

**СОЁЛЫН ӨВИЙН ТӨВИЙН 2017 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар
2017 он

БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭХ АНГИ-1. БИЕТ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ХЭЛТСИЙН СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫГ ХАНГАХАД ЧИГЛЭСЭН АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ

1.1. Соёлын өвийн үзлэг, тооллого зохион байгуулах.

1.1.1. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл буюу улс, аймгийн музейн сан хөмрөгийн улсын тооллогонд зориулсан “Register” програмыг сайжруулах шинэчлэх 2017 оны 1 дүгээр улиралд гүйцэтгэнэ.

I. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан музейн сан хөмрөгийн 4 жил тутмын улсын тооллогын бэлтгэх ажлыг хангахаар “Register” програмын сайжруулалтыг хийж бэлэн болгоод байна.

Энэхүү бүртгэлийн програмыг зохиогч “Сайбер-Андромеда ХХК-тай 2017 оны 11 дүгээр сарын 24нд гэрээ (Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 -р зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн) байгуулж, бодлогын даалгавар боловсруулан ажилласан. Музей-хэрэглэгчээс ирүүлсэн саналуудыг тусган уг програмын ажиллагааг боловсронгуй болгоход дараах 2 чиглэлээр 25 төрлийн шинэчлэлт сайжруулалт хийгдсэн. Үүнд:

1-рт: “Register” програмын ажиллагааг боловсронгуй болгох сайжруулалт

№	Дурсгалын жагсаалт дээр
1	Гэрэл зураг гардаг байх
2	Grid нь Developer Express-ийнх байна. Sum нь гардаг. Filter-ийг custom-oop хийдэг.
3	Хайлтын үр дүнд хэсэг дурсгалууд гаргаад, нэг нэгээр нь дэлгэрэнгүй үзэх гэхээр дахиж хайлт хийхээс өөр аргагүй болоод байгааг засах.
4	Сонгосон дурсгалыг edit цонхруу орохгүйгээр View хийдэг болох.
5	Хайлтын үр дүнгээс нэг дурсгал руу ороод, буцахад лист дээр хайлтын үр дүн хадгалагдаж үлдэх.
6	Сан хөмрөгийн байршил /нүүр хэсэгт гаргах/
7	Дурсгал бүртгэх хэсэг
8	Дутагдсан, Солигдсон, Алдагдсан үзмэр, эд өлгийн зүйлийн бүртгэл
9	Гэрэл зургийн хэмжээ
10	“Б. Тодорхойлолт” Иж бүрдэл үзмэрийн бүрэлдэхүүний хэсгийн нийт тоо ширхэг нь excel-рүү хөрвөж гарахдаа В. Ялгагдах онцлог хэсэгт бичигдсэн текстийн дээр гарч ирж байна. Үүнийг доор нь гаргадаг болгох.
	Хэвлэх
11	Холбогдох нэр, газар, онцлог А. Бүтээсэн /холбогдох он цаг хэсгээс сонголт хийж excel-рүү хөрвүүлэхэд сонголт нь давхар гарч ирж байна./ Б. Хэрэглэж байсан В. Цуглуулсан гэх хүснэгтүүд EXCEL-рүү хөрвөхөд Б-хэсэгт бичигдсэн текст хоёр хуулагдаж гарч байна.
12	Хайлтын үр дүнг гэрэл зурагтай жагсаалтаар хэвлэх (Хэвлэх форматыг бэлтгэж өгнө)

13	Тайлан хэсэгт нэмэлт өөрчлөлт хийх. “Төрөл зүйлийн тоон дүн” гаргасаны дараа давхар “он цагийн тоон дүн” гаргахад өмнөх нь лист дээр давхар хадгалагдаж үлдэх. Одоо гарж байгаа үр дүн нь аль нэгийг нь сонгоход өмнөх гаргасан үр дүн нь алга болж буцааж дуудахад дахин ачаалж байна.
14	Хэвлэх командыг илүү өргөн боломжтой болгох. Хэвлэх команд хуудасны тоог гараас өгөх сонголттой байх. Мөн үр дүн байхгүй утга аваагүй хэсгүүдийг хасаж хэвлэдэг байх. /Жич: PDF болгон хадгаладаг командыг тэр бүр хүмүүс мэдэхгүй ашиглаж чадахгүй асуудал их гарсан./
	Хэрэглэгч
15	Хэрэглэгч бүртгэхдээ и-мэйл оруулах ба нууц үгээ мартсан бол имэйл-ээр сэргээж авах боломжтой байх.
16	Admin нь хэрэглэгчийн нууц үгийг RESET хийдэг байх. Харж, засаж болохгүй.
17	Нэмэлт болон өөрчлөлтийг турших, тестлэх
18	Өөрчлөлтийг програмын update болгон хүргэх

2-рт: Музейн сан хөмрөгийн улсын тооллогын ажлын автоматжуулалт, цахим бүртгэлийн сайжруулалт хийгдсэн. Үүнд:

№	Дурсгалын жагсаалт дээр
1	Тооллого явуулж байгаа огноо болон мэдээллийн уншиж, хэвлэсэн материалтай тулгаж үзээд “Тоолов” товчийг дарж баталгаажуулна. Тоологдсон огноо болон бусад мэдээлэл автоматаар хадгалагдана.
	Тайлагнах процесс
2	Тооллогын явцын талаарх тоон дүн мэдээ гарч байх боломжтой болно.
3	Тооллогын явцын мэдээллүүд сервер дээр нэгтгэн хадгална
4	СӨҮТ дээр нэгтгэгдсний дараа сүлжээнд ажиллах боломжтой байх.
5	Бүх музейнүүдийн бүртгэлийн бааз нь автоматаар нэгтгэгдэх
6	Тооллогын явцын тайланг чарт хэлбэрээр вэб сайтаар live/бодит цаг хугацаанд/ гаргана.
7	Музей тус бүрээр, мөн улсын хэмжээний тооллогын ажлын явцын мэдээллийг авах боломжтой болно.

Энэхүү “Register” програмын өмнөх хувилбарын дутагдлыг засаж сайжруулан шинэчлэлт хийгдсэн ба цаашдаа “RCH” бүртгэлийн програмтай холбох, мэдээллийг нэгтгэх бэлтгэл ажил болох юм.

“Register” програмын сайжруулсан хувилбарыг музейн сан хөмрөгийн улсын тооллого эхлэх үед update хийж музейнүүдэд тараан суурилуулна.

II. Тооллогын бэлтгэл ажлын хүрээнд музейнүүдээс 2017 оны II-III улиралд дутагдсан, солигдсон маргаантай үзмэрийн тоон судалгааг авсан тухай.

2017 оны III улиралд алдагдсан, дутагдсан, солигдсон үзмэр, эд өлгийн судалгааг авахаар улсын болон аймаг орон нутгийн нийт 40 музейд үндэсний төвийн захирлын

2017 оны 198 тоот албан бичиг хүргүүлж хариуг цаасан болон цахим хэлбэрээр авч нэгтгэх ажлыг хийлээ.

Монгол төрийн түүхийн музей, Хархорум музей, Хөшөө цайдам музей, Говьсүмбэр аймгийн музей, Данзанравжаагийн музей, Монгол банкны Эрдэнэсийн сан, Түүх, археологийн хүрээлэн, Геологи, палеонтологийн хүрээлэн зэрэг 8 байгууллага “алдагдсан үзмэр байхгүй” гэсэн хариу ирүүлсэн.

Судалгаанд 32 музейгээс нийт алдагдсан, дутагдсан, солигдсон 1670 дэсийн үзмэрийн жагсаалт ирүүлснээс эхний байдлаар дахин нягтлах ёстой 949 дэсийн үзмэрийн тоон дүнг оруулаад байна. Жагсаалтыг тоон дүнг хүснэгтээр харуулбал:

№	Музейн нэр	Судалгаагаар ирүүлсэн нийт үзмэрийн тоон дүн	Дахин нягтлах ёстой тоон дүн	Тайлбар
1	Монголын үндэсний музей	422	364	Сан хөмрөгч Б.Энхбаттай холбоотой гарсан жагсаалтаас олдсон эд зүйлийг хаслаа.
2	Байгалийн түүхийн музей	60	60	
3	Богд хааны ордон музей	9	9	
4	Дүрслэх урлагийн музей	31	26	2008 оны тооллогоор дутагдсан үзмэрийн жагсаалтад орсон үзмэрээс 5 үзмэр давхар бичигдсэнийг хасав.
5	Чойжин ламын сүм музей	22	22	
6	Уран зургийн галерей	68	23	2008 оны тооллогоор дутагдсан үзмэрийн жагсаалтад оруулсан боловч музей бүртгэлд байхгүй үзмэрийг хасав.
7	Монголын театрын музей	30	30	
8	Монгол цэргийн музей	27	27	
9	Үндэсний номын сан	1	1	
10	Улаанбаатар хотын музей	2	2	
11	Архангай аймгийн музей	4	4	
12	Баян-Өлгий аймгийн музей	10		Давхардуулан бичсэн үзмэрийн давхардлыг арилгасан байна.
13	Баянхонгор аймгийн музей	5	5	
14	Булган аймгийн музей	97		1996 онд сан хөмрөгчөөс дутсан. 1997 онд музейн захирлын тушаалаар төлүүлсэн, сум дундын шүүхээр шийдвэрлэгдсэн.
15	Говь-Алтай аймгийн музей	111		БСГ-ын даргын 2005.5.18-ны №26 албан шийдвэрийг үндэслэн хассан
16	Дархан-Уул аймгийн музей	7	7	
17	Дорноговь аймгийн музей	1		чихмэл
18	Дорнод аймгийн музей	68		ИТХТэргүүлэгчдийн 2010 оны 30 дугаар тогтоолоор данснаас хассан байна.
19	Дорнод. Ялалтын музей	1	1	
20	Дундговь аймгийн музей	16		Шийдвэрлэсэн
21	Завхан аймгийн музей	103	15	Шүүхийн шийдвэрээр төлөгдсөнийг хасаад, байгууллагын даргын шийдвэрээр төлөгдсөнийг

22	Орхон аймгийн музей	4		1 үзмэрийг төлүүлсэн. Музейгээс Зохиолч Д.Даржаагийн үнэмлэх эд зүйлийг гэр бүлд нь өгсөн байна.
23	Өвөрхангай аймгийн музей	106		Музейн ЕБД бичигдээгүй
24	Өмнөговь аймгийн музей	2	2	
25	Сүхбаатар аймгийн музей	8	1	
26	Сэлэнгэ аймгийн музей	67	67	
27	Төв аймгийн музей	99	13	Музейн саналаар цагдаагийн байгууллагаар шийдвэрлэгдсэн үзмэрийг хассан.
28	Увс аймгийн музей	55	55	
29	Ховд аймгийн музей	42	23	Музейн ЕБД бичигдээгүй үзмэрийг хаслаа
30	Хөвсгөл аймгийн музей	150	150	
31	Хэнтий аймгийн музей	6	3	Олдсон 3 үзмэрийг хаслаа.
32	Эрдэнэ зуу музей	36	36	Дутагдсан болон солигдсон үзмэр
33	Палеонтологийн төв		3	Палеонтологийн төвөөс хосгүй үнэт дурсгалд санал болгож батлуулсан Тарбозавр, Сегнозавр, Ахиллобаторын бүрэн бус араг яс алдагдсан
	Нийт	1670	949	

Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэлийн цахим хувилбар “Register” бүртгэлийн програмын шинэчлэлт сайжруулалтаар Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2012 оны №А/355 тоот албан тушаалаар батлагдсан “Музейн сан хөмрөгийг бүртгэх баримтжуулах заавар”-ын ББЗМаягт № 46 ба 49 дүгээрх “Дутагдсан, Солигдсон үзмэр, эд өлгийн зүйлийн жагсаалт”-ыг уг програмд нэмэлт талбар болгон оруулсан. Ингэснээр тухайн музейгээс алдагдсан, дутагдсан үзмэрийн талаарх тодорхойлолт мэдээлэл болон олдсон, эс олдсон нь бүртгэгдэж, тухайн музейн алдагдсан дутагдсан, солигдсон тухай мэдээлэл цэгцрэгдэх юм.

1.2. Дэлхийн өв-Монгол Алтай хадны зургийг бүртгэх, газар зүйн мэдээллийн сан GIS-д оруулах урьдчилсан судалгаа хийх.






1.2.1. Баян-Өлгий аймаг дахь Дэлхийн өв-Монгол Алтай хадны зургийг бүртгэх, газар зүйн мэдээллийн сан GIS-д оруулах урьдчилсан судалгааг Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн музей, бусад байгууллагуудтай хамтран 2017 оны 7 ба 8 дугаар саруудад хийх. Монгол Алтайн нурууны хадны зургийн дурсгалт газар нь соёлын ангиллаар (2011 он) дэлхийн өвд бүртгэгдсэн дурсгалт газар бөгөөд Соёлын өвийг хамгаалах хуулийн 42.3-т

Соёлын өвийн дурсгалт газарт үндэсний болон дэлхийн өвийн дурсгалт газар хамаарна хэмээн заасан байдаг.

Соёлын өвийн төвөөс 2017 онд Монгол Алтайн нурууны хадны зургийн хадгалалт хамгаалалтыг сурталчилгаагаар дамжуулан сайжруулах. Орон нутгийн иргэдийн соёлын өвийн боловсролыг дээшлүүлэх, олон нийтэд Монгол Алтайн хадны зургийг хүртээмжтэй байдлаар цахим орчинд сурталчлах ажлыг хийхээр төлөвлөсөн билээ.

Тус дурсгалт газрыг 2011 онд Францын нийслэл Парис хотноо болсон ЮНЕСКО-гийн Дэлхийн өвийн хорооны 35 дугаар чуулганаар дэлхийн өвд бүртгэсэн. Монгол Алтайн нурууны хадны зургийн цогцолбор 12000 жилийн тэртээгээс хүн төрөлхтний соёлын хөгжлийг харуулсан олон хадны зураг, булшны хөшөө байдаг гурван газраас (Цагаан салаа/Бага Ойгор, Цагаан голын эх, Арал толгой) бүрддэг. Хамгийн эртний сүг зургууд нь (МЭӨ 11,000 - 6,000) том ан гөрөөс агнадаг хөндий ба шигүү ой модыг дүрсэлсэн байдаг. Хожмын үеийн зургууд нь мал маллаж амьдрах хэв маяг зонхилж эхэлж буйг харуулсан бол Хүннү (МЭӨ I зуун), Түрэгийн үеийн (МЭ VII-VIII зуун) зургуудад адуунаас хамааралтай нүүдэлчин амьдралын хэв маягт шилжиж буйг дүрсэлжээ. Хадны сүг зургууд нь эрт дээр үеэс Төв болон Хойд Азид оршин амьдарч байсан олон үндэстэн, ястныг судлахад үнэтэй хувь нэмэр оруулдаг хэмээн үздэг байна.

1993 – 2004 онд Монгол-Америк-Оросын хамтарсан “Алтай” төслийн багийнхан тус аймгийн Хар ямаат, Цагаан салаа, Бага ойгур, Хар ус, Цагаан ус, Шивээт хайрхан, Хар чулуу, Их Бага хагийн гол, Хагийн нуур, Арал толгой зэрэг газруудаас шинэ чулуун зэвсгийн үеэс өнөөг хүртэлх олон тооны хадны зургийг илрүүлэн судалж, олон тооны эрдэм шинжилгээний өгүүлэл, нэгэн сэдэвт зохиол, бүтээлийг хэвлүүлжээ.




Тухайлбал, дөрвөн

нэгэн сэдэвт зохиол бүхий 6 боть ном туурвиснаас [Jacobson, Kubarev, Tseveendorj, 2001; Jacobson, Kubarev, Tseveendorj, 2006] тус бүр хоёр боть хоёр бүтээлийг Франц улсад "Төв Азийн хадны зураг" хэмээх олон улсын төслийн хүрээнд нийтлүүлсэн бөгөөд Оросын судлаачдад зориулан нэмэн баяжуулсан нэгэн сэдэвт зохиолыг ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Археологи, Угсаатны зүйн хүрээлэнгийн хэвлэх үйлдвэрт



Оросын нийгмийн шинжлэх ухааны фондын дэмжлэгтэйгээр хэвлэн гаргасан [Кубарев, Цэвээндорж, Якобсон, 2005]. Харин монгол хэл дээр “Арал толгойн хадны зураг” [2005], “Шивээт хайрханы хадны зураг [2010]” хэмээх номыг Монгол Улсын ШУА-ийн Археологийн хүрээлэнгээс нийтэлсэн байна [Цэвээндорж, Кубарев, Якобсон, 2005; Цэвээндорж, Кубарев, Якобсон, 2010].

Бид юуны өмнө тухайн дурсгалт газрын талаар хэвлэгдсэн судалгааны зохиолууд болон эрдэм шинжилгээний өгүүлэл зэрэгтэй танилцсан болно. Гэвч дээрх бүтээлүүдэд голчлон археологийн шинжлэх ухааны үүднээс хадны зургийн дүр дүрслэл, хийсэн арга барил зэрэгт түлхүү анхаарч үзсэн байх бөгөөд газар зүйн байршлын зургийг нарийн хийсэн хэдий ч газар зүйн солбицол зэргийг огт тэмдэглээгүй байв. Тиймээс бид эхний удаа ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн судлаачдаас энэ талаар лавласан боловч тодорхой хариу аваагүй юм. Харин энэ дурсгалт газруудад судалгаа хийсэн АНУ-ын судлаачидтай холбогдох хэрэгтэй талаар зөвлөсөн болно.

Энэ дагуу Ориганы Их сургуулийн судлаач Естер Жейкобсон-Терфер-д хандсан и-мэйл явуулсан боловч, энэ тухай мэдээлэл Монголын албаны зарим хүмүүст байгаа гэдгийг дурдаад доорх <https://oregondigital.org/sets/maic>, <https://mongolianaltai.uoregon.edu/index.php> цахим хуудаснуудаас мэдээлэл авахыг зөвлөсөн хариу ирүүлсэн болно. Иймд бид <http://whc.unesco.org/> хуудсанд байгаа байр зүйн зургийг болон Дэлхийн өвд бүртгүүлэхэд боловсруулсан баримт бичигт байгаа газрын зургаас дурсгалт газруудын байрлалыг баримжаалан ажиллахаар төлөвлөв.



Хээрийн бүртгэлийн ажил: 2017 оны 7 дугаар сарын 19-ноос 8 дугаар сарын 6-ныг хүртэл 19 хоногийн хугацаанд түүх, соёлын үл хөдлөх дурсгал хариуцсан мэргэжилтэй Г.Анхсанаа, техник хариуцсан мэргэжилтэн П.Чинбат, програмист Ж.Даваацэрэн, сэргээн засварлах хэлтсийн дарга Д.Нямдорж, сэргээн засварлагч А.Мөнгөнцоож, төвийн гэрээт ажилтан Г.Халиунаа болон Баян-Өлгий аймгийн музейн эрдэм шинжилгээний ажилтан Ж.Айнур, бүртгэл, мэдээллийн санч И.Эркабулан нарын бүрэлдэхүүнтэй ажиллаа.




Өмнө дурдсанчилан Монгол Алтайн нурууны хадны зургийн цогцолбор дурсгал нь Баян-Өлгий аймгийн Улаанхус, Цэнгэл сумдын нутагт нийт 11300 га талбайг эзлэн 3

хэсэг газарт орших бөгөөд эхний удаад дээрх гурваас дундаж хэмжээтэй Цагаан салаа/Бага ойгорын орчимд ажиллав.

Цагаан салаа/Бага ойгорын хадны зургийн дурсгалт газар нь аймгийн төвөөс баруун хойш 140 км орчим зайд орших бөгөөд үндсэн талбай 2100 га, хамгаалалтын бүс 3600 га, нийт 5700 га талбайг хамарна. Нийт хадны зургийг Цагаан салаа 1-5, Бага ойгор 1-5 гэсэн 10 хэсэг болгон хувааж тэмдэглэсэн байна.


Бидэнд олдсон хэрэглэгдэхүүнд Цагаан салаа/Бага ойгорын дурсгалт газрын байршлыг тэмдэглэсэн нэг солбицол тэмдэглэгдсэн байх бөгөөд тус цэгийн байрлал өмнөх судалгааны бүтээлүүдэд тэмдэглэгдсэн Цагаан салаа (TS-V) орчимд байв. Дээрх цэгээр баримжаалан хадны зургийн 10 хэсгийг хамруулан нийт 23 газрын хадны зургийн баримтжуулалтыг хийв.

Эндээс бид дараагийн дурсгалт газар болох Цагаан гол буюу судалгааны ном зохиолд Шивээт хайрхан хэмээн нэрлэгдсэн дурсгалт газрыг зорьсон юм. Тус дурсгал Цэнгэл сумын төв Хөшөөт суурингаас 80 орчим км зайд орших бөгөөд үндсэн талбай 9,000 га, хамгаалалтын бүс 6,300 га, нийт 15,300 га талбайг хамарна. Бидэнд байгаа зурагт энэ дурсгалт газрын хадны зургийг TS 1-14, TG 1-13, SK 1-10, KS 1-3 гэсэн нийт 40 хэсэгт бүлэглэн хуваасан байна. Тиймээс бид юуны өмнө энэ орчмын газрын байдал, хэмжээг баримжаалах үүднээс Шивээт хайрхан уулын өмнө талд орших олон хадны зураг бүхий хавтан орчимд солбицол авч, том хавтан дээрх зургийг хуулбарлаж авлаа. Мөн Шивээт хайрханы урдуур тойрон баруун талд гарч солбилцол авч хоноглов. Энд нийт 3 газар солбицол авч, 5 газраас панорам хийлээ. Дээрх собицолыг газар зүйн мэдээллийн системд оруулахад эхний цэг SK-5, дараагийн цэг TS-2, сүүлийн цэг TS-1 орчимд байв.



Дараагийн дурсгалт газар болох Арал толгой нь Цэнгэл сумын төв Хөшөөт сууринаас 150 орчим км зайд, хилийн заставийн орчим байрлана. Арал толгойн

дурсгалт газар нь үндсэн талбай 200 га, хамгаалалтын бүс 800 га, нийт 1000 га бөгөөд хамгийн бага талбайг хамарна. Энд нийт 25 хэсэг газар хадны зураг тэмдэглэгдсэн байна. Бид энэ удаа Арал толгойн зүүн талаас нь самнан өгсөж дээрх хадны зургийн ихэнх хэсгийг илрүүлэн гэрэл зургаар баримтжуулан авав. Мөн 5 хэсэгт панорам хийлээ.



Бид тус аймгийн Улаан хус сумын нутаг Цагаан салаа, Бага ойгор, Цэнгэл сумын нутаг Шивээт хайрхан, Арал толгой гэсэн маршрутаар 1000 орчим км аялж нийт дээрх гурван дурсгалт газарт 36 солбицол тогтоож, 33 панорам (Цагаан салаа/Бага ойгор 23, Шивээт хайрхан 5, Арал толгой 5), болон Хар Ямаат, Дан баатрын хөшөө, Битүү, Харгайтын хүн чулуу зэрэг улс, аймгийн хамгаалтад байх дурсгалуудыг 124 GB гэрэл зураг, хоёр хуулбар зураг, photoscan зэргээр баримтжуулалт хийв.

Мөн Улсын хамгаалтад байх Улаан хус сумын нутагт орших Хар Ямаатын хүн чулуун хөшөө, Цэнгэл сумын нутагт орших Даян Баатарын хөшөө хэмээн хүн чулуунд эвдрэл гэмтлийн судалгаа хийж, анхан шатны цэвэрлэгээ хийв.

Мөн орон нутгийн холбогдох хүмүүсийг судалгааны ажилдаа татан оролцуулж газар дээр нь мэргэжлийн заавар, зөвлөгөө өгч бүртгэлийн ажлын арга зүйгээр хангаж ажиллалаа.

Энэ удаагийн хээрийн бүртгэлийн ажлаар бид төлөвлөсөн хуваарийн дагуу Цагаан салаа/ Бага ойгор, Арал толгойн дурсгалт газрын газар зүйн мэдээллийн санг болон цаашид ашиглах гэрэл зургийн санг бүрдүүллээ. Мөн тухайн дурсгалт газруудын байгаль, газар зүйн талаарх төсөөлөлтэй боллоо.

Дээрх хуримтлуулсан мэдээллийг эмхлэн цэгцэлж, улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хадгалсан болно.

1.3. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалд нөлөөлөх байгаль, хүн нийгмийн хүчин зүйлийн эрсдлийн судалгаа.

1.3.1. Монгол орны нутаг дэвсгэр дэх хөдөө хээр оршиж буй түүх, соёлын үл хөдлөх дурсгалд нөлөөлж буй байгаль, хүн нийгмийн хүчин зүйлийн нөлөөллүүд, эрсдлийг тогтооно.

Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд (СӨУНБМС) цуглагдсан түүх, соёлын үл хөдлөх дурсгал мэдээллүүдээс орон зайн мэдээлэл “хомс” байдаг нь Газар зүйн мэдээллийн системд суурилсан судалгаа хийх, цаашлаад соёлын өвийг хамгаалах оновчтой бодлого шийдвэр гаргахад хүндрэл учруулдаг. Мөн орон нутагт соёлын өвийг хамгаалахаар ажиллаж байгаа “хүмүүс”-ийн соёлын өвийг таньж тогтоох, бүртгэх болон хэрхэн хамгаалах тухай мэдлэг хангалтгүй байсаар байна.

Тиймээс Соёлын өвийг хамгаалагчдад зориулсан Монголын соёлын өвийн хадгалалт хамгаалалтад нөлөөлж буй хүчин зүйлсийн газарзүйн зурагт лавлах боловсруулах, мэдээллийн санг бий болгох ажлыг хийж гүйцэтгэв. Энэ зорилгын хүрээнд дор дурдсан зорилтот ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. СӨУНБМСанд цуглагдсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалын орон зайн мэдээллийн сан бий болгов.

2. Соёлын өвийн хадгалалт хамгаалалтад сөргөөр нөлөөлж буй байгаль, нийгмийн хүчин зүйлсийг тодорхойлж газрын зурагт буулгав.
3. Монголын соёлын өвийн хадгалалт хамгаалалтад нөлөөлж буй хүчин зүйлсийн газарзүйн зурагт лавлах ном боловсруулж, хэвлэв.

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын орон зайн мэдээлэл бүхий мэдээллийн сан бий болгох

- Соёлын өвийн үндэсний төвөөс 2008-2014 онд 15 аймгийн нутагт бүртгэл хийсэн 32000 дурсгалын мэдээлэл,
- 2015 онд Улс орон даяар зохион байгуулагдсан үзлэг тооллогоор Нийслэл хот, 21 аймгийн 301 сумын нутаг дахь 9537 дурсгалт газрын 86157 дурсгалын мэдээлэл,
- Соёлын өвийн үндэсний төвд хадгалагдаж байгаа мэргэжлийн судалгааны 7 байгууллагын эрдэм шинжилгээний болон авран хамгаалах ажлын 2008-2014 оны 562 тайлангаас 18592 дурсгалыг мэдээлэл файл хэлбэрт оруулав.

Судалгааны ажлын танилцуулга, үйл явц, түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хамгаалалтад нөлөөлж буй эрсдэлийг тодорхойлох, эрсдэлийн үнэлгээг хэрхэн гаргах тухай судлаач, зөвлөхүүдийн саналыг авах зорилгоор нийт 11 удаагийн тусгайлсан зөвлөлдөх уулзалтыг давхардсан тоогоор 74 эрдэмтэн, судлаачдыг хамруулан зохион байгуулсан.

Салбарын эрдэмтэн судлаачдаас шүүмж, зөвлөгөө авах уулзалтаас гадна орон нутгийн музей, соёлын мэргэжилтэн, байгаль хамгаалагч, мэргэжлийн хяналтын байцаагч мөн эрдэм шинжилгээний байгууллагуудаас санал асуулга авч үнэлгээ дүгнэлтийг нь тусгасан болно. Үүнд:

- 21 аймгийн музейн эрдэм шинжилгээний ажилтан, бүртгэл мэдээллийн санч,
- 21 аймгийн соёлын асуудал хариуцсан мэргэжилтэн,
- 21 аймгийн байгаль хамгаалагч, мэргэжлийн хяналтын байцаагч
- 13 их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын эрдэм шинжилгээний ажилтан нийт холбогдох салбарын 150 гаруй мэргэжилтнийг хамруулсан болно.

Тус ажлын хүрээнд бид дараах байдалаар шууд үр дүнг гаргалаа.

1. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын 7 төрөл тус бүрийн төрөлжсөн эрсдэлийн зургуудыг давхцуулан “Эрсдэлийн нэгдсэн зураг”-ийг боловсруулахад дараах үр дүн гарав. Үүнд:
 - Үл хөдлөх дурсгалд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсийн эрсдэлийн нэгдсэн үнэлгээнээс тооцоолоход, Монгол улсын нийт 1574533 км² газар нутгийн хэмжээнд **их эрсдэл** учруулах 8942 км² талбай буюу газар нутгийн 0.56%, **дунд эрсдэл** учруулах 112195 км² талбай буюу газар нутгийн 7.1%, **бага эрсдэл** учруулах 489430 км² талбай буюу газар нутгийн 31% -ийг эзлэж байгаа бол, **маш бага эрсдэлтэй** газар нутаг нь 963966 км² талбай буюу газар нутгийн 61.2% байна.
2. Эрсдэлийн үнэлгээг аймаг тус бүрээр нь ангилахад түүх, соёлын үл хөдлөх дурсгалд хамгийн их эрсдэл учруулах газар нутгийн хэмжээгээр Орхон аймаг 238км² буюу газар нутгийнх нь 28.3%, Дархан-Уул аймаг 206 км² буюу газар нутгийнх нь 6.3%, Баян-Өлгий аймаг 890км² буюу газар нутгийнх нь 1.9%, Увс аймаг 929 км² буюу газар нутгийнх нь 1.3%-иар тус тус оржээ. Харин түүх, соёлын үл хөдлөх дурсгалд маш бага эрсдэл учруулах газар нутгийн хэмжээгээр Баянхонгор аймгийн газар нутгийн 74% нь буюу 85600км², Говь-алтай аймаг газар нутгийнхаа 71% буюу 102080км²–ээр тус тус орсон байна.

3. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл, мэдээллийн санд буй 24431 дурсгалаас судалгааны үр дүнд эрсдэлийн үнэлгээгээр Их, Дунд, Бага, Маш бага эрсдэлтэй газар нутагт буй дурсгалын статистик тоон дүн дараах байдлаар илэрхийлэгдэн гарлаа. Үүнд:

Эрсдлийн зэрэг	Чулуун зэвэг, үйлдвэрлэлийн үл мөр хадгалсан дурсгалт газар	Хадны зураг, бичгийн дурсгал	Булш оршуулгын дурсгал	Сүм хийд, уран барилгын дурсгал	Эртний хот, сүм хийдийн туурь, балгас	Хөшөө дурсгал (тахил тайлгын байгууламж)	Палеонтологийн дурсгалт газар	Нийт дурсгалын тоо
Их эрсдэлтэй	11 (3,0 %)	17 (1,3%)	91 (0,6%)	28 (3,7%)	12 (3,0%)	28 (0,5%)	0	187 (0,8%)
Дунд эрсдэлтэй	58 (14,0 %)	99 (7,3%)	2361 (14,3%)	108 (13,9%)	45 (11,2%)	371 (7,4%)	1 (2,3%)	3043 (12,5%)
Бага эрсдэлтэй	146 (36,0%)	300 (22,2%)	7377 (45,0%)	216 (27,8%)	125 (31,0%)	1182 (23,5%)	14 (31,7%)	9360 (38,2%)
Маш бага эрсдэлтэй	189 (47,0%)	934 (69,2%)	6592 (40,1%)	423 (54,6%)	221 (54,8%)	3453 (68,6%)	29 (66,0%)	11841 (48,5%)
Нийт	404	1350	16421	775	403	5034	44	24431

4. Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалл сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсийн эрсдлийн үнэлгээгээр ИХ ЭРСДЭЛ учруулах хүчин зүйлд, ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл, суурьшлын бүстэй ойр үед хүмүүсийн үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл, авто болон төмөр замын бүтээн байгуулалтын үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл, ДУНД ЭРСДЭЛ учруулах хүчин зүйлд, ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл, улсын чанартай замаар зорчиж буй хүмүүсийн үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл, БАГА ЭРСДЭЛД орон нутгийн замтай ойр үед эрсдэл учруулах тохиолдлууд ажиглагдаж байна.

5. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл, мэдээллийн санд буй 24431 дурсгалаас Их эрсдэлтэй бүс нутагт 187 дурсгал буюу нийт дурсгалын 0,8%, Дунд эрсдэлтэй бүс нутагт 3043 дурсгал буюу нийт дурсгалын 12,5%, Бага эрсдэлтэй бүс нутагт 9360 дурсгал буюу нийт дурсгалын 38,2%, Маш бага эрсдэлтэй бүс нутагт 11841 дурсгал буюу нийт дурсгалын 48,5% нь байрлаж байгаа судалгааны үр дүн гарч байна.

Эдгээр үр дүнг дараах байдлаар олон нийтэд хүргэлээ. Үүнд

1. “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын лавлах”,
2. “Соёлын өвийн эрсдэлийн атлас” бүтээлүүдийг шийдвэр гаргагч эрх бүхий байгууллага, соёлын өвийн шат, шатны бүртгэл, мэдээллийн сангийн ажилтнууд болон соёлын өвийг “хамгаалагчид”-д түгээх зорилгоор тус бүр 300 ширхэг хэвлэсэн болно.

Эдгээр бүтээлийн ашигласнаар Соёлын өвийн мэргэжилтнүүдийн газар мэдээллийн системийн тухай мэдлэг ойлголт дээшилж газар зүйн мэдээллийн системийн ArcGIS програм ашиглан мэдээллийн сан үүсгэх, олон төрлийн орон зайн боловсруулалт хийх чадвартай болох нь цаашдын соёлын өвийн судалгааны ажилд чухал ач холбогдолтой юм.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн Зайнаас Тандан Судлалын Төв, Ашигт малтмал, газрын тосны газар зэрэг төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, мэдээлэл солилцох байдал сайжирсан болно.

1.4. Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалуудыг видео болон 3D хэмжээсээр бүртгэн баримтжуулах.

1.4.1. Өвөрхангай аймгийн Эрдэнэ Зуу музейн түүх, соёлын хосгүй үнэт 93 ширхэг дурсгалыг 2017 оны II улиралд.

Өмнөх онд хийгдсэн түүх, соёлын хосгүй үнэт дурсгалуудыг дүрс бичлэгээр бүртгэн баримтжуулах ажлыг үргэлжүүлэн хийж гүйцэтгэж байна. Эхний II улиралд Эрдэнэ Зуу музейд ажиллахын сацуу Хархорум музей дэх хосгүй үнэт дурсгалуудыг дүрс бичлэгээр бүртгэн баримтжуулах ажлыг хийлээ.

Эрдэнэ Зуу музейн сан хөмрөг дэх хосгүй үнэт дурсгалуудыг дүрс бичлэгээр баримтжуулах ажлыг 2017 оны 4 дүгээр сарын 20-нээс 5 дугаар сарын 3-ныг дуустал хугацаанд Соёлын өвийн төвийн Соёлын биет өвийг хамгаалах хэлтсийн дарга Д.Нарантуяа, хэлтсийн мэргэжилтэн П.Чинбат, Соёлын биет бус өвийг хамгаалах хэлтсийн зураглаач Т.Даваа-Очир нар, Хархорум музейн хосгүй үнэт дурсгалуудыг дүрс бичлэгээр баримтжуулахад 2017 оны 5 дугаар сарын 04-нээс 10-ныг дуустал хугацаанд Соёлын биет өвийг хамгаалах хэлтсийн мэргэжилтэн Ш.Энхтуяа, П.Чинбат, зураглаач Т.Даваа-Очир, жолоочоор С. Сайнзолбоо нар тус тус хийж гүйцэтгэлээ.

Эрдэнэ зуу музейн түүх, соёлын хосгүй үнэт дурсгалуудыг дүрс бичлэгээр баримтжуулсан тухай:

Засгийн газрын шийдвэрээр 2000-2013 онуудад Монгол Улсын түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалтад батлагдсан Засгийн газрын шийдвэрээр 2000-2013 онуудад Эрдэнэ зуу музейн сан хөмрөг дэх 93 дурсгал (120 ширхэг) Монгол Улсын түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлээр батлагдсан.

Хосгүй үнэт дурсгалуудыг дүрс бичлэгээр баримтжуулахад хоёр байгууллагын хамтарсан ажлын гэрээг байгуулсан ба ажлын үеэр өдөр тутмын тэмдэглэл хөтлөв. Тус музейн сан хөмрөгч Д.Наранцацрал, Бүртгэл, мэдээллийн санч Ш.Сайзмаа нар хамтран ажиллалаа.

Цутгуур, хөөмөл зэрэг гурван хэмжээст хосгүй үнэт үзмэрийн нүүрэн тал, ар тал, баруун, зүүн тал, баруун, зүүн хагас хажуу талууд, шүншиг, бад суурины дээд тавцан хэсэг гэсэн талуудын план зургийг авахдаа нэг бүрчлэн 3-4 хэсэгчилсэн деталь зураглалыг тус бүр 15-20 хүртэл секундын хугацаатай дүрс бичлэг хийсэн. Бурханы гар мутарлага, барьц, хөл, хормойн хэсэг, титэм, чимэг зүүлт зэргийг хэсэгчилсэн деталь дүрс бичлэгийг хийв. Танка зураг, зээгт наамал бүтээлүүдэд мөн адил гол бурхан, түүний эргэн тойрон, дээд доод хэсгийн дүрслэлийг нэг бүр хэсэгчилэн дүрс бичлэг хийсэн. Нэг дурсгалд дундажаар 15-20 хүртэл минутийн дүрс бичлэг хийгдсэн. /Хавсралт №1/

№	Эрдэнэ Зуу музейн Хосгүй үнэт дурсгалын нэр, хувийн дугаар,	Батлагдсан ЗГ-ын тогтоол, дугаар	Дүрс бичлэгийн үргэлжлэх хугацаа (мин)
1	Манзушир 65-513, 1/1	ЗГ-ын 2000 оны 175-р тогтоол, №134	81 мин
2	Хаянхирваа 65-541, 1/11	ЗГ-ын 2002 оны 118-р тогтоол, №179	71 мин 30 сек
3	Аюуш 65-04, 1/8-“Б”	ЗГ-ын 2000 оны 175-р тогтоол, №132	24 мин 10 сек
4	Доржсэмбэ 65-03, 1/30	ЗГ-ын 2000 оны 175-р тогтоол, №131	25 мин 46 сек
5	IV Банчэн Богд Лувсанчойжижанцан 65-905, 3/28	ЗГ-ын 2004 оны 108-р тогтоол, №214	51 мин 16 сек
6	Манал 65-919, 1/36	ЗГ-ын 2004 оны 108-р тогтоол, №212	35 мин 7 сек
7	Аюуш 65-309, 1/16	ЗГ-ын 2004 оны 108-р тогтоол, №202	47 мин 56 сек
8	Пагва лам 65-587, 3/72	ЗГ-ын 2004 оны 108-р тогтоол, №216	27 мин 36 сек
9	Балдан барнавын суварга\ -69, 1/06	ЗГ-ын 2004 оны 108-р тогтоол, №217	33 мин
10	Манал 65-589, 1/10	ЗГ-ын 2000 оны 175-р тогтоол, №135	22 мин 50 сек
11	Дэмчиггарав \Доржсэмбэ биш\ 65-02, 1/35	ЗГ-ын 2004 оны 108-р тогтоол, №205	25 мин 42 сек
12	Судар барьсан лам 65-585, 1/12	ЗГ-ын 2002 оны 118-р тогтоол, №180	25 мин 60 сек
13	Жийцэгмаа 65-582, 4/33	ЗГ-ын 2002 оны 118-р тогтоол, №181	20 мин 38 сек
14	Богд лам 65-58, 1/14	ЗГ-ын 2002 оны 118-р тогтоол, №182	19 мин 33 сек
15	Доржсэмбэ \Очирдара биш\ 65-520, 1/20	ЗГ-ын 2004 оны 108-р тогтоол, №201	23 мин 38 сек
16	Ямандаг 65-540, 2/96	ЗГ-ын 2004 оны 108-р тогтоол, №208	33 мин 11 сек
17	Сосорбарам 65-517, 1/75	ЗГ-ын 2004 оны 108-р тогтоол, №208	24 мин 1 сек
18	Ловон Бадамжунай 65-353, 1/64	ЗГ-ын 2004 оны 108-р тогтоол, №213	27 мин 34 сек
19	Бурхан багш 65-350, 2/9	ЗГ-ын 2004 оны 108-р тогтоол, №210	22 мин 35 сек
20	Лхамноржмаа 65-28, 1/9	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №706	18 мин 39 сек
21	Махгал 65-971, 2/64	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №713	22 мин 1 сек
22	Бодь суварга 65-67, 2/57	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №699	20 мин 20 сек
23	Бодь суварга 65-65, 2/55	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №700	21 мин 59 сек
24	Аюуш 65-1015, 2/31	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №715	21 мин 6 сек
25	Богд лам 65-40, 2/69	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №728	21 мин 58 сек
26	Манал 65-920, 1/38	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №705	20 мин 58 сек
27	Төрийн долоон эрдэнийн тахил 65-1162, 1/92	ЗГ-ын 2004 оны 108-р тогтоол, №226	9 мин 43 сек
28	Өлзийт найман тахил 65-1162, 1/92	ЗГ-ын 2004 оны 108-р тогтоол, №227	10 мин 21 сек
29	Бурхан багш 65-1316, 3/32	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №703	22 мин 40 сек
30	Махгал 65-552, 2/141	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №720	22 мин 13 сек
31	Бодь суварга 65-1206, 1/34	ЗГ-ын 2000 оны 175-р тогтоол, №137	21 мин 2 сек
32	Богд лам 65-1195, 1/32	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №722	18 мин 14 сек
33	Богд Зонхов хоёр шавийн хамт 65-406, 4/32	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №702	18 мин 45 сек
34	Богд Зонхов \тусад нь\ 65-406, 4/32		23 мин 47 сек
35	Шавь нь \тусад нь\ 65-406, 4/32		20 мин 16 сек
35	Шавь нь \тусад нь\ 65-406, 4/32		20 мин 16 сек
36	Авид 65-1126, 1/55	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №701	10 мин 27 сек
37	Ногоон дара эх 65-532, 2/165	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №724	9 мин 7 сек
38	Богд Зонхов хоёр шавийн хамт 65-1311, 3/26, 65-1312-2, 3/27, 65-1312-1, 3/27	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №711	18 мин 25 сек
39			16 мин 12 сек
40			17 мин 11 сек
41	Бурхан багш 65-1022, 2/108	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №716	15 мин 40 сек
42	Няндай суварга 65-64, 2/59	ЗГ-ын 2004 оны 108-р тогтоол, №218	12 мин 8 сек
43	Авид 65-491, 2/4	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №712	15 мин 55 сек
44	Бодь суварга 65-68 “А” 3/19	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №726	15 мин 9 сек
45	Рид хувилгааны суварга 65-68 “Б” 3/19	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №726	11 мин 50 сек
46	Тийн ялсан суварга 65-68 “В” 3/19	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №726	13 мин 21 сек
47	Тэнгэрээс буусан суварга 65-68 “Г” 3/19	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №726	13 мин 21 сек
48	Бодь суварга 65-68 “Д” 3/19	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №726	13 мин 3 сек
49	Бодь суварга 65-68 “Е” 3/19	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №726	13 мин 28 сек
50	Бодь суварга 65-68 “Ё” 3/19	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №726	10 мин 48 сек
51	Тийн ялсан суварга 65-997, 2/102	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №714	16 мин 57 сек
52	Бурхан багш 65-60, 1/7	ЗГ-ын 2000 оны 175-р тогтоол, №136	16 мин 17 сек
53	Юм Сэргиймаа 65-01, 1/3	ЗГ-ын 2004 оны 108-р тогтоол, №203	15 мин 7 сек
54	Босоо Майдар 65-59, 2/87	ЗГ-ын 2004 оны 108-р тогтоол, №204	16 мин 37 сек
55	Ногоон дара эх 65-501, 1/4	ЗГ-ын 2000 оны 175-р тогтоол, №133	16 мин 47 сек
56	Өндөр гэгээн 65-348, 2/08	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №721	23 мин
57	Найдан Янлагжун 65-1317, 3-35	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №708	10 мин 28 сек
58	Найдан Мапамба 65-1317, 3-35	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №708	10 мин 28 сек
59	Найдан Нагнанай 65-1317, 3-35	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №708	11 мин 52 сек
60	Найдан Дуйдан 65-1317, 3-35	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №708	9 мин 55 сек
61	Найдан Доржмоийбу 65-1317, 3-35	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №708	9 мин 30 сек
62	Найдан Самбуу 65-1317, 3-35	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №708	10 мин 23 сек
63	Найдан Сэрбэу 65-1317, 3-35	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №708	11 мин 3 сек
64	Найдан Бхарадваза Сэржан 65-1317, 3-35	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №708	12 мин 13 сек
65	Найдан Багула 65-1317, 3-35	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №708	12 мин 38 сек

66	Найдан Дажанзэн 65-1317, 3-35	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №708	13 мин 3 сек
67	Найдан Лампрандан 65-1317, 3-35	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №708	13 мин 38 сек
68	Найдан Бхарадваза Содномлян 65-1317, 3-35	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №708	11 мин 32 сек
69	Найдан Ламдан 65-1317, 3-35	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №708	10 мин 45 сек
70	Найдан Лүийдэ 65-1317, 3-35	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №708	12 мин 18 сек
71	Найдан Бэджэд 65-1317, 3-35	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №708	13 мин 32 сек
72	Найдан Мижэдба 65-1317, 3-35	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №708	13 мин 49 сек
73	Гэндэндармаа 65-1319, 3/34 16 Архадыг цуг авсан зураг	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №709	13 мин 21 сек 1 мин 6 сек
74	Зуу бурхан 65-1331, 3/37	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №710	13 мин 9 сек
75	Махгал 65-566, 2/99	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №704	17 мин 8 сек
76	Балданлхам 65-543, 2/98	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №723	16 мин 38 сек
77	Зуу бурхан 65-1478, 3/88	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №707	17 мин 40 сек
78	Ханд чойжин 65-522, 1/65	ЗГ-ын 2002 оны 118-р тогтоол, №178	14 мин 34 сек
79	Чагши Жанрайсиг 65-490, 2/6, \Шаж биш\	ЗГ-ын 2000 оны 175-р тогтоол, №138	14 мин 17 сек
80	Гомбо гүр 65-1653, 1/170	ЗГ-ын 2000 оны 175-р тогтоол, №130	14 мин 4 сек
81	Сэмбэжэд 65-30-1, 3/22	ЗГ-ын 2004 оны 108-р тогтоол, №219	10 мин 34 сек
82	Сэмбэжэд 65-30-2, 3/22	ЗГ-ын 2004 оны 108-р тогтоол, №220	10 мин 7 сек
83	Сэмбэжэд 65-30-3, 3/22	ЗГ-ын 2004 оны 108-р тогтоол, №221	9 мин 9 сек
84	Сэмбэжэд 65-30-4, 3/22	ЗГ-ын 2004 оны 108-р тогтоол, №222	13 мин 38 сек
85	Сэмбэжэд 65-30-5, 3/22	ЗГ-ын 2004 оны 108-р тогтоол, №223	10 мин 27 сек
86	Сэмбэжэд 65-30-6, 3/22	ЗГ-ын 2004 оны 108-р тогтоол, №224	9 мин 47 сек
87	Сэмбэжэд 65-30-7, 3/22	ЗГ-ын 2004 оны 108-р тогтоол, №225	8 мин 29 сек
88	Очирдара голлосон дүвчинжалбу 84 шидийг үзүүлж буй нь 65-1454, 4/129	ЗГ-ын 2005 оны 116-р тогтоол, №253	14 мин 47 сек
89	Сандуйн жүд 65-1493, 4/108	ЗГ-ын 2013 оны 227-р тогтоол, №775	3 мин 47 сек
90	Гүндсамба 65-1189, 3/241	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №697	3 мин 11 сек
91	Насны гурван бурхан 65-1488, 4/21	ЗГ-ын 2005 оны 116-р тогтоол, №262	4 мин 21 сек
92	Гурван Дээд Амгалант 65-1453, 4/133	ЗГ-ын 2005 оны 116-р тогтоол, №260	6 мин 11 сек
93	Хасарваань Жанрайсиг 16 Архад, 4 Махранз лусын оронд хамтдаа 65-1490, 4/19	ЗГ-ын 2005 оны 116-р тогтоол, №257	8 мин 31 сек
94	Бурхан багшийн 12 зохионгуй 65-1527, 4/18	ЗГ-ын 2005 оны 116-р тогтоол, №258	19 мин 39 сек
95	Цогт Охин тэнгэр 65-1482, 4/127	ЗГ-ын 2005 оны 116-р тогтоол, №255	7 мин 45 сек
96	Цагаан Итгэл 65-713, 4/136	ЗГ-ын 2005 оны 116-р тогтоол, №264	5 мин 34 сек
97	Дарагшид Гомбо 65-1425, 4/138	ЗГ-ын 2005 оны 116-р тогтоол, №254	4 мин 26 сек
98	Зургаан мутарт Итгэл 65-713, 4/135	ЗГ-ын 2005 оны 116-р тогтоол, №263	4 мин 11 сек
99	Пунцаггүсэм 65-1522, 4/107	ЗГ-ын 2000 оны 175-р тогтоол, №139	9 мин 33 сек
100	Бурхан багшийн 15 рид хувилгаан 65-1489, 4/17	ЗГ-ын 2005 оны 116-р тогтоол, №259	12 мин 56 сек
101	Гадаад, Дотоод, Нууц эрлэг хаан 65-1457, 4/128	ЗГ-ын 2005 оны 116-р тогтоол, №256	9 мин 12 сек
102	Гүр Итгэл 65-1484 1/283	ЗГ-ын 2005 оны 116-р тогтоол, №252	6 мин 50 сек
103	Бурхан багшийн жирав 65-1529,4/22	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №698	17 мин 43 сек
104	Арслант ширээнээ заларч буй Богд лам (төвд: Сэгва-аа) 65-1486-1, 4/9	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №698	10 мин 2 сек
105	Бар хөлөглөсөн Их егүзэрийн дүрээр заларч буй Богд лам (төвд: Сэгва-аа) 65-1486-3, 4/9	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №698	5 мин 20 сек
106	Заан хөлөглөн заларч буй Богд лам (төвд: Сэгва-аа) 65-1486-2, 4/9	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №698	5 мин 57 сек
107	Өндөр гэгээн Занабазарын хүүхэд ахуйн дээл 02-4-1, 5/400	ЗГ-ын 2011 оны 214-р тогтоол, №596	15 мин 52 сек
108	Нархажид 65-1664, 3/224	ЗГ-ын 2004 оны 108-р тогтоол, №266	19 мин 55 сек
109	Дээд Амгалант 73-01, 1/290	ЗГ-ын 2004 оны 108-р тогтоол, №261	29 мин 52 сек
110	Махгал 65-1491, 3/223	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №717	26 мин 16 сек
111	Ловон Ендон-Од 65-1509, 4/5	ЗГ-ын 2012 оны 105-р тогтоол, №717	22 мин 9 сек
112	Давгажалцан лам 64-1427, 4/14	ЗГ-ын 2005 оны 116-р тогтоол, №265	18 мин 41 сек
ЭрдэнэЗуу музей- бичлэгийн хугацаа			1845 мин 05 сек

Хосгүй үнэт дурсгалуудын дүрс бичлэг хийх ажлын явцад дурсгалын нэр, материал, хэмжээ, хувийн дугаар зэрэг өгөгдөл мэдээллийг “Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэл” болон Засгийн газрын тогтоолтой тулган “дурсгалын нэр” ташаарсан, Засгийн газрын тогтоолд “хувийн дугаар” дутуу бичигдсэнийг нэмж оруулах, буруу бичигдснийг залруулахыг бичиж тэмдэглэв.

Дурсгалын нэр ташаа бичигдснийг “Монголын бурханы шашны урлаг”, “Их Монголын суварга Онол хийгээд бүтээх ёс”, “Deities of the Buddhism” (СӨТ-өөс өгсөн хуулбар), “Өндөр гэгээн Занабазар” зэрэг номын танка зураг, бурхан шүтээний нэрийг

тулган үзэж нягталсан. Тухайлбал, бүртгэлд хийц, хэлбэр, бэлгэдлээрээ тус бүрдээ өөр өөр боловч нэг хувийн дугаартай 7 ширхэг “суварга”-ыг ерөнхий нэрлэн бүртгэснийг чухам ямар суварга болохыг нь нэг бүр нэрийг тодруулан бичсэн.

Ажлын гол зорилго Засгийн газрын шийдвэрээр Монгол Улсын түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйл хэмээн зэрэглэлд батлагдсан дурсгалуудыг дүрс бичлэгээр баримтжуулах явдал байсан. Засгийн газрын 2012 оны 105 дугаар тогтоолоор хосгүй үнэт зэрэглэлд батлагдсан үзмэрүүд нь ур хийцийн хувьд ядмаг дорой, өөр бусад музейд нийтлэг элбэг байдаг үзмэрүүдийн нэг ба ба Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн зэрэглэлийн шалгуурыг тогтоох тухай 8.3 дахь заалтуудыг илтэд хангаж чадахгүй үзмэрүүдийг хосгүй үнэт дурсгал гэж шийдвэр гаргуулсан нь тун хариуцлагагүй явдал болжээ. Хэлбэр, бэлгэдлээрээ тус бүрдээ тэс өөр 7 ширхэг Суваргыг нь нийтэд 1 иж бүрдэл хэмээн Засгийн газрын тогтоолд ташаа бүртгэсэн байна. Тус бүрдээ бие даасан үзмэр болж чадахаар үзмэрүүдийг салгаж тус бүрчлэн зохих зөв нэрийн дагуу залруулан бүртгэх шаардлагатай.

Цаашид зэрэглэлд хамруулахад музейн ажилтнуудын саналыг эхэнд нь харгалзан үзэж байх, уг 2012 оны 105 дугаар тогтоолоор батлагдсан хосгүй үнэт дурсгалуудыг зэрэглэлээс хасах, бууруулах асуудлыг шийдвэрлүүлэхэд эрх бүхий дээд байгууллагад уламжлах талаар музейн удирдлагаас саналаа хэлж байв.

Засгийн газрын 2002 оны 118 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол улсын түүх, соёлын дурсгалт зүйлийн хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-ын 183, 184-рт бүртгэгдсэн 2 ширхэг Аюуш бурхан (хувийн дугаар 1/8 “А” ба 1/8 “В”), Засгийн газрын 2004 оны 108-р тогтоолын 209-рт бүртгэгдсэн Санжаа марлий зод (хувийн дугаар 65-592, 1/23), 211-рт бүртгэгдсэн Авид (хувийн дугаар 65-932, 1/48), 215-рт бүртгэгдсэн Пагва лам (хувийн дугаар 65-585, 1/71) зэрэг солигдсон нь тогтоогдсон 5 ширхэг хосгүй үнэт үзмэрийн дүрс бичлэг хийгдээгүй.

Засгийн газрын 2004 оны 108 дугаар тогтоолоор “Монгол Улсын түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-ын 206-рт бүртгэгдсэн Дүйнхор (хувийн дугаар 65-536, 1/58), мөн 2012 оны 105 дугаар тогтоолын 725-рт бүртгэгдсэн Майдар (хувийн дугаар 65-1295, 3/3), 727 дүгээрт бүртгэгдсэн Жүгдэрнамжил (хувийн дугаар 65-869, 2/48) зэрэг 3 ширхэг үзмэр нь Соёлын өвийн төвд сэргээн засварлалтад байгаа тул уг 3 үзмэрийн дүрс бичлэгийг Соёлын өвийн төв дээр хийхээр болов.

Дүрс бичлэгээр баримтжуулах ажлаар 2002-2013 онуудад Засгийн газрын шийдвэрээр батлагдсан ЭрдэнэЗуу музейн 93 (120 ширхэг) хосгүй үнэт дурсгалуудаас:

- 85 (112 ширхэг) хосгүй үнэт дурсгалын нийт 1845 минут 05 секундын дүрс бичлэгийг хийв.
- Соёлын өвийн төвд сэргээн засварлалт хийгдсний дараа 3 хосгүй үнэт үзмэрийн дүрс бичлэгийг хийхээр болов.
- Солигдсон нь тогтоогдсон 5 хосгүй үнэт дурсгалд дүрс бичлэг хийгдээгүй.

Хосгүй үнэт дурсгалуудын дүрс бичлэгийг “Canon 7D mark II” маркийн гэрэл зураг авах, дүрс бичлэг хийх зориулалт бүхий аппаратаар хийж гүйцэтгэлээ. Ажлын ачааллаас шалтгаалж карт халсны улмаас аппарат гацах явдал гарч байсан ба бичлэгийн ажлыг түр 20-30 минут хүртэл зогсоон, аппаратыг үе үе амраан ажиллаж дүрс бичлэгийн ажлыг дуусгалаа.

Хархорум музейн түүх, соёлын хосгүй үнэт дурсгалыг дүрс бичлэгээр бүртгэн баримтжуулсан тухай:

Хархорум музейтай 2017 оны 5 дугаар сарын 4-ны өдрийн №05 тоот гэрээ байгуулан тус музейн түүх, соёлын хосгүй үнэт 63 дэсийн 66 ширхэг дурсгалыг дүрс бичлэгээр баримтжуулах ажлыг Соёлын өвийн төвийн мэргэжилтэн Ш.Энхтуяа, зураглаач Т.Даваа-Очир, Хархорум музейн Сан хөмрөгч Б.Уртнасан, Бүртгэл, мэдээллийн санч Б.Мөнхзул нар 2017 оны 5 дугаар сарын 4-өөс 10-ны өдрүүдэд гүйцэтгэлээ.

2011 онд түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлээр батлагдсан 13-14 дүгээр зууны үед хамаарах Их, бага хаадын үеийн 60 ширхэг зоосны дүрс бичлэгийг тус музейн лабораторид хийсэн. Зоосны 15 ширхэг нь сан хөмрөгийн өрөөнд, 45 ширхэг нь үзүүлэлийн танхимд байсан ба музейн сан хөмрөгч зооснуудаа зөөж авчран дүрс бичлэгээ хийлгүүлсэн. Дүрс бичлэгээ хийхдээ эхлээд зоос бүрийн хувийн дугаар, харьцуулалтын марштабтай аваад, дараа нь тэднийгээ аваад зоосны өвөр болон ар талаас 2-3 мин хөдөлгөөнгүй барьж хийсэн. Энэ зарчмын дагуу дүрс бичлэгээ хийлгүүлсэн.

2013 онд түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлээр батлагдсан 3 дэсийн 6 ширхэг бичигтэй чулууны гэрэл зургийг авахад багагүй хүн хүч, хөдөлгөөн орсон. Сан хөмрөгт байсан Монгол бичигт I хөшөөний хэсгүүдийг тэргээр зөөж авчран баримтжуулсан.

Үзүүлэлийн танхимд байгаа болон музейн гадна талбайд байгаа чулуунуудын дүрс бичлэгийг фон, гэрлээ зөөж байгаа газар дээр авсан.

Зарим хөшөөнүүдийн бичиг маш бүдгэрсэн учир ажлын хэсэг ярилцаад Монгол бичигт I хөшөөний хэв дардасыг музейн эрдэм шинжилгээний ажилтан Ж.Цамбагарав, П.Баянсан нар хийсэн байдаг ба хуулбарыг дүрс бичлэгтээ монтажлан оруулахаар болсон.

Музейн гадна талбайд байрлах Монгол бичигтэй II Хөшөөний гэрэл зургийг авах ажлыг нарны байдлыг харгалзан 3 удаа бичлэг хийв.

Музейн хүсэлтээр хосгүй үнэт дурсгалт зүйлд ороогүй музейн үзүүлэлийн танхимд байрлах Ү.2010.1.08 хувийн дугаартай Бумбатын амны хүн чулууны дүрс бичлэгийг нэмж авсан ба мөн дүрс бичлэг авсан хосгүй үнэт дурсгалынхаа тайлбарыг музейн эрдэм шинжилгээний ажилтан Дэжидмаа болон бүртгэл, мэдээллийн санч Б.Мөнхзул нараар яриулан бичлэг хийсэн.

№	Хархорум музейн хосгүй үнэт дурсгал	Бичлэг хийсэн хугацаа
1	Зоос /60 ширхэг/	4 цаг 15 минут,
2	Бичигт чулуун хөшөө /7 ширхэг/	1 цаг 54 минут,
3	Хосгүй үнэт дурсгалын тухай тайлбар яриа	16 минут
	Нийт 64 дэсийн 67 ш хосгүй үнэт дурсгал	6 цаг 25 минут

2017 оны үр дүнгийн гэрээнд заасан Эрдэнэ Зуу музей, Хархорум музейн хосгүй үнэт дурсгалуудыг дүрс бичлэгээр бүртгэх ажлуудыг амжилттай хийж гүйцэтгэлээ. Эрдэнэ Зуу болон Хархорум музейн нийт 157 хосгүй үнэт дурсгалыг дүрс бичлэгээр баримтжуулахаар төлөвлөснөөс 149 (179 ширхэг) дурсгалын 2230 минут 05 сек-ийн дүрс бичлэгийг хийв.

№	Музейн нэр	Дүрс бичлэг хийгдсэн хосгүй үнэт дурсгал	Дүрс бичлэг хийгдсэн минут	Тайлбар
---	------------	--	----------------------------	---------

1	Эрдэнэ Зуу музей	85 (112ш)	1845 минут 05 сек	- Солигдсон нь тогтоогдсон 5 хосгүй үнэт дурсгалд дүрс бичлэг хийгдээгүй. - Сэргээн засварлалтад байгаа 3 хосгүй үнэт үзмэрийн дүрс бичлэгийг СӨТ дээр хийхээр болов.
2	Хархорум музей	64 (67ш)	385 минут	
	Дүрс бичлэг хийгдсэн нийт хосгүй үнэт дурсгал	149 (179ш)	2230 мин 05 сек	

Нийт 149 (179 ширхэг) хосгүй үнэт дурсгалуудын 2230 мин 05 сек бичлэгийн эх хувь болон монтаж хийсэн бичлэгийг Эрдэнэ Зуу музей, Хархорум музейн бүртгэл, мэдээллийн санд бүрэн хүлээлгэн өгөх ба дүрс бичлэгийн хуулбар хувийг Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн байнгын хадгаламжид архивлан хадгалахаар зохион байгуулав.

1.4.2. Дүрслэх урлагийн музей-40 ширхэг, Уран зургийн галерей-5 ширхэг, Монгол цэргийн музей-1 ширхэг, Түүх, археологийн хүрээлэн-6 ширхэг, Улаанбаатарын их сургууль-10 ширхэг дурсгал /нийт 62 дурсгал/-ыг III ба IV улиралд хийлээ.

Монголын уран зургийн галерейд Соёлын өвийн үндэсний төвийн захирлын 230 тоот албан бичиг хүргүүлж, 2017 оны 06 тоот “Дүрс бичлэг хийх тухай” гэрээ байгуулан тус музейгээс Засгийн газрын 2013 оны 227 тоот тогтоолоор түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлээс батлагдсан 5 бүтээлийг тайлбарын хамт дүрс бичлэгийг баримтжуулах ажлыг 2017 оны 10 дугаар сарын 26, 30-ны өдрүүдэд Соёлын өвийн төвийн мэргэжилтэн Ш.Энхтуяа, зураглаач Т.Даваа-Очир болон Уран зургийн галерейн менежер Ө.Даваажаргал, сан хөмрөгч Б.Чимэдхорлоо, Н.Отгонбаяр, БМСанч Г.Үржиндулам гүйцэтгэлээ. Бүтээлийн тайлбарыг Уран зургийн галерейн сан хөмрөгч Б.Чимэдхорлоо, Н.Отгонбаяр нар уншив. Дүрс бичлэгийг 1000 вт-ийн Led гэрэлтүүлэг, 1920x1080 форматаар Canon 6D камераар хийж нийт 58 минутны бичлэг хийлээ. Ажлын тэмдэглэлийг хавсаргав.

1. О.Цэвэгжав “Азарганы ноцолдоон” уран зураг
2. Г.Одон “Ажлын дараа” уран зураг
3. Ү.Ядамсүрэн “Өвгөн хуурч” монгол зураг
4. Н.Цүлтэм “Талын айл” уран зураг
5. Б.Шарав “В.И.Ленин” монгол зураг

Дүрслэх урлагийн музейтэй 2015 оны 01/07 тоот “Дүрс бичлэг хийх тухай” гэрээгээрээ үргэлжлүүлэн тус музейгээс Засгийн газрын 1995 оны 241, 1998 оны 126, 2002 оны 118, 2005 оны 116 тоот тогтоолоор түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлээс батлагдсан 41 дурсгалыг баримтжуулах ажлыг 2017 оны 10 дугаар сарын 27, 28, 29-ны өдрүүдэд Соёлын өвийн төвийн зураглаач Т.Даваа-Очир болон тус музейн сан хөмрөгийн эрхлэгч Г.Лхагвадулам, сэргээн засварлагч Р.Чинзориг, БМСанч Т.Энхжаргал нар гүйцэтгэлээ. Дүрс бичлэгт хамрагдсан үзмэрийн тайлбарыг бичих ажил хийгдэж байна. Дүрс бичлэгийг 1000 вт-ийн Led гэрэлтүүлэг, 1920x1080 форматаар Canon 6D, Sony MC2500 камераар хийж нийт 469 минутны бичлэг хийлээ.

№	Бүтээл	Хувийн дугаар	Тодорхойлолт
1	Улаан сахиус /жамсран/	69.45.10	Монгол зураг, даавуу, grunt, алтан боронз, шороон будаг, торго, хадаг
2	Цагаан дар эх	76.16.396	Монгол зураг, даавуу, grunt, алтан боронз, шороон будаг, торго, хадаг
3	Жүгдэрнамжил	69.45.15	Монгол зураг, даавуу, шороон будаг, алтан боронз
4	Гүүний үрс гаралт	69.45.41	Монгол зураг, даавуу, шороон будаг,
5	Монголын нэг өдөр	69.45.40	Монгол зураг даавуу, шороон будаг, grunt
6	Улаан хөлөгт баатар	78.02.01	Монгол зураг, алтан боронз, шороон будаг, даавуу
7	Намсрай	69.45.06	Монгол зураг, даавуу, grunt, алтан боронз, шороон будаг, торго,
8	Нууц Хаянхярваа	69.45.17	Монгол зураг, даавуу, шороон будаг
9	Төвдийн лхас хот	70.55.02	Монгол зураг, даавуу, grunt, шороон будаг, алтан боронз
10	8-р богд Жавзандамбын хөрөг	70.55.01	Монгол зураг, даавуу алтан боронз, шороон будаг, grunt
11	Шамбалын 25 хаан	84.02.03	Монгол зураг даавуу, шороон будаг
12	Шамбалын дайн	76.16.566	Монгол зураг, даавуу, шороон будаг
13	Ламын гэгээний Майдар	69.45.31	Монгол зураг, даавуу, шороон будаг
14	Чогданжанданжанрайсэг	69.45.03	Монгол зураг, даавуу, шороон будаг
15	Майдар	69.45.01	Монгол зураг, даавуу, торго, шороон будаг
16	Майдар /босоо/	66.01.11	Монгол зураг, даавуу, grunt, алтан боронз, шороон будаг, торго
17	Чагши Жанрайсэг	76.16.380	Монгол зураг, даавуу, grunt, алтан боронз, шороон будаг, торго
18	Майдрын шангад	76.16.763	Монгол зураг, даавуу, grunt, алтан боронз, шороон будаг, торго
19	Гомбо махгал	69.45.8	Монгол зураг, даавуу, grunt, алтан боронз шороон будаг, торго
20	Дэгүггомбо	69.45.7	Монгол зураг, даавуу, grunt, алтан боронз, шороон будаг, торго
21	Жигжид	69.45.13	Монгол зураг, даавуу, grunt, алтан боронз, шороон будаг, торго, хадаг
22	Нархажидын тэг	98.02.01	Монгол зураг, даавуу, шороон будаг
23	Авидын тэг	98.02.02	Даавуу, хар, улаан бэх, шороон бэх
24	Жигжидын жанхор	76.16.240	Монгол зураг, даавуу, шороон будаг
25	Охин тэнгэр	69.45.82	Монгол зураг, даавуу, grunt, алтан боронз, шороон будаг, торго, хадаг
26	Авидын шангад	76.16.768	Монгол зураг, даавуу, шороон будаг
27	Ловонбадамжунай	76.16.394	Монгол зураг, даавуу, шороон будаг
28	Цагаан шүхэрт /Сэдэд/	76.16.397	Монгол зураг, даавуу, grunt, алтан боронз, шороон будаг, торго
29	Аюуш	69.45.27	Монгол зураг, даавуу, grunt, алтан боронз, шороон будаг, торго,
30	Ногоон дара эх	69.45.22	Монгол зураг, даавуу, grunt, алтан боронз, шороон будаг, торго, хадаг
31	Манзушири	69.43.08	Зээгт наамал, торго, хоргой, өнгийн утас, саан утас

32	Хар Махгал	69.45.11	Зээгт наамал өнгийн торго, өнгийн утас, хоргой, сувд, шүр, шил
33	Охин тэнгэр	69.45.25	Зээгт наамал, торго, хоргой, саан утас, өнгийн утас, алт мөнгө шүр, сувд оюу, тогосны өд
34	Гүнгэргийн жанхор	88.04.05	Торго хоргой, шүр, сувд
35	Дүйнхорын хот мандал	76.16.405	Зээгт наамал өнгийн торго, өнгийн утас, хоргой алт, мөнгөн саа
36	Пагва лам Лодойжанцан	69.45.05	Зээгт наамал, торго, хоргой, алт мөнгөн утас, саа
37	Гармаавий лам Ванчигдорж	69.45.19	Зээгт наамал, хоргой торго
38	8-р Богд Жавзандамба	72.86.50	Зээгт наамал хоргой, торго, саан утас
39	Хяньярваа	69,45,17	Зээгт наамал хоргой, торго, саан утас
40	Найчин Чойжин /Дорж Дордан/	69.45.12	Зээгт наамал хоргой, торго, саан утас
41	Сэнгий Раа	69.45.66	Зээгт наамал, торго, хоргой, алт, мөнгөн утас

Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалыг дүрс бичлэгээр баримтжуулах ажлаар Уран зургийн галерейн 5 дурсгалын 58 минут, Дүрслэх урлагийн музейн 41 дурсгалын 469 минутын дүрс бичлэг нийт 1212 минутны дүрс бичлэг хийж СӨУНБМС-д авлаа.

Уран зургийн галерейн түүх, соёлын дурсгалт зүйлээр батлагдсан 5 үзмэр бүрэн баримтжуулалтад бүрэн хамрагдсан ба Дүрслэх урлагийн музейгээс түүх, соёлын дурсгалт зүйлээр батлагдсан 71 үзмэрээс 62 үзмэрийг дүрс бичлэгээр баримтжуулж 9 үзмэр үлдээд байна.

ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнд хадгалагдаж буй түүх, соёлын хосгүй үнэт 6 дурсгалуудыг баримтжуулан дүрс бичлэг хийсэн тухай:

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 21.1; 21.2.7 дахь заалтын хэрэгжилтийг хангахаар тус хүрээлэнд хадгалагдаж буй Засгийн газрын 1999 оны 110 дугаар тогтоолын 116-рт, мөн 2010 оны 103 дугаар тогтоолын 564-өөс 568-рт бичигдсэн түүх, соёлын хосгүй үнэт 6 /9ш/ дурсгалт зүйлийг мэргэжлийн түвшинд дуу, дүрс бичлэгээр баримтжуулах ажлыг хүрээлэнгийн музейн байранд, 2017 оны 11 дүгээр сарын 15-16 өдрүүдэд ажиллав.

Түүх, Археологийн хүрээлэнгээс: эрдэм шинжилгээний ажилтан Р.Эрдэнэцэцэг, эрдэм шинжилгээний дадлагажигч ажилтан Н.Нандинцэцэг, Соёлын Өвийн Үндэсний Төвөөс: Соёлын биет өвийг хамгаалах хэлтсийн дарга Д.Нарантуяа, Соёлын биет бус өвийг хамгаалах хэлтсийн зураглаач Т.Даваа-Очир нар хариуцан гүйцэтгэсэн. Түүх, Археологийн хүрээлэнгээс: эрдэм шинжилгээний ажилтан Р.Эрдэнэцэцэг, эрдэм шинжилгээний дадлагажигч ажилтан Н.Нандинцэцэг, Г.Галдан, Баримт, мэдээллийн төвийн эрхлэгч, др Д.Тод, эрдэм шинжилгээний ажилтан Ц.Энхжаргал, ажилтан Э.Түвшин нар байлцан, хосгүй үнэт дурсгалуудыг зөөх, дэглэх, байрлуулах ажлыг гүйцэтгэлээ.

№	Засгийн газрын тогтоолын он, дугаар	Хосгүй үнэт дурсгалын нэр, хувийн дугаар	Бичлэгийн хугацаа /минут/
1	2010 оны 103-р тогтоолын 564-т	Хөөмөл мөнгөн чимэглэл /хувийн дугаар: 2006-1/	00:02:31 сек
2	2010 оны 103-р тогтоолын 565-т	Нэхмэл хивс /хувийн дугаар: 2006-2/	00:12:47 сек
3	2010 оны 103-р тогтоолын 566-т	Дээл /хувийн дугаар: 2006-3(2)/	00:20:34 сек
		Эсгийн малгай /хувийн дугаар: 2006-3(1)/	00:05:14 сек

		Хос эсгий гутал /хувийн дугаар: 2006-3(4)	00:12:36 сек
		Өмд /хувийн дугаар: 2006-3(3)/	00:11:22 сек
4	2010 оны 103-р тогтоолын 567-т	Хүний гавлын ясны дээд хэсэг /хувийн дугаар: 2006-4/	00:01:33 сек
5	2010 оны 103-р тогтоолын 568-т	Ясан хэл хуур /хувийн дугаар: 1989-1/	00:01:17 сек
6	1999 оны 110-р тогтоолын 116	Культегиний толгой	00:08:14 сек
		Нийт	74.48 сек

Засгийн газрын 1999 оны 110 дугаар тогтоолын 116-рт, мөн 2010 оны 103 дугаар тогтоолын 564-өөс 568-рт бичигдсэн түүх, соёлын хосгүй үнэт 6 /9ш/ дурсгалын дүрс бичлэгийн эх хувийг Түүх, Археологийн хүрээлэнгийн бүртгэл, мэдээллийн санд бүрэн хүлээлгэн өгөх ба дүрс бичлэгийн хуулбар хувийг Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн байнгын хадгаламжид архивлан хадгалахаар зохион байгуулав.

Дараах нэр бүхий 2 хосгүй үнэт дурсгалын дүрс бичлэгийг хийхдээ ерөнхий байдлаар болон дүрслэл нэг бүрийг детальчлан авч, нийт 23:69 сек-ын дүрс бичлэг хийв. Үүнд:

Дүрс бичлэг хийхээр хуйлаастай хадгалагдаж буй “Нэхмэл хивс”-ийг дэлгэхэд төв дунд хэсэгтээ хуйлж хадгалсанаас үүдэлтэй гүн нугалаа хуниас үүссэн байлаа. Иймд уг хуниас нугалааг сэргээн засварлахын дагуу тэнийлгэн хадгалах шаардлагатайг байгууллагын удирдлагад уламжилсан.

Хоёр байгууллагын удирлагаас шийдвэрлэсний дагуу уг нэхмэл хивсний нугалааг тэнийлгэх, горимын дагуу хуйлж хадгалах ажлыг тус төвийн сэргээн засварлагч Д.Нямдорж, О.Оюунчимэг нар хүрээлэнгийн холбогдох ажилтнуудтай хамтран хийсэн байна.

Дүрс бичлэгийн явцад “Хэл хуур”, “Гавлын яс”, “Эсгий малгай, Дээл, Өмд, Эсгий гутал”-ын талаар Академич, доктор, профессор, ШУ-ны гавъяат зүтгэлтэн, Япон, Солонгос, АНУ, Франц зэрэг найман орны хүндэт профессор, дотор, академич Дамдинсүрэнгийн Цэвээндорж, “Культегиний толгой” дурсгалын талаар тус хүрээлэнгийн Дундад зууны судалгааны салбарын эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор, дэд профессор Алтангэрэлийн Энхтөр нарын яриаг дүрсжүүлэн авсан.

Монгол Цэргийн музейд хадгалагдаж буй түүх, соёлын хосгүй үнэт 1 дурсгалт зүйл Засгийн газрын 2013 оны 227 дугаар тогтоолын 766 дугаарт бүртгэгдсэн “Хотгор илд” түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг мэргэжлийн түвшинд дуу, дүрс бичлэгээр баримтжуулах ажлыг тус музейн үзүүлэлийн танхимд 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр хийж гүйцэтгэв.

Монгол Цэргийн музейгээс: эрдэм шинжилгээний ажилтан н.Ганганчимэг, хосгүй үнэт дурсгал /Хотгор илд/ -ыг зөөх, дэглэх, байрлуулах ажлыг; Соёлын Өвийн Үндэсний Төвөөс: Соёлын биет өвийг хамгаалах хэлтсийн дарга Д.Нарантуяа, Соёлын биет бус өвийг хамгаалах хэлтсийн зураглаач Т.Даваа-Очир, П.Чинбат нар дүрс бичлэг хийх ажлыг тус тус хариуцан ажилласан.

№	Засгийн газрын тогтоолын он, дугаар	Хосгүй үнэт дурсгалын нэр, хувийн дугаар	Бичлэгийн хугацаа /минут/
1	2013 оны 227 дугаар тогтоолын 766-рт	Хотгор илд	00:11:44 сек

Дүрс бичлэгийн явцад Батлан Хамгаалахын Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн цэргийн түүх судлалын төвийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор профессор, цэргийн түүхч Жамбын Базарсүрэн, Тээврийн дээд сургуулийн ахмад багш, техникийн ухааны доктор Пүрэвжалын Баясгалан нарын Хотгор илдний тухай эрдэм шинжилгээ, судалгааны талаарх яриаг дүрсжүүлэн авсан.

Улаанбаатарын их сургуульд хадгалагдаж байгаа Засгийн газрын 2012 оны 105 дугаар тогтоолоор “Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-ын 739-өөс 748 дугаарт бүртгэгдсэн 10 /23ш/ дурсгалыг дүрс бичлэгээр баримтжуулах ажлыг 2017 оны 11 дүгээр сарын 28нд Монголын Үндэсний музейн үзэсгэлэнгийн зааланд хийлээ. Дүрс бичлэгээр хийх ажлыг зураглаач Т.Даваа-очир, техникч П.Чинбат нар хийж гүйцэтгэсэн. Дүрс бичлэгийн ажлын хүрээнд хосгүй үнэт дурсгалуудын гэрэл зургийг авах ажлыг давхар хийж УНБМсанд архивлан авав.

№	Засгийн газрын тогтоолын он, дугаар	Хосгүй үнэт дурсгалын нэр, хувийн дугаар	Бичлэгийн хугацаа /минут/
1	2012 оны 105-р тогтоолын 739-рт	Ганц эвэрт барсын дүрслэлтэй алтан чимэглэл	00:07:53
2	2012 оны 105-р тогтоолын 740-рт	Ганц эвэрт барс толгойтой, шувуу биетэй амьтны дүрстэй алтан чимэглэл	00:09:40
3	2012 оны 105-р тогтоолын 741-рт	Ганц эвэрт барс толгойтой, шувуу биетэй амьтан болон эвэргүй барс толгойтой шувуу биетэй хос амьтны дүрстэй алтан чимэглэл	00:09:47
4	2012 оны 105-р тогтоолын 742-рт	Хүрэн халтар хаш чимэглэл	00:10:46
5	2012 оны 105-р тогтоолын 743-рт	Ромын шилэн аяга	00:04:27
6	2012 оны 105-р тогтоолын 744-рт	Мөнгөн чимэг	00:04:11
7	2012 оны 105-р тогтоолын 745-рт	Мөнгөн чимэг	00:05:07
8	2012 оны 105-р тогтоолын 746-рт	Мөнгөн чимэг	00:02:43
9	2012 оны 105-р тогтоолын 747-рт	Мөнгөн чимэг	00:04:18
10	2012 оны 105-р тогтоолын 747-рт	Сүйх тэрэгний хүрэл чимэглэл	00:15:59
		Нийт	72 мин 5 сек

Дүрс бичлэгийн явцад Улаанбаатарын Их сургуулийн Археологийн тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D), профессор Хатагины Диймажавын Эрдэнэбаатарын дурсгалуудын талаарх судалгааны яриаг дүрсжүүлэн авсан.

Хосгүй үнэт дурсгалуудыг дүрс бичлэгийг “Sony HXR-MC-2500 cam” маркийн зориулалтын камераар хийж гүйцэтгэлээ. Хийгдсэн дүрс бичлэгийн эх хувийг музейн

бүртгэл, мэдээллийн санд, хуулбар хувийг Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн байнгын хадгаламжид архивлан хадгалахаар зохион байгуулав.

2017 оны үр дүнгийн гэрээнд тусгагдсан түүх, соёлын дурсгалт зүйлийг нийтдараах нэр бүхий 7 байгууллагад хадгалагдаж буй **212 хосгүй үнэт** дурсгалын 2915 нийт **2915 мин 47 сек**-ийн дүрс бичлэг хийгдэж, СӨУНБМСанд архивлан хадгалав.

№	Музей	Хосгүй үнэт дурсгалын тоо	Бичлэгийн хугацаа
1	Эрдэнэ Зуу музей	85 (112ш)	1845 мин 05 сек
2	Хархорум музей	64 (67ш)	385 мин
3	Монголын уран зургийн галерей	5	58 мин
4	Дүрслэх урлагийн музей	41	469 мин
5	Түүх, Археологийн хүрээлэн	6 /9ш/	74 мин 48 сек
6	Монгол Цэргийн музей	1	11 мин 44 сек
7	Улаанбаатрын Их сургууль	10 /23/	72 мин 5 сек
	Дүрс бичлэг хийгдсэн нийт хосгүй үнэт дурсгал	212 /258ш/ хосгүй үнэт дурсгал	2915 мин 47 сек

2015 оноос эхлэн хэрэгжүүлж буй түүх, соёлын хосгүй үнэт дурсгалыг дүрс бичлэгээр баримтжуулахад 2017 оны байдлаар нийтдээ 324 нь буюу 777 хосгүй үнэт дурсгалын 41.60 %-д нь дүрс бичлэг хийгдлээ.

Цаашид 2018 онд энэхүү хосгүй үнэт дурсгалуудыг дүрс бичлэгээр баримтжуулах ажлыг гүйцэтгэхэд холбогдох журмын дагуу соёлын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүний зөвшөөрөл хэрэгтэй байгааг дашрамд дурдья.

1.4.3. Богд хааны ордон музейн түүх, соёлын хосгүй үнэт Хорин нэгэн дарь эх үзмэрүүдээс эхний ээлжинд 5 ш цувралыг 3D хэмжээсээр бүртгэн баримтжуулах ажлыг 2017 оны 9 дүгээр сард 14 хоног хийж гүйцэтгэнэ.

Ажлын ачаалал, нөхцөл байдлаас шалтгаалан Богд хааны ордон музейн сан хөмрөг дэх 21-н Дара эхийн 5 ширхэг Дара эхийг 3D хэмжээсээр бүртгэн баримтжуулах ажлыг 2017 оны 12 дугаар сард хийж гүйцэтгэлээ. Ажлын багийн бүрэлдэхүүнд Ж.Даваацэрэн /Програмист/, П.Чинбат /Техникийн ажилтан/ нар ажиллав.

Тус музейд хадгалагдаж буй хосгүй үнэт дурсгалт 21-н Дара эхүүдээс эхний ээлжинд таван ширхэг Дара эх бүтээлүүдийг гурван хэмжээсийг авч хийсэн. Эдгээр бүтээлүүд нь овор хэмжээний хувьд харьцангуй бага боловч ур хийц нарийн тансаг, чимхлүүр учир гурван хэмжээсээр зураг авахад цаг хугацаа нэлээд шаардсан ажиллагаатай юм. Иймд хэсэгчилэн хэмжилт хийж тухай бүрт нь анхан шатны боловсруулалт хийгдсэн дутуу хэсгийг нь нөхөн авсан.

Гурван хэмжээст бүтээлүүдийг олон талаас нь скан хийж авсан салангид нэгэн цэгэн өгөгдлүүдийг нэгтгэж нэг координатын системд бүртгэсэн. Цэгэн өгөгдөл дээрээ гурвалжилсан торыг байгуулж, скан хийсэн бүтээл тус бүрийн 3 хэмжээст загварыг өндөр нарийвчлалтай байгуулсан.



Гурван хэмжээст лазер сканнер хийж буй ажлийн явц

Нэг бурханы хувьд авч үзвэл 120 орчим дата файл 15 сая орчим цэг бүртгэн авсан. **Rapidform Geomagic XOS, C++, OpenGL** програмуудыг ашиглан гурван хэмжээст мэдээллийг боловсруулсан. Ингэж боловсруулсан мэдээлэл нь нийт 3 гигабайт орчим файл үүссэн. Нийтдээ 5 ширхэг бурханы хувьд 1000 орчим дата файл 60 сая орчим цэг бүртгэж мөн нийт 15 гигабайт орчим хэмжээний файлын үүссэн.




Нэг удаагын сканнер хийхэд авсан үр дүн

4. 3D моделийг SFM-MVS аргачлалаар байгуулах

4.1 Богд хааны ордон музейн хадгалагдах хосгүй үнэт дурсгал болох 21-н Дарь эхийн таван ширхэг бүтээлүүд нь маш нарын хийцтэй учраас лазер сканнер хэмжих боломжгүй хэсгүүдийг 3D моделийг SFM-MVS аргачлалаар байгуулах зорилгоор тусгайлан гэрэл зураг авсан.

4.2 3D моделийг SFM-MVS аргачлалаар байгуулах, боловсруулах үйл явц



Гэрэл зураг авч буй үйл явц

3D моделийг SFM-MVS аргачлалаар байгуулаж, боловсруулан зургаар 3D модел үүсгэсэн. 3D моделийг SFM-MVS аргачлалаар байгуулсан моделио 3D лазер сканнераар үүсгэсэн 3D моделтойгоо холбон нийлүүлж боловсруулсан.

Энэхүү ажил нь соёлын өвийг хадгалж хамгаалах, энэ бүтээлүүдийг бусад эрдэмтэд судлах боломжийг олгох зэрэг олон талын чухал ач холбогдолтой. Ингэж 3D загвар үүсгэснээрээ виртуал музей ба уг бүтээлд хүний болон байгалийн хүчин зүйлийн нөлөөгөөр ямар нэг гэмтэл гарсан тохиолдолд энэхүү 3D мэдээллийг ашиглан сэргээн засварлах бүрэн боломжтой болж байгаагаараа давуу талтай юм.

2017 оны үр дүнгийн гэрээнд тусгагдсан нийт 11 хосгүй үнэт /Эрдэнэ зуу музейн -6, Богд хааны ордон музейн-5/ дурсгалыг 3D хэмжээсээр бүртгэх баримтжуулах ажлыг амжилттай хийж гүйцэтгэлээ.

1.4.4. Өвөрхангай аймгийн Эрдэнэ Зуу музейн “Гомбогүр”, “Ловон Бадамжунай”, “Доржсэмба”, “Чагши Жанрайсиг”, “Манал”, “Манзушир” зэрэг 6 ширхэг хосгүй үнэт дурсгалыг 3D хэмжээсээр бүртгэн баримтжуулах ажил 2017 оны 5 дугаар сард 21 хоног хийж гүйцэтгэх. Тус ажлын хүрээнд тус музейн ажилтнуудад зориулан “Соёлын өвийг 3D-ээр баримтжуулалтыг үзүүлэгт ашиглах” тухай 1 өдрийн сургалт зохион байгуулна.

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20.8; 21.2.7 дахь заалтыг хэрэгжүүлэн Соёлын өвийн төвийн 2017 оны үр дүнгийн гэрээний 1.4.1-д тусгагдсаны дагуу Засгийн газрын шийдвэрээр 2000-2013 онуудад Монгол Улсын түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалтад батлагдсан Эрдэнэ Зуу музейн сан хөмрөг дэх хосгүй үнэт үзмэрийг 3D-ээр сканердан баримтжуулах, хосгүй үнэт үзмэрийн материалын бүтэцийн судалгаа хийх ажлыг 2017 оны 6 дугаар сарын 05-наас 6 дугаар сарын 19-нийг дуустал 14 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэв.

Соёлын өвийн төвийн Соёлын биет өвийг хамгаалах хэлтсийн техникч П.Чинбат, тус хэлтсийн туслах програмист Ж.Даваацэрэн, Эрдэнэ Зуу музейн сан хөмрөгч Д.Наранцацрал нар ажиллалаа.

Хосгүй үнэт зэрэглэлийн 6 ширхэг бурханы 3D баримтжуулалт

Үзмэрийн товч танилцуулга

Д/д	Нэр	Хувийн дугаар	Хэмжээ /см/	Зураг
1	Ловонбадамжунай	65-353	Өндөр 43,3 Бадны диаметр 33 Жин 25435 гр	
2	Гомбо гүр	65-1653	Өндөр 18,2 см Өргөн 6,4 см Жин 1395 гр	
3	Юмсэргиймаа	65-01	Өндөр 23.3 см Бадны диаметр 15.7см Жин 2950 гр	
4	Ногоон дарь эх	65-501	Өндөр 24.3 см Өргөн 11,5 см Жин 3535 гр	
5	Бурхан багш	65-60	Өндөр 29 см Өргөн 17,7 см Жин 6755 гр	
6	Майдар	65-59	Өндөр 36,8 см Жин 4915 гр	

3D баримтжуулалтын ажил

Музейн сан хөмрөгийн өрөөнд байрлах хосгүй үнэт зэрэглэлийн үзмэр болох 65-353 хувийн дугаартай Ловон Бадамжунай бурхныг 3D баримтжуулалт хийх өрөөнд зохих журмын дагуу авчирч гэрэл зургаар баримтжуулан авсны дараа тухайн үзмэрийн бохирдлыг цэвэрлэсэн.



Цэвэрлээний явц



3D баримтжуулалт хийж буй явц

Нарны тусгал их байсан учраас өрөөний цонхны хөшгийг хааж тасалгааны гэрэлтэй болгож Vivid 9i сканерыг байршуулан теле дурангаар 3D баримтжуулалтын ажлыг хийсэн. Эхний бурханыг 3D баримтжуулалт хийсний дараа сан хөмрөгийн өрөөнөөс 65-1653 хувийн дугаартай Гомбогүр, 65-501 хувийн дугаартай Ногоон дарь эх, 65-01 хувийн дугаартай ЮмСэргиймаа, 65-59 хувийн дугаартай Майдар, 65-50 хувийн дугаартай Бурхан багш зэрэг хосгүй үнэт зэрэглэлийн нийт 6ш бурханыг 3D баримтжуулалт хийсэн. 3D баримтжуулалтын ажил дууссаны дараа бүх бурханыг гэрэл зургаар дахин баримтжуулсан. Мөн үзмэрүүд маш нарийн хийцтэй жижигхэн байсан учраас лазер сканнер хэмжих боломжгүй хэсгүүдийг 3D моделийг SFM-MVS аргачлалаар байгуулах зорилгоор тусгайлан гэрэл зураг авсан.

Үзмэрийн аюулгүй байдлын үүднээс тухайн өдөр бүрт нь тэмдэглэл хөтөлж сан хөмрөгийн өрөөнд буцаан байрлуулж байсан.



SFM-MVS аргачлалаар байгуулах зураг авч буй явц




3D модель боловсруулсан ажлын урьдчилсан үр дүн


Судалгааны ажлын дүнд цуглуулсан 3D хэмжилтийн мэдээллийг **Rapidform Geomagic XOS** програм ашиглан анхан шатны байдлаар боловсруулж СӨУНБМСанд цахим хэлбэрээр хадгалахад бэлэн боллоо. Цаашид ямар зорилгоор ашиглахаас шалтгаалж дараагийн шатны боловсруулалт хийх нь зүйтэй.



Анхан шатны модель үүсгэсэн байдал

Музейн үзмэрүүдийн 3D хэмжээст зураг авахад ашигласан тоног төхөөрөмж

№	Тоног төхөөрөмж	Зориулалт
1	 Konica Minolta VIVID 9i 3D сканнер	Дунд болон жижиг хэмжээтэй объектыг лазераар хэмжиж 3D загвар боловсруулах зориулалттай төхөөрөмж
2	 Dell Precision зөөврийн компьютер	Хээрийн судалгааны ажилд тохиромжтой, 3D хэмжилтийн мэдээллийг сканнераас тусгай програм хангамжийн тусламжтай хүлээн авч хадгалах, анхан шатны боловсруулалт хийх зориулалт бүхий өндөр хүчин чадалтай зөөврийн компьютер.
3	Canon 60D дижитал камер	Дүрс бичлэг хийх, гэрэл зураг авах
4	 Polygon Editing Tool	VIVID 9i 3D сканнертай хоршин ажиллаж хэмжилтийн мэдээллийг компьютерт хадгалах, анхан шатны боловсруулалт хийх зориулалттай програм хангамж
5	 Geomagic XOS	Бүх төрлийн 3D хэмжээст мэдээллийг мэргэжлийн түвшинд боловсруулах өргөн боломж бүхий програм хангамж

6	 x-met 7500	Орц найрлага тодорхойлох хөдөлгөөнт төхөөрөмж
---	--	---

Хосгүй үнэт зэрэглэлийн үзмэрээс материалын орц найрлагын судалгаа хийх дээж авах ажил

Энэхүү ажлын явцад хосгүй үнэт зэрэглэлийн зарим үзмэрүүдийн материалын орц найрлагын судалгаа хийх дээж авах ажлыг Эрдэнэзуу музейн сан хөмрөгийн өрөөнд хийв. Түүх, соёлын хосгүй үнэт зэрэглэлийн үзмэр болох 32 дэсийн 57 ширхэг үзмэрт материал бүтцийн судалгаа хийж дээж авах байснаас 31 дэсийн 37 ширхэг үзмэрээс дээж авав. 1 үзмэр сэргээн засварт байгаа ба 14ш үзмэр нь 1 дэсийн 16 бурханы 14 ба нэг ижил материалтай тул 2 үзмэрийг сонгож дээж авав. 5 үзмэрээс дээж авах боломжгүй байлаа. Ажлын явцад өдөр тутмын тэмдэглэл хөтөлж, гэрэл зургаар баримтжуулалт хийв.




Орц найрлагын судалгаа авч буй явц

1.5 Дэлхийн өв-“Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутаг”-ийг баталгаажуулах, танилцуулга чулуун самбар байрлуулах.

2017 оны I улиралд “Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутаг” дэргэд байрлуулах танилцуулга чулуун самбар самбарын эскиз загварыг эхний байдлаар боловсруулан Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яаманд тус тус хүргүүлсэн.

Эскиз загварыг баталгаажуулах, загварын дагуу танилцуулга чулуун самбар хийх болон зөөн байршуулах төсөв санхүүгийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.



Танилцуулга чулуун самбарын эх загварын зургаас

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны төлөөллийг оролцуулан Соёлын өвийн үндэсний төв дээр 2017 оны II улиралд Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутгийн хамгаалалтын менежментийн талаар 2-3 удаа уулзалт зохион байгуулсан.

2017 оны 11 дүгээр сарын 20-нд зохион байгуулагдсан Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, ЮНЕСКО-гийн Монголын үндэсний хороо, Хан Хэнтий Улсын тусгай хамгаалалтай газрын захиргаанаас зохион байгуулсан “Дэлхийн өвийн менежментийн асуудлууд-“Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутаг” уулзалт хэлэлцүүлэгт хамтран оролцсон Дэлхийн өвд бүртгүүлсэн газар нутагт соёлын өвийн хадгалалт, хамгаалалтын менежментийн талаар танилцуулсан.

1.6. “Чулуун өв соёл” үндэсний хөтөлбөр боловсруулах .

Монгол Улсын “Соёлын өвийг хамгаалах тухай” хуульд түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах байгаль, нийгэм, түүх, соёл, урлаг, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдол бүхий хөшөө дурсгал, хадны зураг, бичээс зэрэг чулуу ашиглаж бүтээсэн соёлын өвийг биет соёлын өв, үүн дотроо түүх, соёлын үл хөдлөх дурсгалд хамруулж, хадгалж хамгаалах, судлан шинжлэх, сурталчлах, ашиглах, сэргээн засварлах ажлыг төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэхээр тодорхой заасан байна.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.57 дахь зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2 дахь заалтыг үндэслэн “Чулуун соёлын өв” хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр заажээ.

Соёлын өвийн үндэсний төвөөс “Чулуун соёлын өв” хөтөлбөрийн үндэслэлийг гаргаж, зорилгыг тодорхойлон 5 зорилтын хүрээнд боловсруулав. Чулуун соёлын өв хөтөлбөр хэрэгжсэнээр:

1. Чулуун соёлын өвийн үндэсний чадавхийг бэхжүүлэх;

Орон нутгийн соёлын мэргэжилтнүүдийг хөшөө чулуун дурсгалыг хамгаалах анхан болон дунд шатны сургалт зохион байгуулж, чадавхжуулах.

1. Баруун бүс
2. Төвийн бүс
3. Зүүн бүс
4. Говийн бүс

2. Ард, иргэдийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх;

Хөшөө чулуун дурсгалыг олон нийтэд танилцуулах, соёлын өвийн мэдлэг боловсрол олгох чиглэлээр нэвтрүүлэг, баримтат кино бүтээх, цахим хуудас бий болгох.

1. “Монголын хадны зураг, бичгийн дурсгал” баримтат кино
2. “Монголын буган чулуун хөшөөд” баримтат кино
3. “Монголын хүн чулуун хөшөөд” баримтат кино
4. Чулуун соёлын өвийг хадгалж хамгаалах тухай баримтад нэвтрүүлэг 3 цуврал
5. “Чулуун соёлын өв-3600” виртуал тур

3. Чулуун соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санг баяжуулах;

Хадны зураг, бичээсний дардсыг авч Соёлын өвийн улсын бүртгэл мэдээллийн санд хадгалах

1. Баян-Өлгий аймаг, Улаанхус, Цэнгэл сум, Бага ойгор, Арал толгой, Шивээт хайрхан, Билүүтийн хадны зураг
2. Архангай аймаг, Чулуут, Тариат сум, Чулуут голын хадны зураг
3. Баянхонгор аймаг, Баянлиг сум, Баянлигийн хадны зураг
4. Хөвсгөл аймгийн Ринченлхүмбэ сумын Орюк хадны руни бичээс
5. Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Жаргалантын ширээгийн хадны зураг
6. Өмнөговь аймгийн Номгон сумын Долоон уулын хадны зураг
7. Дундговь аймгийн Дэлгэрхангай сум. Хүннүгийн үед холбогдох бичээс.

4. Чулуун соёлын өвийн хадгалалт хамгаалалтын аюулгүй байдлыг хангах;

Хөшөө чулуун дурсгалын хэв авч, хуулбарыг хийж улсын сан хөмрөгт хадгалах

1. Сүхбаатар аймаг, Дарьганга сум, Ламтын хүн чулуун хөшөөд
2. Төв аймаг, Дэлгэрхаан, Их хөшөөтийн гэрэлт хөшөө
3. Өвөрхангай аймгийн Тарнийн голын хүн чулуу
4. Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын Цамбагарав уулын хадны зураг (морьт цэргийн)
5. Ховд аймгийн Үенч сумын Ямаан усны хадны зураг

Биологийн болон механик эвдрэл гэмтэлтэй хөшөө чулууг цэвэрлэх, бэхжүүлэх, сэргээн засварлах

1. Архангай аймаг, Ихтамир сум, Тайхар чулууны бичээс
2. Сүхбаатар аймаг, Дарьганга сум, Ламтын хүн чулуу
3. Сүхбаатар Хөргийн хөндийн хүн чулуун хөшөөд
4. Төв аймгийн Дэлгэрхаан сумын Кулчурийн гэрэлт хөшөө
5. Улаанбаатар, Их тэнгэрийн амны зосон зураг

Хамгаалалтын хашаа, хайс барих, чулуун танилцуулга самбар байршуулах

1. Архангай аймаг, Өлзийт сум, Хөшөөтийн дэнжийн буган чулуун хөшөө

2. Сүхбаатар аймаг, Дарьганга сум, Ламтын хүн чулуун хөшөөд
3. Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын Дунд Жаргалантын буган чулуу
4. Төв аймгийн Баянцагаан сумын Хүүхэн хонгорын хүн чулуун хөшөөд

Устаж үгүй болох магадлалтай зарим хөшөө чулуун дурсгалыг унаган газраас нь зөөж битүү байранд хадгалах, хуулбарыг байршуулах

1. Булган аймгийн Сайхан сумын нутагт орших Моюн-Чурын гэрэлт хөшөө
2. Сүхбаатар аймаг, Онгон сум, Таван толгойн хүн чулуу
3. Архангай аймаг, Хотонт сумын төвийн хүн чулуу
4. Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын Зуны голын 10-р буган хөшөө
5. Завхан аймгийн Сонгино сумын Айраг нуурын буган хөшөө
6. Булган аймгийн Орхон сумын Сээрийн адгийн 11-р буган хөшөө

Чулуун дурсгалын чулуулгийн бүтэц, гэмтлийн оношлогоо бүхий мэдээллийн сан бүрдүүлж, каталогжуулах

1. Баруун бүс нутаг дахь 35 дурсгалын чулуулгийн бүтэц, эвдрэл гэмтлийн оношлогооны судалгаа
2. Төвийн болон хойд бүс нутаг дахь 50 дурсгалын чулуулгийн бүтэц, эвдрэл гэмтлийн оношлогооны судалгаа
3. Зүүн бүс нутаг дахь 30 дурсгалын чулуулгийн бүтэц, эвдрэл гэмтлийн оношлогооны судалгаа
4. Говийн бүс нутаг дахь 20 дурсгалын чулуулгийн бүтэц, эвдрэл гэмтлийн оношлогооны судалгаа
5. Чулуулгийн нэгдсэн сан үүсгэх, эвдрэл гэмтлийн судалгааны үр дүнг хэвлэж, холбогдох байгууллагыг арга зүй, мэдээллээр хангах

5. Чулуун соёлын өвийн нөөцийг эдийн засгийн эргэлтэд оруулах;

Аялал жуулчлалын зориулалтаар археологийн музей-үзвэрийн газартай болох

1. Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Донгойн ширээгийн дурсгалт газар
2. Булган аймгийн Шивээт улааны цогцолбор дурсгал
3. Төв аймаг, Эрдэнэ сум, Тоньюкукийн цогцолбор дурсгал
4. Хэнтий аймаг, Батширээт сум, Рашаан хад зэрэг дурсгалыг хамруулав.

Хөтөлбөрийн үр дүнд дараах ажлууд хийгдэнэ.

- Түүх, соёл, шинжлэх ухааны өндөр ач холбогдол бүхий хөшөө чулуун дурсгал биологийн бохирдлоос цэвэрлэгдэн, механик гэмтэл бүхий хөшөө дурсгал сэргээн засварлагдана;
- Улсын чанартай болон аймаг, сумын эрх зүйн хамгаалалт бүхий зарим хөшөө чулуун дурсгал хашаа хайсаар хамгаалагдан, чулуун танилцуулга самбартай болсон байна;
- Түүх, соёл, шинжлэх ухааны ач холбогдол бүхий хөшөө чулуун дурсгалын хэв, дардас, хуулбар бүхий улсын сан хөмрөгтэй болсон байна;
- Байгалийн болон нийгмийн хүчин зүйлийн эрсдэлээс авран хамгаалах зорилгоор зарим хөшөө чулуун дурсгалыг музейн сан хөмрөгт зөөж шилжүүлж, хуулбарыг унаган газар нь байршуулсан байна;
- Хөшөө чулуун дурсгалд түшиглэсэн археологийн музей-үзвэрийн газартай болсон байна;
- Хөшөө чулуун дурсгалыг хамгаалах, сурталчлах талаар төрөлжсөн баримтат кино, цуврал нэвтрүүлэг, виртуал тур, цахим мэдээллийн төрөлжсөн вебсайт бүхий цахим хуудастай болсон байна;

- Хөдөө орон нутгийн соёлын өвийн ажилтнуудад хөшөө чулуун хадгалалт хамгаалалтын талаар бүсчилсэн сургалтыг зохион байгуулж, боловсон хүчний чадавхийг сайжруулж, хүний нөөцтэй болсон байна;
- Чулуун дурсгалын чулуулгийн бүтэц, насжилт, эвдрэл гэмтлийн талаарх судалгаатай болсон байхаар төлөвлөв.

Хөтөлбөрийн хүрээнд 2018-2022 онд нийт 36 дурсгалт газар хамрагдах бөгөөд баримтат 3 кино, 3 цуврал нэвтрүүлэг, web site хийхээр төлөвлөв.

Мөн 2017 оны 4 ба 11 дүгээр сард хоёр удаа ШУА-ын Түүх, археологийн хүрээлэн, Физик технологийн хүрээлэн, Монголын Үндэсний музей, МУИС-ын Антропологи-Археологийн тэнхим, ШУТИС-ын БуХИСургууль, СУИС-ийн ДДУСургууль, Нийслэлийн соёл, урлагийн газар зэрэг төрийн захиргааны болон эрдэм шинжилгээний 10 гаруй байгууллагуудын 20 орчим төлөөллийг оролцуулж, тэдний санал хүсэлтийг тусгасан хэлэлцүүлгийг хийсэн болно.

ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНД ТУСГАГДААГҮЙ, НЭМЭЛТ ХИЙГДСЭН АЖЛУУД

Соёлын өвийн үндэсний төв

- Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20.3, 46.6, Соёлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5-д заасныг үндэслэн батлагдсан “Соёлын өвийн үндэсний төв байгуулах тухай” Засгийн газрын 2017 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 239 тоот тогтоол, “Дүрэм, бүтэц шинэчлэн батлах тухай” Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн А/295 тушаалын хэрэгжилтийг ханган, байгууллагын шинэ бүтэц, зохион байгуулалттай уялдуулан:
 - Хөдөлмөрийн дотоод журам,
 - Соёлын өвийн үндэсний төвийн ажил, мэргэжлийн лавлах,
 - Ажлын байрны тодорхойлолт,
 - Газар нэгжүүдийн ажлын дотоод журам зэргийг шинэчлэн боловсруулаад байна.

Шинэ бүтэц, зохион байгуулалтад тохируулан байгууллагын үйл ажиллагааны чиг үүргийг гүйцэтгэхэд ажилтнуудыг ажилтнуудыг шинэ бүтцийн дагуу оновчтой тараан байршуулах, ажил үүргийг хуваарилалтыг зохион байгууллаа.

- 2017 оны 7 болон 8 дугаар сард Соёлын өвийн төвийн шинэ барилга ашиглалтад орохтой холбогдуулан холбогдох мэргэжилтэнгүүдтэй хамтран улсын төсвөөс 2017 онд 500 сая төгрөгийн өртөг бүхий, мөн 2018 онд шинээр худалдан авах тавилга тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлтийг тус тус боловсруулан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яаманд хүлээлгэн өгөв.

Соёлын өвийн төвийн шинэ барилгад зориулан улсын төсвийн хөрөнгөөр 2017 онд шинээр худалдан авах тавилга тоног төхөөрөмжийн тендерийг 3-н багц болгон тендер зарласан ба “Багц №1.Тавилга хэрэгсэл нийлүүлэх” тендерт шалгарсан Анун ХХК-иас тавилга тоног төхөөрөмжийн тендерийг 2017 оны 12 дугаар сарын 19нд хүлээн авлаа. Хүлээн авсан тавилга хэрэгслийг үндэсний төвийн шинэ барилга ашиглалтад орох хүртэл тус Анун ХХК-ийн агуулах байранд хадгалахаар зохион байгуулан тендер хүлээлцсэн тухай актад тусгав.

Соёлын өвийн бүртгэл баримтжуулалттай холбогдох хийж гүйцэтгэсэн бусад ажлууд:

Шинжээчийн дүгнэлт гаргасан тухай

Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах газар, Гаалийн ерөнхий газрын төв лаборатори, Буянт-Ухаа дахь Гаалийн газар, Иргэний агаарын тээвэрдэх Цагдаагийн хэлтэс, Тагнуулын ерөнхий газар, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын ямаар дамжуулан Завхан аймгийн цагдаагийн газар, Увс аймгийн цагдаагийн газар, Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын цагдаагийн хэлтсээр танай төвд хандсаны дагуу тус газруудад хураагдсан, саатуулагдсан, гэмт хэрэгт холбогдож шалгагдаж байгаа 239 нэрийн эд өлгийн зүйлд шинжилгээ хийж 76 эд зүйл нь түүх, соёлын дурсгалд хамрагдахгүй, 163 эд өлгийн зүйл нь түүх, соёлын дурсгалт зүйлд хамаарна хэмээн шийдвэрлэн 19 удаагийн шинжээчийн дүгнэлт гаргалаа. Шинжилгээнд хамрагдсан эд зүйлийг хүснэгтээр үзүүлбэл:

№	Хүсэлт ирүүлсэн газар	Албан хүсэлт	Шинжилгээнд хамрагдсан эд зүйл		Тайлбар
			Нийт тоо	ТСДЗ-д хамрагдсан	
1	Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах газар	2017-01-05 №14/3-89	1	1	Шинжээчийн дүгнэлт №1 Эрүүгийн хэрэгт шалгагдаж байгаа “Манан хөөрөг”
2	Гаалийн ерөнхий газар Гаалийн төв лаборатори	2017-01-05 №07/21	1	1	Шинжээчийн дүгнэлт №2 Эрүүгийн хэрэгт шалгагдаж байгаа “Сунадаг дуран”
3	Иргэн Б.Мандал-Эрдэнэ	2017-01-23	2	-	Шинжээчийн дүгнэлт №3 Гаалиар гаргахыг хориглосон тул дүгнэлт гаргуулах хүсэлт тавьсан. “Гонгор” хатгамал, “Дүртэддагва” зээгт наамал
4	Гаалийн ерөнхий газар Буянт-Ухаа дахь Гаалийн газар	2017-02-20 №02/643	1	-	Шинжээчийн дүгнэлт №5 Гаальд саатуулагдсан. “Тамга”
5	Иргэний агаарын тээвэрдэх Цагдаагийн хэлтэс	2017 оны №28/92	11	1	Шинжээчийн дүгнэлт №6 Өргөдөл гомдлын бүртгэлийн 09 дугаарт бүртгэлтэй нийт 11 нэрийн 18 ш дурсгалаас Зуйван дугуй цайвар өнгийн чулууг мэргэжлийн байгууллагаар шинжлүүлэхээр шийдвэрлэв.
6	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Гаалийн ерөнхий газар	Амаар үүрэг болгосон	34	21	Шинжилгээ хийсэн тухай тайлан гарсан. Гаалийн ерөнхий газрын агуулахад очиж шинжлэсэн: Шашин, угсаатны зүй, археологи, палеонтологи байгалийн дурсгалд хамрагдах нийт 34 нэрийн 259 ширхэг эд зүйлээс Шашны холбогдолтой 10, угсаатны зүйн 7, палеонтологийн 4 олдвор нийт 21 эд өлгийн зүйлийг түүх, соёлын ердийн дурсгалт болно хэмээн үзлээ.
7	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам,	2017-04-12 №5/2701	37	26	Шинжээчийн дүгнэлт №7 Тагнуулын ерөнхий газар хураагдсан 3 хэргийн нийт 37 эд зүйлийг газар дээр нь

	Тагнуулын ерөнхий газар				очиж шинжлэн дараах 26 нэрийн дурсгалыг ТСДЗ-д хамрууллаа. I хэсгээс. Танка 9, II хэсгээс. Судар 11, III хэсгээс. Танка 2, гууль цутгамал бурхан 1, судар 2, тамганы хайрцаг 1
8	Гаалийн ерөнхий газар Буянт-Ухаа дахь Гаалийн газар	2017-04-17 №02/751	3	2	Шинжээчийн дүгнэлт №8 Гаалийн газар саатуулагдаад байгаа 3 төрлийн 38 ширхэг эд зүйлээс Модон шатар /32 ширхэг/, Хятад гар бичмэл данс /3 ширхэг/ нь түүх, соёлын дурсгалт зүйлд хамаарна.
9	Тагнуулын Ерөнхий газар хураагдсан	2017-04-21 №01/269	21	17	Шинжээчийн дүгнэлт №9 Замын–Үүд сумын автозамын шалган нэвтрүүлэх боомт дээр саатуулагдсан 21 дурсгалыг шинжлээд Судар 11, Хонх 1, Пүрэв 1, Ганлин 1, Судрын хавтас 1, Номын ширээ 2-ийг ТСДЗ-д хамрууллаа.
10	Иргэний агаарын тээвэрдэх Цагдаагийн хэлтэс	2017-05-10 №34/293	6	-	Шинжээчийн дүгнэлт №10 Иргэний агаарын тээвэр дэх Цагдаагийн хэлтэст шалгагдаж байгаа 6 ширхэг эд зүйл шинжлээд түүх, соёлын дурсгалд хамаарахгүй хэмээн шийдвэрлэсэн.
11	Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн иргэн Билигбат овогтой Ганхуяг /РД: СЮ80122618/	2017-5-11	1	-	Хариуг албан бичгээр /СӨТ 2017-05-15-ны №114/ Худалдаж авсан “Морьтой хүний дөрвөлжин суурьтай металл баримал”-ыг шинэжлээд түүх, соёлын дурсгалд хамраарахгүй хэмээн шийдвэрлэсэн.
12	Гаалийн ерөнхий газар Буянт-Ухаа дахь Гаалийн газар	2017-05-23 №02/820	2	-	Шинжээчийн дүгнэлт №11 Тус газар саатуулагдсан /12 жилийн дүрстэй мөнгөлөг металл эдлэл болон барын дүрстэй бариултай дөрвөлжин суурьтай тамга/ 2 дурсгалыг шинжлэн ТСДЗ-д хамрахгүй хэмээн шийдвэрлэсэн.
13	Гаалийн ерөнхий газар Буянт-Ухаа дахь Гаалийн газар	2017-06-15 №02/859	6	-	Шинжээчийн дүгнэлт №12 Тус газар саатуулагдсан 6 ширхэг эд зүйлийг шинжлэн ТСДЗ-д хамрахгүй хэмээн шийдвэрлэсэн.
14	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	2017-06-23 №05/5624	7	4	Шинжээчийн дүгнэлт №13 Увс аймгийн Цагдаагийн хэлтэст шалгаж байгаа 6 төрлийн 7 ширхэг эд зүйлээс Бурхан багш цутгамал, Цэнд-Аюуш цутгамал, Аралхаан нагтан зураг, Авид бурханы барын дардсыг ТСДЗ-д хамаарууллаа.
15	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	2017-06-23 №05/5624	19	8	Шинжээчийн дүгнэлт №14 Завхан аймгийн Цагдаагийн хэлтэст шалгагдаж байгаа 19 эд зүйлийг шинжлэн 5 ширхэг судар, Хос цан, Дун, Хонх очир гэсэн 8 нэрийн дурсгалыг ТСДЗ-д хамаарууллаа.

16	Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын цагдаагийн хэлтэс	2017-09-06 №42а-2/1158	82	78	Шинжээчийн дүгнэлт №15/1 109 дугаартай гомдол мэдээлэлд бүртгэгдсэн 82 эд зүйлийг шинжлэн 78 ш цөгцийг ТСДЗ-д хамаарууллаа.
17	Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын цагдаагийн хэлтэс	2017-09-06 №42а-2/1158	1	1	Шинжээчийн дүгнэлт №15/2 172000068 дугаартай хэрэг бүртгэлтэй Цагаан өнгийн ясан дун 1 ш шинжлэн ТСДЗ-д хамаарууллаа.
18	Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын цагдаагийн хэлтэс	2017-09-06 №42а-2/1158	3	3	Шинжээчийн дүгнэлт №15/3 1172000076 дугаартай хэрэг бүртгэлтэй Металл хувин 3 ш шинжлэн ТСДЗ-д хамаарууллаа.
19	Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын цагдаагийн хэлтэс	2017-09-06 №42а-2/1158	1	-	Шинжээчийн дүгнэлт №15/4 108 дугаартай гомдол мэдээлэлд /Сангийн бойпорт 1 ш/ эд зүйлийг ТСДЗ-д хамаарахгүй хэмээн шийдвэрлэсэн.
Нийт			239	163	

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газрын ТГ/623 тоот болон Цагдаагийн ерөнхий газар, Мөрдөн байцаах албанаас ирүүлэх “Музей, сүм хийдээс 1990-2017 онд алдагдсан үзмэрийн судалгааг гаргуулах тухай” 11/3-5376 тоот албан бичгийн дагуу СӨУНБМСанд мэдээлэл хадгалагдаж буй хулгайд алдагдсан 236 үзмэрийн судалгааг гаргаж, үндэсний төвийн захирлын 2017 оны 197 тоот хариу албан бичгийг 31 хуудас хавсралтын хамт хүргүүлсэн.
- Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20.7 22.3 заалтыг хэрэгжүүлэхэд “Секрет Монголс” ХХК-ийн хүсэлтийн дагуу тэдний өмчлөл, эзэмшил дэх соёлын өвийг СӨУНБМСанд бүртгүүлэх, хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэлийн маягтыг хөтлөх талаар арга зүйн зөвлөгөөг өгч, тэдний өмчлөл эзэмшил дэх 1949 ширхэг соёлын өвийн бүртгэлийг цаасан болон “RCH”-д оруулсан цахим хэлбэрээр СӨУНБМСанд хүлээн авах ажлыг 2017 оны 1 ба 2 дугаар саруудад зохион байгуулан ажиллав. “Секрет Монголс” ХХК-тай СӨУНБМСанд бүртгэгдсэн бүртгэлийн тухай гэрээ байгуулсан.
- 2017 оны 1 дүгээр сард Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн хорооны даргын шийдвэрээр баруун европын орнуудаас ирсэн үлэг гүрвэлийн олдворуудыг Үлэг гүрвэлийн төв музейд хүлээлгэн өгөх Ажлын хэсэгт хэлтсийн дарга Д.Нарантуяа, Соёлын биет бус өвийг хамгаалах хэлтсийн зураглаач О.Үүрийнтуяагийн хамт орж ажилласан ба уг олдворуудыг нисэхийн гааль дээр хүлээн авахаас Үлэг гүрвэлийн музейн сан хөмрөгт өгөх хүртэл ажлыг хариуцан гүйцэтгэлээ.
- Сэргээн засварлах хэлтэст 2016-2017 онд сэргээн засварлалт хийгдсэн Ховд аймгийн “Үзүүр гялан”-гийн олдворуудын гэрэл зураг авах, дүрс бичлэг хийх, бүртгэн баримтжуулах ажлыг тус хэлтсийн мэргэжилтэнгүүд гүйцэтгэсэн ба уг ажлыг тайлагнах үзэсгэлэнгийн үеэр хэвлэгдсэн гарсан “Хадан гэрийн соёл” товхимолд хэлтсийн дарга Д.Нарантуяа, мэргэжилтэн Г.Бүрэнтөгс нар “Хадны оршуулгыг сэргээн засварласан ажлын тухай”, Ш.Энхтуяа “Үзүүр гялангийн олдворын бүртгэл” өгүүлэл тус тус бичиж хэвлүүлэв. Үзүүр гялангийн олдворуудын сэргээн засварлалт, бүртгэл баримтжуулалтын талаарх материалуудыг нэгтгэн СӨУНБМСанд архивлан хадгалав.

- 2017 оны 10 дугаар сард Дорнод аймгийн Замын-Үүдийн суман дахь сум дундын шүүхээс хураагдан ирсэн соёлын өвийн 159 дурсгалыг Дүрслэх урлагийн музейн сан хөмрөгт шилжүүлэх ажлыг Соёлын урлагийн газрын мэргэжилтэн Ч.Нацагням, Дүрс урлагийн музейн ажилтнууд, хэлтсийн мэргэжилтэн Ш.Энхтуяа нартай хамтран зохион байгуулан ажиллаж, тайланг Соёл, урлагийн газарт хүлээлгэн өглөө.
- 2017 оны 12 дугаар сард Дорнод аймгийн Замын-Үүдийн суман дахь сум дундын шүүхээс хураагдан ирсэн 9 ш танка зургийг Чойжин ламын сүм музейн сан хөмрөгт шилжүүлсэн ба мөн газраас ирсэн 195 дурсгалыг Говьсүмбэр аймгийн музейд өгөхөөр Соёл, урлагийн газраас шийдвэрлэсний дагуу энэ 12 дугаар сарын 25-нд хүлээлцэхээр зохион байгуулав.
Музейн сан хөмрөгт шилжүүлэх ажлыг Соёлын урлагийн газрын мэргэжилтэн Ч.Нацагням, Чойжин ламын сүм музейн ажилтнууд хэлтсийн дарга Д.Нарантуяа, хэлтсийн мэргэжилтэн Ш.Энхтуяа нартай хамтран зохион байгуулан ажиллаж, тайланг Соёл, урлагийн газарт хүлээлгэн өглөө.

Хувь хүний өмчлөлийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэлийн талаар:

- СӨУНБМСанд 2017 онд 10 хувь хүн өөрийн өмчлөлийн түүх, соёлын дурсгалт 23 дурсгалт зүйлийн бүртгүүлээ. Эдгээрээс 50% буюу 5 хүний 10 дурсгал улсын хилээр нэвтрэх лиценз авах зорилгоор бүртгүүлсэн байна.
Хувь хүний өмчлөлийн түүх, соёлын дурсгалт зүйлийн бүртгэлийн талаар дэлгэрэнгүй тайлан бичиж явуулсан ба Үүнд, хувь хүний бүртгэлийг програмд оруулахад шаардлагатай байгаа РСН-д програмын сайжруулалтын санал, хувь хүний өмчлөлийн бүртгэлийн бүрдүүлэлтэд хийх болон бүртгэлтэй холбоотой бусад саналыг оруулсан болно.

№	Өмчлөгч нэр, оршин байгаа газар	Дурсгалын Дэс Дугаар	Дурсгалын нэр
1	Галсандагва овогтой Нямдаваа /ЧС58042071/ УБ, БЗД	1	Монгол халх эхнэрийн малгай
	Галсандагва овогтой Нямдаваа /ЧС58042071/ УБ, БЗД	2	Монгол халх эхнэрийн дээл, ууж
	Галсандагва овогтой Нямдаваа /ЧС58042071/ УБ, БЗД	3	Монгол халх эхнэрийн толгойн боолт
	Галсандагва овогтой Нямдаваа /ЧС58042071/ УБ, БЗД	4	Монгол халх эхнэрийн энгэрийн сүйх
	Галсандагва овогтой Нямдаваа /ЧС58042071/ УБ, БЗД	5	Монгол халх эхнэрийн гутал
2	Норьёованчигийн Болор /УШ75121500/	6	Бурхан багш цутгамал
	Норьёованчигийн Болор /УШ75121500/	7	Аюуш бурхан танка
3	Түдэв овогтой Оюунцэцэг /ХА66050502/	8	Дамдин бурхан зэс хөөмөл, алт шармал

4	Болдбаатар овогтой Нэмүүлэн /УК98092826/	9	Хүрэл тогоо
5	Даваажавын Алдартөгс /УХ68103013/	10	Алтан Доржзодов судар
	Даваажавын Алдартөгс /УХ68103013/	11	Есөн эрдэнээр бичсэн Тарвачинбо судар
6	Чулуунгомбын Чойжилсүрэн /ОО64100276/ Увс аймаг Тэс сум	12	Авид бурханы дардас
	Чулуунгомбын Чойжилсүрэн /ОО64100276/, Увс аймаг Тэс сум	13	Аралхаан танка
	Чулуунгомбын Чойжилсүрэн, /ОО64100276/ Увс аймаг Тэс сум	14	Цэнд-Аюуш цутгамал
	Чулуунгомбын Чойжилсүрэн /ОО64100276/ Увс аймаг Тэс сум	15	Бурхан багш цутгамал
7	Цэвэгжав овогтой Дагиймаа /ХА54082009/ Улаанбаатар Баянзүрх дүүрэг	16	Азарганы ноцолдоон
	Цэвэгжав овогтой Дагиймаа /ХА54082009/ Улаанбаатар Баянзүрх дүүрэг	17	Азарганы ноцолдоон
8	Нэргүй овогтой Батмөнх /ЧН78012879/ Улаанбаатар СХД дүүрэг, Швед улсын Стокгольм хотод амьдардаг	18	Тал хэвийн шавар бурхад
	Нэргүй овогтой Батмөнх /ЧН78012879/ Улаанбаатар СХД дүүрэг, Швед улсын Стокгольм хотод амьдардаг	19	Ширнэн судар
	Нэргүй овогтой Батмөнх /ЧН78012879/ Улаанбаатар СХД дүүрэг, Швед улсын Стокгольм хотод амьдардаг	20	Алтангэрэл судар
9	Дорлигжав овогтой Бамбажав /УХ34031513/ Улаанбаатар Сүхбаатар дүүрэг	21	8-р Богдын хэрэглэж байсан зуух
	Дорлигжав овогтой Бамбажав /УХ34031513/ Улаанбаатар Сүхбаатар дүүрэг	22	8-р Богдын хэрэглэж байсан том тогоо
10	Жамбал овогтой Баярмаа Улаанбаатар хот БЗД, Болгар улсын Софи хотын Их сургуульд суралцдаг	23	Алтангэрэл судар

Түүх, соёлын хосгүй үнэт зэрэглэлийн дурсгалт зүйлийн жагсаалтын талаар:

- 2017 оны 11 дүгээр сард Засгийн газрын шийдвэрээр 1995-2015 онд “Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-д батлагдсан 777 дурсгалын Засгийн газрын тогтоолын хавсралт дахь “Дурсгалын нэр”, “Зохиогч”, “Холбогдох он цаг”, “Дурсгалын шинж байдал”, “хувийн дугаар”, “Эзэмшигч байгууллага” зэрэг тухайн хосгүй үнэт дурсгалын талаарх мэдээлэл ташаарч бичигдсэн, музейн бүртгэлд зөрүүтэй тэмдэглэгдснийг залруулах, солигдсон, дутсан нь шүүх хяналтын байгууллагаар тогтоогдсон, мөн Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 8.3-т заасан шалгуурыг илт хангаж чадахгүй байгаа зэрэг хосгүй үнэт дурсгалуудын судалгааг гарган БСШУСЯамны дэргэдэх ТСДЗЗҮТМэргэжлийн Зөвлөл, Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлд хүргүүлсэн.

Соёлын өвийн бүртгэл баримтжуулалт Хамтын ажиллагааны хүрээнд:

- Тус төв нь БНСУ-ын Соёлын Өвийн Судалгааны Үндэсний хүрээлэн “Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал болох сүм хийд, уран барилга, архитектурын дурсгалыг 3D цахим хэлбэрээр баримтжуулах, техникийн зураг боловсруулах, мэргэжилтэн бэлтгэх” тухай Хамтын Ажиллагааны Санамж Бичгийг 2015 онд байгуулсан билээ.

Энэхүү хамтын ажиллагааны эхний ажил 2015-2016 онд Архангай аймгийн Өлзийт сумын төвд орших Өөлд бэйсийн хүрээний Цогчэн дуган, Жүд дацан, Цамын асар зэрэг гурван барилгын, Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын нутаг дахь Үнстийн хийдийн Цогчин дуганы барилгад тус тус хийгдсэн 3D хэмжилт, судалгааны ажлын үр дүнг нэгтгэсэн тайланг хэвлүүлэх ажлыг Солонгосын талтай хамтран гүйцэтгэлээ.

Тайлан үндсэн хоёр агуулгаас бүрдэж байна. Эхний хэсэгт монголын сүм хийдийн барилга архитектурын түүхэн тойм, Өөлд бэйсийн хүрээ, Үнстийн хийдийн түүхэн судалгаа, үндсэн хэсэгт сүмийн барилгуудын архитектурын тодорхойлолт бичвэр, 3D болон хоёр хэмжээст барилгын техникийн зураг, гар зураг, гэрэл зураг зэрэг материалуудаас бүрдэж байна. Тайлан монгол, солонгос, англи хэл дээр нийтлэгдсэн болно.

Сүм хийдийн барилга архитектурын хэмжилт, судалгааны ажлыг БНСУ-ын Соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэнгийн Барилга архитектурын дурсгалын судалгааны хэлтсийн мэргэжилтэнгүүдтэй хамтран гүйцэтгэсэн. Энэ удаагийн судалгааны тайлан бол монголын эртний түүхт барилга, архитектурын дурсгалын бүртгэл баримтжуулалтыг уламжлал шинэчлэл хослуулан, орчин үеийн багаж тоног төхөөрөмж ашиглан 3D цахим хэлбэрээр хийсэн хамгийн анхны ажлын үр дүн юм.

Өөлд бэйсийн хүрээний хэвлэгдсэн тайланг БНСУ-аас 2017 оны 7 дугаар сард хүлээн авсан ба соёлын өв, барилга архитектурын чиглэлийн их дээд сургуулийн номын сан, Улаанбаатар хотын номын сангууд, эрдэм шинжилгээний хүрээлэн, эрдэм судлаачид, улсын болон аймгийн музей, 21 аймгийн номын сан, зэрэг байгууллагуудад үнэ төлбөргүйгээр тараасан.

Үнстийн хийдийн тайлан 12 дугаар сарын 10нд хэвлэгдэн гарсан. Уг ном БНСУ-аас шуудан илгээмжээр 2018 оны 1 дүгээр сарын эхээр ирэх ба дээр дурдсан газруудад мөн үнэ төлбөргүй тараагдана.

- Дээр дурдсан БНСУ-ын Соёлын өвийн үндэсний хүрээлэнтэй хамтран хэрэгжүүлж байгаа сүм хийдийн барилга, архитектурыг 3D цахим хэлбэрээр баримтжуулах ажлаар хэлтсийн мэргэжилтэн Г.Бүрэнтөгс, програмист Ж.Даваацэрэн, техникч П.Чинбат нар Архангай аймгийн Зая гэгээний хийдэд Солонгосын мэргэжилтэнгүүдтэй хамтран, 2017 оны 6 дугаар сарын 22-23 нд очиж ажиллав. Ажлын үеэр 2017 онд хамтран хийх ажлын төлөвлөгөөнд Солонгосын талтай гарын үсэг зурж, Цогчэн дуганы барилга, архитектурыг 3D цахим хэлбэрээр баримтжуулах ажлыг хийлээ. Барилга архитектурын зөвлөхөөр ШУТИСийн багш, доктор З.Оюунбилэг ажиллаж байна.

Б.Шарав. “Богдын ногоон ордон” монгол зургийг баримтжуулсан тухай

- Монголын Улсын Засгийн газрын 1998 оны 126 тоот тогтоолоор түүх, соёлын хосгүй үнэт дурсгалаар батлагдсан Богд хааны ордон музейд хадгалагдаж буй Б.Шаравын “Богдын ногоон ордон” монгол зураг нь 2017 оны 06 дугаар сарын 10-наас 9 дүгээр сарын 17-ныг хүртэл Германы Касел хотод болсон олон улсын

Документа үзэсгэлэнд оролцоод ирсэн байна. Үүний дараа тус бүтээлийн нэг хувь буюу хуулбар бүтээл болох эсэх нь тодорхойгүй бүтээл “Бадамханд музей”-д хадгалагдаж байгаа мэдээлэл гарсан ба энэ нь тус музейгээс 2009 онд хэвлүүлсэн каталогийн 27 дугаар хуудсанд 1912 онд бүтээгдсэн хэмээн хэвлэгдсэн байна.

Богд хааны ордон музейн захиргаанаас манай төвд хандсаны дагуу Богд хааны ордон музей дээр хадгалагдаж байгаа Б.Шаравын “Богдын ногоон ордон” монгол зургийн баримтжуулах ажлыг 2017 оны 10 дугаар сарын 04-ны өдөр Богд хааны ордон музейн үзэсгэлэнгийн танхимд Соёлын өвийн үндэсний төвийн мэргэжилтэн Ш.Энхтуяа, зураглаач Т.Даваа-Очир нар гүйцэтгэлээ.

Баримтжуулах ажлаар тус бүтээлийн 17 мин 50 сек-ийн дүрс бичлэгийг хийж, гэрэл зургийг давхар авсан ба тухайн үеийн нөхцөл байдлын тодорхойлолт, бүтээлийн гэмтлийн гар зургийг үйлдэж тайланг бичиж СӨУНБМС болон Богд хааны ордон музейн БМСанд хүргүүлэв.


Соёлын өвийн холбогдолтой эрх зүйн баримт боловсруулах талаар:

- 2014 оны 4 дүгээр сард Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 14.1.13-д заасан “Соёлын өвийг бүртгэл, мэдээллийн санд бүртгэх журам”-д соёлын биет болон биет бус өвийн хэлтсийн мэргэжилтэнгүүдийн саналыг нэгтгэн, уг журмыг шинэчлэн боловсруулж Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яаманд хүргүүлсэн.
- БСШУСЯамны Соёл, урлагийн бодлогын газрын даргын шийдвэрээр “Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх журам”, “Соёлын өвийн үзлэг тооллого хийх журам” боловсруулах ажилд оролцсон ба 2017 оны 4 ба 5 дугаар саруудад уг журмын эхийг боловсруулах, музейхний дунд 2 удаа хэлэлцүүлэг зохион байгуулахад ажлын хэсгийнхэнтэй хамтран ажиллав. “Соёлын өвийн үзлэг тооллого хийх журам”, “Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх журам”-ын эхийг боловсруулан, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яаманд өргөн мэдүүлээд байна.

Ажилтнуудын мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд мэргэжлийн сургалтад хамруулсан талаар:

- БНХАУ-ын Бээжин хот, Шаньси мужийн Тайюань, Да тун, Жинь жүн хотуудад 2017 оны 7 дугаар сарын 19-нөөс 8 дугаар сарын 17-ны өдөр хүртэл зохион байгуулагдсан “Дэлхийн соёлын өвийг хамгаалах, мэргэжлийн сургалтыг хөгжүүлэх нь” сэдэвт сургалтад үл хөдлөх дурсгал хариуцсан мэргэжилтэн Г.Бүрэнтөгс хамрагдав .





БНХАУ-ын Бээжин хот, Шаньси мужийн Тайюань, Да тун, Жинь жүн хотуудад болох Хятадын дэлхийн өвийг хамгаалах сургалтад хамрагдах, БНХАУ-ын дэлхийн соёлын өвд бүртгэгдсэн газруудаар зочилж туршлага судлах.

Соёлын удирдлагын төв академи: БНХАУ-ын Соёлын яамны харьяа боловсролын сургалтын байгууллага юм. Тус сургууль нь Хятадын соёлын салбарын бүх түвшинд яамд, түүний захирал, бусад холбогдох албаны ажилтнуудад зориулж соёлын удирдлага,

бизнесийн менежментийн цуврал сургалт, семинар зохион байгуулдаг. Түүнчлэн, Соёлын системийн шинэчлэлийн судалгааны төв, БНХАУ-ын Соёлын мэдээлэл, хүний нөөцийн төсөл, Ардын урлагийн олон улсын зөвлөлийн хороо, Африкийн соёлын албан хаагчдын сургалтын бааз, АНУ, Баруун Европын олон улсын сургалт, сургалтын байгууллагуудтай хамтын ажиллагааны харилцааг бий болгосон. Соёлын захиргааны бүх Хятадын албан хаагчдад зориулсан зайн боловсрол, онлайн сургалтын платформ байгуулахад бэлтгэн ажиллаж байна.




Энэхүү сургалтанд нийтдээ 25 орны 80 орчим төлөөлөгч оролцов. БНХАУ нь бүхий л салбарт сүүлийн жилүүдэд хурдацтай хөгжиж байгааг бид харж байна. Мэдлэг болон авьяаст суурилсан хятад үндэстний агуулгыг чанартай эцсийн бүтээгдэхүүн болгож бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлж, мөн түүнийг эдийн засгийн аргаар тэжээн тэтгэх кластрын загварт шилжсэн байгааг харахад таатай байлаа. Хятад Улс соёлын аялал жуулчлалаар дамжуулан хятадын түүх, соёл, ард түмний аж амьдралын хувьд цэгцтэй бодлогыг өгч өөрийн улсын иргэдэд музейд үнэ төлбөргүй үйлчлэх зэргээр гадаад орчныг өөрийн анхаарлын төвд хандуулснаар Хятад улсыг зорин ирэх дотоод гадаадын жуулчдын тоо өсөн нэмэгдэж байна. Бидэнтэй хөрш зэргэлдээ оршин байгаа тэднээс суралцах, туршлага солилцох, соёлын салбарт харилцан эрх тэгш хамтран ажиллах шаардлага байгааг харлаа.

- ОХУ-ын Шинжлэх ухааны академийн Сибирийн салбар Монгол, Будда, Төвд судлалын төвөөс 2017 оны 12 дугаар сарын 3-наас 6-ны хооронд Буриадын археологич, түүхийн шинжлэх ухааны доктор, профессор П.Б.Коноваловийн 80 насны ойд зориулсан “Актуальные вопросы археологии и этиологии Центральной Азии” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгууллаа.

П.Б.Коновалов нь 1937 онд Буриадын нутагт мэндэлсэн бөгөөд 1960 оноос Өвөрбайгал болон Монголын хүннү булшний судалгаагаар тасралтгүй дагнан ажиллаж байгаа судлаач юм. Тэрбээр Хунну в Забайкалье. - Улан-Удэ,1976. 221 с.+26 ил., Этнические аспекты истории Центральной Азии (древность и средневековье).- Улан-Удэ, изд-во БНЦ СО РАН, 1999. 214 с., Усыпальница хуннского князя в Суджи (Ильмовая падь, Забайкалье).- Улан-Удэ, изд-во БНЦ СО РАН, 2008. 98 с.: ил., The Burial Vault of a Xiongnu Prince at Sudzha (I'Imovaia Pad', Transbaikalia). - Bonn, 2008. с. Социальная структура Хунну Забайкалья.- Владивосток, Дальнаука, 2004. 106 с. (соавторы Данилов С.В., Крадин Н.Н.) зэрэг Евразийн эртний түүх, соёлын харилцааны олон чухал сэдвийг хөндсөн нэг сэдэвт зохиолуудыг бие даан болон хамтран зохижээ.

“Төв Азийн археологи, угсаатны зүйн үндсэн асуудлууд” сэдэвт хурал нь Төв Азийн чулуун зэвсгийн үе, Төв Азийн хүрлийн үеэс дундад зууны археологи, Соёлын өвийн хадгалалт хамгаалалт гэсэн 3 салбар хуралдаанд Япон, Герман, ОХУ (Санкт-Петербург, Иркутск, Чита, Красноярск, Якутск, Новосибирск, Владивосток)-аас оролцсон 50 гаруй судлаач илтгэл хэлэлцүүлэв.



Манай улсаас Монголын үндэсний музей, ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн, Улаанбаатар Их сургууль, ШУТИС, Соёлын өвийн үндэсний төв гэсэн 5 байгууллагын 10 судлаачид оролцов.

Тус хуралд Г.Анхсанаа миний бие хоёрдугаар салбар хуралдаанд “О хуннских металлических котлах из погребений на территории Монголии” сэдвээр илтгэл тавьж хэлэлцүүлэв.

Мөн хурлаас Төв Ази болон түүний дотор Буриад, Монгол орчмын Соёлын өвийн судалгаа, хамтын ажиллагааг эрчимжүүлэх, хамтарсан төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх санал гаргаж, зөвлөмж боловсруулахаар боллоо.

- Соёлын биет өвийг хамгаалах хэлтсийн мэргэжилтэн Ц.Цолмон нь 2015 оны 8 дугаар сарын 01-ээс 2017 оны 9 дүгээр сарын 1-ний хооронд Европын Холбооны тэтгэлэгт хөтөлбөр Erasmus Mundus-ийн “Choreomundus – Dance as knowledge, practice and heritage” буюу “Бүжиг мэдлэг, дадлага, өв болох нь” олон улсын мастерийн хөтөлбөрт хамрагдаж, Норвегийн Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль, Францын Блэйз Фаскал Их Сургууль, Унгар улсын Сегед хотын Их Сургууль, Англи Улсын Ройхамптон их сургуульд нийт 120 кредит цагийн хичээл үзэв.

“Буриад угсаатны дуут Ёохор бүжгийн уламжлал, түүний залгамж хийгээд өөрчлөлт” сэдвээр дипломын ажлаа бичиж, 2017 оны 06 дугаар сарын 27-ны өдөр амжилттай хамгаалсан.

- “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны тухай хууль”-ийг хэрэгжүүлэхэд 2017 оны 10 дугаар сарын 23-наас 26-ны өдрүүдэд суурь мэдлэг олгох сургалтанд байгууллагаас хэлтсийн дарга Д.Нарантуяа, Д.Нямдорж, програмист Ж.Даваацэрэн, мэргэжилтэн Ш.Энхтуяа, Ж.Насантогтох нарыг хамруулсан.

Уг сургалтанд оролцогчдоос хэлтсийн дарга Д.Нарантуяа №2007/АЗ-3555 тоот, мэргэжилтэн Ш.Энхтуяа №2007/АЗ-3578 эрх бүхий гэрчилгээ авсан.

Мэргэжил, арга зүй, соёлын өвийн сургалтын талаар:

- Баянхонгор аймгийн Боловсрол, соёлын газраас хэрэгжүүлж байгаа “Соёлын ажилтнуудыг чадавхижуулах нь” хөтөлбөрийн хүрээнд БСӨХХэлтсийн дарга Д.Нарантуяа, БСӨХХэлтсийн мэргэжилтэн Ж.Насанжаргал нар 2017 оны 5 дугаар сарын 20-23-ны өдрүүдэд Баянхонгор аймгийн сумдын соёлын өв хариуцсан ажилтнуудад “Соёлын биет бус өвийг бүртгэх”, “Биет бус өвийг өвлөн уламжлагчийг тодруулах, бүртгэх арга зүй”, “Соёлын өвийг хамгаалах тухай хууль эрх зүй”, “Биет соёлын өвийг бүртгэх, мэдээллийн сан бүрдүүлэх тухай”, “ОНСТанхимын үзүүлэлэг дэглэлт” зэрэг сэдвүүдээр мэргэжил арга зүйн сургалт өгч хичээл заав.
- Музейн үзмэрийг бүртгэх РСН програм бүрдүүлэлтийг сайжруулах ажлын хүрээнд хэлтсийн дарга Д.Нарантуяа Дүрслэх урлагийн музейн үзмэрийн бүртгэл хөтөлбөрийн байдалд дүн шинжилгээ хийж, тус музейн ажилтнуудад 2017 оны 6 дугаар сарын 30-нд бүртгэл хөтөлбөрийг засаж сайжруулах талаар арга зүйн зөвлөмжийг өгч ажилласан.
- 2017 оны 9 дүгээр сарын 7-10 өдрүүдэд Сэлэнгэ аймагт зохион байгуулагдсан “Музей ба хөгжил-2017” музейчдийн нэгдсэн чуулган эрдэм шинжилгээний хурал% спортын тэмцээнд хэлтсийн дарга Д.Нарантуяа, техникч П.Чинбат, програмист Ж.Даваацэрэн, сэргээн засварлагч Г.Ууганчимэг, А. Мөнгөнцоож, мэргэжилтэн Г.Бүрэнтөгс, нягтлан Ч.Өнөртогтох нар оролцсон. Хэлтсийн дарга Д.Нарантуяа тус чуулганд “Соёлын өвийн бүртгэл, баримтжуулалт, цаашдын чиг хандлага” сэдвээр илтгэл тавьсан. Төвийн ажилтнууд гар бөмбөгийн тэмцээнд амжилттай оролцсон.
- Монгол улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2017 оны А/53 тоот тушаалаар “Чулуун соёлын өв” хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсгийг баталсан бөгөөд энэхүү хөтөлбөрийг боловсруулах ажлын хүрээнд Хэнтий аймгийн музейгээс тус аймгийн Батширээт сумын нутагт орших Рашаан хадны дурсгалт газрыг энэхүү хөтөлбөрт хамруулах, хөтөлбөрийн арга хэмжээний төлөвлөгөөнд тусгах, шаардлагатай бол газар дээр нь очиж хэмжилт судалгаа хийх, хадгалалт



хамгаалалтын талаар мэдээлэл цуглуулах зорилго бүхий хүсэлтийг БСШУЯ-нд тавьсны дагуу тус яамны Соёл, урлагийн бодлогын газрын дарга Н.Болд 2017 оны 7/7942 тоот албан бичгийг манай төвд ирүүлсэн байна.

“Чулуун соёлын өв” хөтөлбөрийг боловсруулах цаг үетэй энэхүү ажил нь цаг хугацааны хувьд таарсан тул тус төвийн захирлын 2017 оны А/46 тоот тушаалаар Сэргээн завсарлах хэлтсийн дарга Д.Нямдорж, үл хөдлөх дурсгал хариуцсан мэргэжилтэн Г.Анхсанаа, жолооч С.Сайнзолбоо нар 2017 оны 9 дүгээр сарын 02-ны өдрөөс 4 хоногийн хугацаатай газар дээр нь очиж ажиллав.

Судалгааны баг дээрх нөхцөл байдалд дүгнэлт хийн дараах арга хэмжээг “Чулуун соёлын өв” хөтөлбөрт тусган дурсгалт газрыг хамгаалах саналыг дэвшүүлж байна.

1. Дурсгалт газрын үнэ цэнийг өсгөх, монголчууд, аялагч жуулчдын дунд монгол тамганы бахархлын Өргөө бий болгох орон нутгийн санаачилгыг дэмжиж байна. Гэвч дурсгалт газраас 5 км зайд буй Хурх багийн төвд төлөвлөж буй нь оновчтой эсэхэд эргэлзэж байна. Иймд 2013 оны үед Хэнтий аймгийн Батширээт сумын ИТХ-д санал болгон, дурсгалт газраас зүүн талд



- 1-2 км-т байрлах талд Рашаан хадны судалгаа мэдээллийн төв байгуулах хэмээн олгосон газарт энэхүү Өргөөг хамтад нь байгуулж болохыг орон нутаг болон холбогдох байгууллагууд судлах.
2. Энэхүү Рашаан хадны Судалгаа мэдээллийн төв буюу тамга тэмдэгний хүндэтгэлийн өргөөнөөс дурсгалт газар руу явганаар болон морь, морин тэргээр зорчиж очдог байх маршрут чиглэл бий болгон хэвшүүлэх
3. Бичээс бүхий хадны дээд оройн хэсгээс хадны ан цагаар урсан орох борооны усыг хаах зорилгоор бөглөөс чигжээс хийх, энэ ажил нь 2 жилийн давтамжтайгаар 1-2 сарын хугацаанд 20,0 орчим сая төгрөгөөр хийх.
4. Тамга тэмдэгт хавтанг 2 оос доошгүй өргөгч краны тусламжтайгаар байгалийн хөрсөн дээр нь тэгшлэн бэхжүүлж тогтоох нь зүйтэй, мөн энэ үед өмнө нь хөндөгдсөн хөрс шороог чулуу шороон дүүргэлтээр дүүргэн газрын хөрсөнд нөхөн сэргээн хийх хэрэгтэй байна. Энэ ажлыг 1 жилийн хугацаанд 7 хоногийн дотор, 10 орчим сая төгрөгөөр хийх.
5. Тамга тэмдэгт хавтангийн дээр бороо ус, нарнаас хамгаалсан хамгаалалтын саравч барих буюу өвлийн цагт модон хавтан бэхэлгээгээр битүүлэн хамгаалах аргыг хэрэглэх нь зүйтэй. Энэ аргыг өвлийн цагт Европын холбооны улсууд эртний баримал хөшөөгөө хамгаалахад ихээр ашигладаг арга болно.
6. Үндэсний хөтөлбөрт Рашаан хадны дурсгалт газрыг бичил тойрон явганаар аялахад зориулсан байгалийн чулуун зам, дурсгалыг үзэж сонирхох аяллын цэгүүдийг бий болгон, танилцуулга бүхий чулуун самбарыг хийх нь зүйтэй байна. Энэ ажил нь 2 жилийн давтамжтайгаар 1-2 сарын хугацаанд 30,0 орчим сая төгрөгөөр хийх.

7. Рашаан хадны дурсгалт газар нь монгол оронд соёлын биет болон биет бус өвийн ангиллаар нэгэн дор цогц байх онцлог дурсгалт газар тул ирээдүйд Соёлын өвийн дурсгалт газар хэмээх ангилалд оруулах саналыг орон нутгаас санаачлан Монгол Улсын Их хуралд өргөн барих нь зүйтэй.
 8. Рашаан хадны дурсгалт газрын хадгалалт хамгаалалтын менежментийн үйл ажиллагааг хадгалалт хамгаалалт талаас нь улсын байгууллага, аялал жуулчлал талаас нь хувийн хэвшил хамтран оролцож ажиллах нь зүйтэй гэж судалгааны баг үзлээ.
- ЮНЕСКО/Монако-гийн Хамтын Итгэлцлийн Сангийн дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй “Майхан уулын Шороон Бумбагар археологийн дурсгалын хадгалах, хамгаалах, тогтвортой менежмент бий болгоход боловсон хүчний чадавхийг нэмэгдүүлэх, олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх” төслийн хүрээнд “Орон нутгийн иргэдийн соёлын өвийн хадгалалт, хамгаалалтын талаарх мэдлэг ойлголтыг дээшлүүлэх” нь сэдэвт сургалтыг 2017 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Булган аймгийн Баяннуур суманд зохион байгууллаа. Сургалтыг NO 4500340035 гэрээний дагуу Соёлын өвийн төвөөс зохион байгуулж, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний Комисс, ТИКА-Туркийн Олон улсын хамтын ажиллагааны байгууллага дэмжигчээр оролцов.



Сургалтын эхний хэсэгт Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, ЮНЕСКО-ийн Бээжин дэх төлөөлөгчийн газар, ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний Комисс, ТИКА-Туркийн Олон улсын хамтын ажиллагааны байгууллага, Соёлын өвийн үндэсний төв, Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн, Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах алба зэрэг байгууллагуудын төлөөлөл олон улсын конвенц, монгол улсын хууль тогтоомж, дурсгалт газрын хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалт, судалгаа сурталчилгааны хэлбэрүүд, Соёлын өвийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх асуудал зэрэг 9 сэдвээр сургалт хийлээ. Сургалтад Булган аймгийн Боловсрол, соёлын урлагийн газар, аймгийн музей, Баяннуур сум, Дашинчилэн сум, Сэлэнгэ, Төв аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, аймгийн музей, Алтанбулаг сумын соёлын өвийн ажилтан, мэргэжилтнүүд болон Баяннуур сумын төрийн албан хаагчид, ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагчид 100 гаруй хүн хамрагдав.

Сургалтын дараагийн хэсэгт Шороон бумбагар дурсгалт газар ажиллав. Соёлын өвийн төвийн Соёлын өвийг сэргээн засварлах хэлтсийн дарга Д.Нямдорж дурсгалт газар очиж ЮНЕСКО-ийн мэргэжилтнүүдийн



зөвлөсний дагуу, дурсгалын бичил орчинд нөлөөлөл үзүүлэхээс урьдчилан сэргийлж сургалтад оролцогчдыг тус бүр нь 5-8 хүнтэй баг болгон хувааж, хамгаалалтын хувцас өмсгөж дурсгалын өнөөгийн нөхцөл байдалтай танилцуулав. Энэ нь ЮНЕСКО, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Соёлын өвийн үндэсний төв болон ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний Комисс уг дурсгалыг хамгаалах ажилд 2011 оноос хойш хэрхэн хүчин чармайлт гаргаж ирснийг харах боломжийг олон улсын болон орон нутгийн оролцогчдод өгсөн юм. Энэ нь соёлын өвийн хамгаалалд орон нутгийн иргэд, соёлын ажилтнуудын өөрсдийн үүрэг, оролцоог тодорхойлоход чухал алхам



болсон юм.

Мөн энэ үеэр Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хууль, ЮНЕСКО-ийн Конвенцууд, болон соёлын өвийн холбогдолтой, ялангуяа Баяннуур суманд буй Шороон бумбагарын бунханта булш болон түүний ханын зургийн талаар мэдээллээр оролцогчдыг хангах зорилгоор илтгэгчдийн илтгэл, судалгааны материалыг багтаасан гарын авлага хэвлэж, орон нутгийн иргэд, соёлын ажилтнууд, сумдын засаг захиргааны ажилтнуудад сургалтын үеэр тараалаа. Тус сургалт нь “Орон нутгийн иргэдийн соёлын өвийн хадгалалт, хамгаалалтын талаарх мэдлэг ойлголтыг дээшлүүлэх” нь сэдэвт сургалтыг дурсгал оршин буй орон



нутагт зохион байгуулж холбогдох яам, мэргэжлийн байгууллагууд, гадаад хамтын ажиллагааны байгууллага, орон нутгийн удирдлага, ард иргэд оролцсон нь цаг үеэ олсон, соёлын өвийн хадгалалт, хамгаалалтын талаарх мэдлэг ойлголтыг түгээн дэлгэрүүлэх, ялангуяа ард иргэдэд болон өсвөр насныхны дунд зөв ойлголтыг олгосноороо үр дүнтэй, олон

хүний талархлыг хүлээсэн амжилттай ажил болсон гэж үзэж байна.

Соёлын өвийн хадгалалт, хамгаалалтад орон нутгийн иргэдийн үүрэг оролцоо чухал хувь нэмэртэй энэ цаг үед цаашид энэ төрлийн сургалтыг соёлын өв, ялангуяа түүх, соёлын үл хөдлөх дурсгал оршин байгаа газарт нь зохион явуулах зайлшгүй шаардлагатай болохыг энэ сургалт харуулж чадсан юм.

- 2017 оны 11 дүгээр сарын 29-30 өдрүүдэд зохион байгуулагдсан Соёл, урлагийн ажилтны улсын II чуулганы хүрээнд Музей, соёлын өвийн салбар хуралдаанд СБӨХХэлтсийн дарга Д.Нарантуяа “Соёлын өвийн нөөц” сэдвээр илтгэл тавьж, хэлэлцүүлэг зохион байгуулсан.

- Монгол Улсын хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт, Ардын жүжигчин хөгжмийн зохиолч Дагвын Лувсаншаравын мэндэлсний 90 жилийн ойд зориулан БСШУСЯ, Улсын дуурь бүжгийн эрдэмийн театр, Монголын үндэсний урлагийн их театр, Соёл урлагийн Их сургууль зэрэг байгууллагууд Дагвын Лувсаншарав сантай хамтран түүний амьдрал, уран бүтээлийг олон талаас нь судлах зорилгоор “Лувсаншарав судлал” эрдэм шинжилгээний хурлыг 2017 оны 11 дүгээр сарын 24-ны өдөр зохион байгуулсан.


Соёл урлагийн Их сургуулиас хүсэлт тавьсны дагуу уг хуралд мэргэжилтэн Ш.Энхтуяа “Лувсаншарав, түүнд холбогдох эд өлгийн дурсгал” сэдвээр илтгэл бэлтгэж тавьлаа. Уг илтгэлээрээ Лувсаншаравын хадгалж үр хүүхдүүддээ үлдээсэн өдрийн тэмдэглэл, аян замын тэмдэглэл зэрэг гар бичмэлийг хэвлэх, судалгааны эргэлтэд оруулах, тухайн үеийн дотоод гадаадын орнуудын бэлэг дурсгалын зүйлсээр нь каталоги хэвлүүлэх, пянзны цуглуулга, алтан үеийнхний дуу хоолой, яриа бүхий туузан бичлэг зэргийг хөврүүлэх ажлыг зохион байгуулах нь зүйтэй хэмээн үзсэн.

- Соёлын сургуулийн 2017 оны хичээлийн жилийн 2, 3 дугаар улиралд Түүх, музейн 3 дугаар курсын оюутнуудад мэргэжилтэн Ш.Энхтуяа Музейн сан хөмрөгийн бүртгэн баримтжуулалт талаар Музейн бүртгэн баримтжуулалтын олон улсын зарчим, Музейн үзмэрийн бүртгэн баримтжуулалтын түүхэн явц, эрх зүйн орчин, Музейн үзмэрийн бүртгэн баримтжуулалтын үе шат сэдвүүдээр лекц, семинар бэлтгэн 2 кредитийн хичээл заалаа.
- 2017 оны 12 дугаар сарын 4-ны өдөр Соёлын биет өвийг хамгаалах хэлтэийн дарга Д.Нарантуяа “Зориг сан”-гийн дэргэдэх оюутан залуучуудын клубтэй хамтран “Соёлын өвийг хайрлан хамгаалцгаая” сэдвээр Боловсролын их сургуулийн 250 гаруй оюутанд “Түүх, соёлын өв - Бидний ирээдүй” сэдвээр лекц уншсан.

Судалгаа сурталчилгааны ажлын хүрээнд:

- Үндэсний төвийн захирлын 2017 оны А/43 тоот тушаалын дагуу Монголын Бурханы Шашинтны Төв Гандантэгчэнлин хийд, Монгол уламжлал академи, ШУА-ийн Философийн хүрээлэн зэрэг бусад газруудтай хамтран ажиллаж “Монгол дахь буддын сүм хийд, туурь” газрын зураг боловсруулан хэвлүүлсэн. Уг хэвлэгдсэн “Монгол дахь буддын сүм хийд, туурь” 50 ширхэг газрын зургийг СӨУНБМСанд хадгалав.
- Тус төвийн 2008-2015 онд Монгол нутагт оршин буй түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг анхан шатны байдлаар бүртгэн баримтжуулах, тоолох, хадгалалт хамгаалалт, ашиглалтын байдалд судалгаа хийх ажлыг хийж гүйцэтгэсэн билээ. Энэ ажлын хүрээнд Хэнтий, Сүхбаатар, Дорнод, Дорноговь, Говьсүмбэр, Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон, Булган, Өвөрхангай, Дундговь, Төв, Архангай, Завхан, Өмнөговь аймгийн нутагт ажиллаж 3300 орчим дурсгалт газрын дурсгалыг бүртгэн баримтжуулж, холбогдох мэдээллийг Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан болон аймгуудын бүртгэл, мэдээллийн санд хадгалаад байна.

Соёлын өвийн төвөөс олон нийтэд монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг сурталчлах зорилгоор Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хадгалагдаж байгаа мэдээллийг дээрх ажлын үеэр цуглуулсан мэдээллээр баяжуулан гэрэл зургийн 10 цуврал цомог хэвлүүлээд байгаа билээ. 2017 онд Завхан аймгийн нутаг дэвсгэр дээрх түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг багтаасан 11 дэх цомгийн хэвлэлийн эхийг бэлтгэн хэвлүүлэв. Цомогт түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтын тухай болон тус аймгийн нутагт явуулсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалын судалгааны тойм, улс, аймгийн хамгаалтад орших дурсгалуудын товч түүх, орших түүх зэргийг Монгол, Англи хэлээр нийтэллээ.



Мөн Завхан аймгийн 24 сумын нутагт орших түүх, соёл, шинжлэх ухаан, танин мэдэхүйн ач холбогдолтой 234 дурсгалт газрыг сонгон авч, байршлыг нь газрын зурагт байрлуулан товч тайлбарын хамт оруулж, сум тус бүрийн нутагт орших дурсгалын жагсаалтыг хавсаргав. Энэхүү цомог нь олон нийтэд түүх, соёлын дурсгалыг сурталчлан таниулах, танин мэдэхүйн зорилготой болно.

Улс, орон нутгийн музейн үзмэрийг Монголын Үндэсний Олон Нийтийн Радио, Телевизээр сурталчилсан тухай

- Төрөөс соёлын талаар баримтлах бодлого /4.4/, Соёлын өвийг хамгаалах тухай хууль /49.2.3/, Олон нийтийн радио, телевизийн тухай хууль болон холбогдох бусад хуульд заасны дагуу түүх, соёлын дурсгалт зүйлийг сурталчлах зорилгоор МҮОНРТ-ийн Баримтат уран сайхны нэвтрүүлгийн албаны найруулагч Н.Чингис, редактор Ц.Одонтуяа нараас 2017 оны 2 дугаар сард манай төвд хүсэлт тавьж улс, орон нутгийн музейд хадгалагдаж байгаа үзмэрээр 3-5 минутны “Өв эрдэнэ” мэдээлэл, танин мэдэхүйн /шторк/ цуврал нэвтрүүлэг хийхээр тохиролцсон.

Уг ажлыг улс, орон нутгийн музейтэй хамтран гурвалсан гэрээ байгуулан ажилласан ба нэвтрүүлэгт оруулах үзмэрийг түүх, соёлын хосгүй үнэт дурсгалд хамрагдаагүй, эгэл атлаа өвөрмөц, сонирхолтой, өмнө нь тэр бүр нэвтрүүлэгт орж байгаагүй үзмэрийг сонгон оруулахаар ярилцсан.

Нэвтрүүлгийг **Богд хааны ордон музейгээр** эхэлж, тус музейтэй 2017 оны 2 дугаар сарын 09-ны өдөр гэрээ байгуулан дараах 9 үзмэрийг сонгонсон. Үзмэрийн тайлбарт дурсгалын гарал үүсэл, хийц хэлбэр, давтагдашгүй шинж байдал зэргийг тусгахыг зорисон ба тус музейн үзмэрийн тайлбарыг музейн ЭША бичиж, Ш.Энхтуяа хянан найруулсан.

1. Ирвэсийн арьсан гэр
2. Өндөр гэгээн Занабазар
3. Хаш чулуун бичгийн хэрэглэл
4. VIII Богд Жавзундамбын бага насны тоглоомон эмээл
5. VIII Богд Жавзундамбын бага насны тоглоомон гэр
6. VIII Богд хааны бага насны тоглоомон шашны хэрэглэл
7. VIII Богд хааны сүйх тэрэг

8. VIII Богд Жавзандамба хааны сэнтий суудал
9. Улсын эх дагина Дондогдуламын энгэсэгны хайрцаг

Үзмэрийн тайлбарыг хянах найруулах ажилд багагүй цаг, судалгаа шаардлагатай байсан тул бусад музейнүүдийн үзмэрийг тэр бүр нарийн хянах, найруулах боломж болоогүйг хэлэх нь зүйтэй болов уу.

Монголын Уран зургийн галерейтай 2017 оны 2 дугаар сарын 09-ны өдөр гэрээ байгуулан дараах 7 зураасан зураг болон уран зураг бүтээлийг оруулсан.

- 1.Н.Адъяабазар “Адуучин”
- 2.Б.Чогсом “Говийн дуу”
- 3.Л.Гаваа “Алтайн уулс”
- 4.О.Цэвэгжав “Эхийн цагаан сэтгэл”
- 5.Д.Амгалан “Улаан тоос”
- 6.А.Сэнгэцохио “Буур”
- 7.До.Болд “Алтайн дуу”
- 8.П.Амгалан “Заг”

Монголын театрын музейтэй 2017 оны 4 дүгээр сарын 19-ны өдөр гэрээ байгуулан 1 үзмэр оруулсан.

- 1.Луун толгойтой хар хуур /Эртний Монголын хуурын шинжийг агуулсан шанаган хэлбэртэй/

Дүрслэх урлагийн музейтэй 2017 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр гэрээ байгуулан дараах 12 үзмэр оруулсан.

1. Ган сийлбэртэй хэт хутга
2. “Бурхан багшийн 12 зохионгуй”, бурхан зураг, шороон будаг, даавуу
3. “Дуйнхорын мандал” бурхан зураг, шороон будаг, даавуу
4. “Хүрээ цам”, Монгол зураг, даавуу, гуашь
5. “Мял богд” Зэс цутгуур, хөөмөл, мөнгөн түрхэц, алтан боронз, шороон будаг
6. “Шалши Ганзай” Зээгт наамал, торго, хоргой, даавуу, утас
7. Цагаан Жамба, “Жаргалын найман морь” Монгол зураг, шороон будаг, цаас
8. “Хүн чулуу”, Чулуун сийлбэр
9. “Хонь”, Чулуун сийлбэр
10. “Соёмбо” цаасан шуумал, гуашь, шороон будаг
11. “Цагаан дара эх” хатгамал, Торго, хоргой, даавуу, утас, хорхой сувд, шүр
12. “Занабазар”, Хүрэл цутгуур, алтан шармал

Хэнтий аймгийн музейн -2 үзмэр

- 1.Сэцэн ханы тамга, 1728 он, ган төмөр
- 2.Жигжид бурхан, XIX зуун, зэс хөөмөл

Говь-Алтай аймгийн музей -4 үзмэр

1. Хүрэл морь
2. Занабазарын цаасан шуумал
3. Сийлбэртэй эмээл
4. Дилов хутагтын хэт хутга

МҮОНРТ-ийн “Өв эрдэнэ” мэдээлэл, танин мэдэхүйн /шторк/ цуврал нэврүүлэгээр цацагдсан үзмэрийн бичлэг болон хар дүрсийг 2017 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Телевизийн байран дээр очиж сангийн харданд хуулж авсан ба уг хардны бичлэгийг зураглаач Т.Даваа-Очирт давхар хуулуулсан. Бичлэгт

Богд хааны ордон музей, Уран зургийн галерей, Монголын театрын музей, Хэнтий аймгийн музей, Говь-Алтай аймгийн музейн бичлэгүүдүүдээс гадна хараахан цацагдаагүй байгаа Монголын үндэсний музей, Ховдын музейн үзмэр, Дөрвөн бэрх нэвтрүүлэг, зураач Уртнасангийн нэвтрүүлэг зэрэг өвтэй холбоотой нэвтрүүлгүүд, мөн үзмэрүүдийн танилцуулгыг хуулж санд хадгалав.

Орон нутагт ажиллахдаа гэрээ байгуулаагүй бичлэг хийсэн тул Хэнтий аймгийн музей, Говь-Алтай аймгийн музейг гэрээг нөхөж хийлгүүлэхээр болж гэрээний хувийг орон нутгийн шуудангаар явуулсан байна.

Энэхүү нэвтрүүлэг нь түүх, соёлын дурсгалт зүйлийг сурталчлах, олон нийтийн танин мэдэхүйн боловсролыг нэмэгдүүлэхэд ач холбогдолтой нь дамжиггүй боловч нэвтрүүлгийн чанарыг бүх талаас нь сайжруулахад Монголын Үндэсний олон нийтийн радио телевизийн зүгээс анхаарах нь зүйтэй байна.

-х-

БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭХ АНГИ-2. БИЕТ БУС СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ХЭЛТСИЙН СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫГ ХАНГАХАД ЧИГЛЭСЭН АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ

Энэ төрлийн ангид 4 үндсэн арга хэмжээ буюу 4 төрлийн ажил багтсан болно.

2.1. СББӨ-ийн талаарх мэдлэг ойлголтыг дээшлүүлэх, чадавхи бэхжүүлэхэд хэвлэл мэдээллийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх:

“Соёлын биет бус өвийг хамгаалах тухай Конвенцийн хэрэгжилт – Хэвлэл мэдээллийн байгууллагын үүрэг оролцоо, чадавхийг бэхжүүлэх нь” сэдэвт сургалтын тайлан

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яам, (цаашид БСШУСЯ гэнэ) Соёлын өвийн төв, Монголын Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл, Соёлын өвийн сүлжээ, харилцаа холбооны Зөвлөл, ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний комисс хамтран ЮНЕСКО-гийн итгэмжит байгууллага болох БНХАУ-д төвтэй Соёлын биет бус өвийн олон улсын сургалтын төв (CRIHAP)-ийн дэмжлэгтэйгээр “ЮНЕСКО-гийн Соёлын биет бус өвийг хамгаалах тухай Конвенцийн хэрэгжилтэнд Хэвлэл мэдээллийн байгууллагуудын оруулах үүрэг, оролцоо” сэдэвт сургалтыг 2017 оны 9 дүгээр сарын 11-наас 15-ны өдрүүдэд Дархан хотноо зохион байгууллаа.

Сургалтыг СӨҮТ, CRIHAP, МСНЭ, болон сургагч багш нарын ЮНЕСКО-гийн итгэмжит сургагч багш, мэргэжилтнүүд болох Александра Денес болон Рахул Госвами нар урьдчилан бэлтгэсэн сургалтын хөтөлбөрийн дагуу удирдан явуулав. Сургалтанд Улаанбаатар хотын болон 21 аймгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудаас нийт 40 хүн хамрагдав. Ази-Номхон далайн бүс нутгийн хэмжээнд анх удаа зохион байгуулагдаж байгаа тус сургалтын явцыг ажиглахаар CRIHAP-ийн ерөнхий захирал Лиан Бин, сургалтын хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн Ли Тонг, Танг Хайжао, “Хятадын Соёл” өдөр тутмын соёлын сонины сэтгүүлч Шүэ Шуай нар оролцсон юм.

Сургалтыг зохион байгуулагчдын багт Соёлын өвийн үндэсний төвийн СББӨ-г хамгаалах хэлтсийн дарга А.Саруул, тус хэлтсийн мэргэжилтэн Ж.Насанжаргал, мэргэжилтэн Ц.Цолмон, ЮНЕСКО-гийн Соёлын асуудал хариуцсан мэргэжилтэн М.Цэцэнбилэг, Ч.Цэцэгбаатар, СУИС-ын соёл судлаач Г.Нямханд, Г.Ариунтунгалаг, жолооч Г.Эрдэнэчимэг, С.Сайнзолбоо, Түмэндэлгэр нар оролцлоо.

СББӨ-г хамгаалах тухай ЮНЕСКО-гийн 2003 оны Конвенцийг хэрэгжүүлэхэд хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх, тэднийг чадавхижуулахад энэ удаагийн сургалтын зорилго оршив. Нээлтэнд Монгол Улсын БСШУСЯ-ны Соёл, Урлагийн Бодлогын Газрын дарга Н.Болд, Монголын Соёлын Өвийн Үндэсний Төвийн захирал Г.Энхбат, ЮНЕСКО-гийн итгэмжит байгууллага болох БНХАУ-д төвтэй Соёлын биет бус өвийн олон улсын сургалтын төв (CRIHAP)-ийн ерөнхий захирал Лиан Бин, Монголын Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн ерөнхийлөгч Б.Галаарид, Соёлын өвийн сүлжээ, харилцаа холбооны Зөвлөлийн гүйцэтгэх захирал Б.Алтансүх нар оролцов.



Зураг 1. Сургалтын нээлт



Зураг 2. Сургалтанд оролцогчид дурсгалын зураг татуулав

Сургалтанд Монголын Соёлын өвийн Үндэсний төвийн захирал Г.Энхбат “Монгол улс дахь соёлын биет бус өвийн хамгаалал” сэдвээр илтгэл тавив. Соёлын биет бус өв гэж юу вэ, өвлөн өвлөгч гэж хэн бэ, Монгол улсаас Соёлын биет бус өвийг хамгаалах зорилгоор ямар хууль батлан хэрэгжүүлж, бодлого боловсруулж, хэрхэн хамгаалж ирсэн, Монгол Улсаас ЮНЕСКО-гийн Соёлын биет бус өвийн жагсаалтанд хичнээн өв бүртгүүлсэн, Монгол улсад нийт хичнээн СББӨ-ийн төрөл зүйл болон өвлөн уламжлагчийг бүртгээд байгаа, цаашид хэрхэн хадгалж, хамгаалах бодлого боловсруулж ажиллахаар төлөвлөж байгааг танилцуулсан юм.

Мөн Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэлийн ерөнхийлөгч Б.Галаарид “Монгол улс дахь Соёлын биет бус өвийн ашиглалт, хамгаалалтад



хэвлэл мэдээллийн байгууллагын үүрэг оролцоо, тулгамдаж буй асуудал” сэдвээр илтгэл тависан юм. Монголын сэтгүүл зүйн түүх, үүсэл хөгжил, Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хууль болон Төрөөс соёлын талаар баримтлах бодлогыг сэтгүүлчид хэрхэн үйл ажиллагаандаа тусгах, Монголын төр засаг, БСШУСЯ, олон улсын байгууллагууд, соёлын өвийг хамгаалах, ашиглах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудын идэвх оролцоо, СББӨ-г хамгаалахад сэтгүүлчидэд байгаа боломж бололцоо, мөн тулгардаг хүндрэл бэрхшээл, тулгамдаж байгаа асуудлууд хийгээд тэдгээрийг шийдвэрлэх гарц, гаргалгааг сэтгүүлчидтэй харилцан нээлттэй ярилцсан юм.



Сургагч багш нар “СББӨ-ийг хамгаалах тухай ЮНЕСКО-гийн Конвенци ба түүний суурь ойлголт, зарчим”, “СББӨ-г хамгаалахад хэвлэл мэдээллийн үүрэг оролцоо”, “Соёлын Биет Бус Өв ба тогтвортой хөгжил” , “Ёс зүй ба үүрэг хариуцлага”, “Урьдчилан мэдээлсэн, сайн дурын үндсэн дээр өгсөн зөвшөөрөл”, “СББӨ-ийн талаарх хэвлэл мэдээллийн баримтжуулалтад баримтлах ёс зүй” , “БНХАУ-ын сэтгүүл зүйн жишээ” зэрэг сэдвээр сургалтыг интерактив арга зүйгээр зохион байгуулав. Сургалтын хүрээнд дараах 5 бүлэгт хуваагдаж хээрийн судалгаа хийж, сэдвийн хүрээнд хэвлэл мэдээллийн бүтээл түүрвix даалгаварыг биелүүллээ. Үүнд:

- 1-р баг: “Мал эмнэх уламжлалт арга ухаан”,
- 2-р баг: “Казак бий болон эсгий ширмэл”
- 3-р баг: “Цагаан идээ боловсруулах уламжлалт технологи”,
- 4-р баг: Уламжлалт гар урлал
- 5-р баг: “Эмийн ургамал ашиглан уламжлалт эм бэлтгэх” гэсэн төрөл зүйлийг сонгов.



Бүлгүүд өмнөх өдрүүдэд сурсан онолын мэдлэг, конвенцийн тухай ойлголтоо бататгах хээрийн судалгааны ажлыг Дархан-Уул аймгийн Хонгор, Шарын гол, Орхон сумдын нутагт мал маллан амьдарч байгаа малчин айлуудад хийлээ. Ингэхдээ сургагч багш нарын урьдчилан бэлтгэсэн асуулгын (хавсралт- урьдчилсан бэлтгэсэн асуулга) дагуу өвлөн уламжлагчидтай ярилцаж, мэдээллээ цуглуулж ажиллав.

1-р баг. “Мал эмнэх уламжлалт арга ухаан”



2-р баг: “Казак бий болон эсгий ширмэл”



3-р баг: “Уламжлалт эм хийх арга”



4-р баг: “Уламжлалт уран хатгамал”



5-р баг: “Уламжлалт аргаар цагаан идээ боловсруулах”



Хээрийн судалгааны ажлын хүрээнд сэтгүүлчдийн баг бүр сэтгүүл зүйн нийтлэл, богино хэмжээний нэвтрүүлэг, танилцуулга, ярилцлага, слайдыг бэлтгэж Соёлын биет бус өвийг баримтжуулав.

Сургагч багш болон оролцогчдын зүгээс Монгол Улсын Засгийн Газарт болон Хэвлэл Мэдээллийн Салбарт хандсан Зөвлөмжийг боловсруулав.

“Соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенцийн хэрэгжилт-хэвлэл мэдээллийн байгууллагын үүрэг оролцоо” сургалтаас гарсан зөвлөмж

Засгийн Газарт:

1. Дунд сургуулийн сургалтын хөтөлбөрт СББӨ-ийн тухай хичээл оруулах, мэргэжлийн контент нийлүүлэх
2. Сэтгүүл зүйн мэргэжил олгодог их, дээд сургуулиудад СББӨ-ийн талаар хөтөлбөр оруулах, цаг гаргах
3. СББӨ-ийг өвлөн уламжлагчийг төрийн бодлогоор дэмжиж ажиллах. \Өвлөн уламжлагчдийн нэгдсэн зөвөлгөөн хийх. Өвлөн уламжлагчдыг алдаршуулж соёлын өвийн тухай онолын болоод танин мэдэхүйн боловсрол олгох\
4. Орон нутгийн засаг захиргаа, төрийн байгууллагын үүрэг оролцоог нэмэгдүүлэх, идэвхижүүлэх. \ СББӨ-ийг хамгаалах тогтвортой байдлыг нь төр, орон нутгийн засаг захиргаанаас хангаж өгөх. Орон нутгийн удирдлага соёлын ажилтан нарт СББӨ-ийн талаар мэдлэгтэй болгох сэтгүүлчидтэй хамтран ажиллах уялдаа холбоог нь сайжруулах. Орон нутгийн удирдлагуудын СББӨ-ийн ойлголт нэмэгдүүлж, энэ талаар идэвхи санаачилгатай ажилласан орон нутгийн зохион байгуулалтыг сурталчлах. Тогтвортой хөгжил, ногоон хөгжил, эдийн засгийн ач холбогдол талаас нь нийгэмд болон эрх баригчдад ойлголтуудыг өгч, дэмжлэг авах\
5. СББӨ-ийн хамгаалах сурталчилах үндэсний сан байгуулах. Олон нийтийн үндэсний телевизэд архивлагдсан нэвтрүүлэг баримтад кино зэргийг орон нутгийн телевизээр цацах боломжоор хангах. СББӨ-ийн талаар нийтэлж, нэвтрүүлсэн сэтгүүлзүйн бүтээлүүдийг архивлан, судалгааны хэрэглэгдэхүүн болгох
6. Төрийн бодлогоор СББӨ-ийн эрдэмтэн мэргэд судлаач залуу боловсон хүчинг дэмжиж сурч боловсроход дэмжлэг үзүүлэх
7. ТББ-ууд төр, иргэдтэй хамтарч СББӨ-ийн талаарх төрөл бүрийн судалгааг хийх /Жич: Нүүдэлчдийн ахуй соёлын хувьсан өөрчлөлт, бүс нутгийн онцлог г.м/
8. Олон Улсын Байгууллагууд, Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам, Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам, Сангийн яам, Хүний Эрхийн Комисс, Жендерийн Тэгш Эрхийн Хороо, Соёлын Өвийн Үндэсний Төв, Орон нутгийн захиргааны байгууллагууд, аймгуудын нутгийн зөвлөлүүд, Хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэх мэт байгууллагуудын СББӨ-ийн өмнө хүлээх үүргийг бодитой болгож, уялдаа холбоог сайжруулах.
9. Монгол улсын бүс нутагуудад СББӨ-ийг хамгаалах чиглэлээр мэргэшсэн сэтгүүлч бэлтгэх. Сэтгүүлчдийг шат дараалсан сургалтанд хамруулах.

10. Сэтгүүлчдийг гадны орны сэтгүүлчдийн арга туршлагаас судлуулах. СББӨ-ийг сурталчилахад олон улсын хэвлэлийнхэнтэй хамтран судалгаа нэвтрүүлэг хийх боломжоор хангах
11. Сэтгүүлчдийн бэлтгэсэн СББӨ-ийн талаарх нийтлэл нэвтрүүлгийг Юнеско болон Соёлын өвийн үндэсний төвийн дэмжлэгтэйгээр Дотоодод болон гадаад улс орнуудад цацах нэгдсэн систем бүрдүүлэх
12. Сэтгүүлзүйн бүтээлийн төрөлжсөн уралдаан зарлах, урамшуулах. СББӨ-ийг сурталчилсан уралдааныг тогтмол зохион байгуулж байх оны шилдэг бүтээлийг тодруулдаг байх
13. Сэтгүүлчдийг эдийн засгийн чиглэлээр дэмжих.

Хэвлэл мэдээллийн салбарт:

1. Хэвлэл мэдээлийн байгууллага СББӨ-ийг хамгаалах тухай конвенцийг олон нийтэд сурталчилах
2. СББӨ-ийг өвлөн уламжлагчдыг алдаршуулж соёлын өвийн тухай зорилтот баримт кино, асуудал дэвшүүлсэн нийтлэл зэрэг сэтгүүл зүйн бүтээлүүдийг сэтгүүлчид хийх
3. Хэвлэл мэдээллийн ажилтнууд СББӨ-ийн тухай зөв, бүрэн дүүрэн мэдлэг мэдээлэлтэй болох
4. Нийгмийн Хариуцлагатай Сэтгүүлзүйг хөгжүүлэх хүрээнд Төвийн болон Орон нутгийн хэвлэл мэдээлийн байгууллагуудын удирдлагуудад чиглэсэн уриалга гарган булан, контент бэлтгэн хүргэх
5. Соёлын өвийн чиглэлээр Нэвтрүүлэг нийтлэл бэлтгэх Орчин үеийн шаардлагад нийцсэн тогтсон зохиол стандартыг бий болгох
6. СББӨ-ийн талаар бичих сонирхолтой сэтгүүлчид, соёлын мэргэшсэн судлаачдын бүтээлийг нийтлэхэд соёлын өвийн үндэсний төвтэй хамтран ажиллах
7. Хам бүлгүүдийн хүсэлтийг хүлээн авах шугамтай болох
8. Залуучуудын оролцоог сайшаан хөхиүлэх
9. Сэтгүүлзүйн бүтээлийн төрөлжсөн уралдаан зарлах, урамшуулах
10. Идэвхи санаачилгатай ажилласан орон нутгийн зохион байгуулалтыг сурталчлах
11. Өвийг өвлөн уламжлуулагч хамт олон, жагсаалтад орсон 85 өвлөн уламжлалуулагчийг яаралтай алдаршуулах нийгэм сэдэл төрүүлэх
12. СББӨ-ийг хамгаалахад үе тэнгийн сургагч багшийг бэлтгэх /Жич: Адил түвшиний мэдлэг боловсролтой хүмүүс мэдлэгээ солилцох нь илүү үр дүнтэй байдаг/
13. Сэтгүүлчид СББӨ-ийн талаар нэвтрүүлэг бэлтгэх системээ Тогтвортой хөгжлийн бодлоготой уялдуулах. Тухайлбал 45 сэтгүүлчийн хувьд 21 аймаг 3 хотын хэмжээнд сурталчлах үйл явцыг дэмжин Бичил төсөл хэрэгжүүлэх./1 Сэтгүүлч 5 саяас доошгүй санхүүжилттэй төсөл босгох\
14. Хэвлэл мэдээллийн байгууллага нь эрдэм шинжилгээ судалгааны академиудтай хамтран ажиллаж, мэдээлэл солилцох

Бүлгүүд дээрхи саналыг зөвлөмжинд тодотгосноор сургалтын хичээл, хэлэлцүүлэг албан ёсоор өндөрлөж, оролцогчидод гэрчилгээг гардуулав.



Дүгнэлт

Соёлын биет бус өвийн хадгалалт, хамгаалалтад сэтгүүлчдийн оруулах хувь нэмэр үнэлэшгүй их юм. Энэхүү сургалт нь ЮНЕСКО-ийн Соёлын биет бус өвийг хамгаалах тухай 2003 оны Конвенцийн талаар ерөнхий ойлголт, мэдлэгтэй байсан сэтгүүлчдийн мэдлэгийг тэлсэн, Конвенцийн талаар илүү гүнзгий ойлголт мэдлэг өгсөн сургалт болж байгааг сэтгүүлчид сургалтын явцад дурдаж байв. Хэдийгээр сургалт цөөн өдөр үргэлжилсэн ч сэтгүүлчид ЮНЕСКО-ийн Соёлын биет бус өвийг хамгаалах тухай 2003 оны Конвенцийн талаар онолын болон дадлагын мэдлэг, ойлголтыг хангалттай олж авсан юм. Мөн түүнчлэн энэхүү сургалт нь соёлын өвийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд болон хэвлэл мэдээллийн байгууллагуудын хамтын ажиллагаанд нэгэн шинэ алхамыг авчирсан юм.

Сургалтанд оролцогчид СББӨ-ийг хамгаалах, ЮНЕСКО-ийн СББӨ-ийг хамгаалах тухай 2003 оны Конвенцийг хэрэгжүүлэхэд өөрсдийн үүрэг, оролцоог, Конвенцийн ажиллах зарчим, СББӨ-ийн сэтгүүл зүй, сэтгүүлчийн ёс зүй болон болон үүрэг хариуцлага соёлын өвтэй хэрхэн уялдах, мөн СББӨ тогтвортой хөгжилтэй хэрхэн холбогдох, СББӨ-ийн талаар мэдээ, нийтлэл бичихдээ Конвенцийн үзэл баримтлалаас юуг анхаарах зэргийг суралцав.

Энэхүү сургалтын 40 оролцогчид нь улс орны хэмжээнд нэгдсэн сүлжээ үүсгэж, соёлын өвийн сэтгүүл зүй, тэр дундаа СББӨ-ийн сэтгүүл зүйн анхны алхамыг энэхүү сургалтын үр дүнд хийсэн юм.

2.2. СББӨ-ийн судалгаа

2.2.1. Зүүн бүсийн Соёлын биет бус өвийн судалгаа

Соёлын өвийн төвийн захирлын 2017 оны 6 дугаар сарын 22-ны өдөр баталсан А/31 тоот тушаалын дагуу Соёлын өвийн төвийн Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн сангийн 2010-2017 оны анхан шатны бүртгэлд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр Зүүн бүс нутгийн Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймаг угсаатны бүлэг зонхилох сумдыг түүврийн аргаар сонгон тухайн угсаатны бүлгийн СББӨ-ийн онцлог, оршин тогтнох чадвар, тархалт зэргийг олж тогтоох судлах, түүн дотор “**Эх хэл болон аман уламжлал**”, “**Уламжлалт зан үйл, ёслол, баяр наадам**”, “**Байгаль болон сав ертөнцийн тухай уламжлалт мэдлэг, арга ухаан**” зэрэг бага илэрцтэй байгаа ай савд хамрах СББӨ-ийн төрөл зүйлийг түлхүү тандан судлах, олж тогтоох, бүртгэн баримтжуулах, дүн шинжилгээ хийх зорилгоор энэхүү судалгааны ажлыг удирдамжын дагуу 2017 оны 07 дугаар сарын 16-аас 08 сарын 15 хүртэл Хэнтий аймгийн Батноров, Батширээт, Биндэр, Дадал, Норовлин зэрэг 5 суманд мөн Дорнод аймгийн Баян-Уул, Булган, Гурванзагал, Дашбалбар, Сэргэлэн, Хөлөнбуйр, Цагаан-Овоо зэрэг 7 сум нийт 12 сумдын Үзэмчин, Барга, Хамниган, Буриад угсаатны бүлгүүдийн төлөөлөлтэй уулзаж СББӨ-ийн судалгааг асуулга, ажиглалт, ярилцлага, тусгайлан бэлдсэн судалгааны маягт зэргийг хослуулан Дорнод аймгийн Боловсрол Соёл, Урлагийн газар, Хэнтий Аймгийн музейтэй хамтран хийж нийт 51 хүнээс 2727 минутын дуу, дүрс бичлэг, 5036 ширхэг гэрэл зургаар баримтжуулан УНБМСанд 420 орчим зургийг сонгон архивласан болно.

Соёлын биет бус өв хариуцсан соёлын ажилтан, сумдын соёлын төвийн эрхлэгч, орон нутаг судлах музейн ажилтнуудад зориулан “Соёлын биет бус өвийн үндсэн ойлголт”, “СББӨ-ийг бүртгэх арга зүй”, “СББӨ-тэй холбогдолтой Хууль эрх зүй” сэдвээр төрөлжсөн сургалтыг Хэнтий аймагт 2017 оны 07 дугаар сарын 30-ны өдөр, Дорнод аймагт 07 дугаар сарын 30-ны өдөр тус тус зохион байгуулав.

Мөн судалгаанд Сүхбаатар аймгийн Баруун-Урт, Дарьганга, Эрдэнэцагаан, Түвшинширээ, Уулбаян, Баяндэлгэр зэрэг 6 сумд Үзэмчин, Барга, Дарьганга угсаатны бүлгийн СББӨ-ийн өвлөн уламжлагч болон төрөл зүйлийг олж тогтоох хээрийн судалгааг төлөвлөсөн байсан хэдий ч давашгүй хүчин зүйлийн улмаас судалгааны ажил хойшилсон тул тус аймгийн СББӨ-ийн судалгааг УНБМС, угсаатны судалгааны эх сурвалж дээр тулгуурлан тодорхойлсон болно. Цаашид Сүхбаатар аймгийн угсаатны бүлгийн СББӨ-ийн түүвэр судалгааг хийж гүйцэтгэх шаардлагатай.

Хэнтий, Дорнод аймгийн сонгогдсон сумын угсаатны бүлгийн СББӨ-ийн өвлөн уламжлагч болон төрөл зүйлийг олж тогтоох хээрийн судалгаанд давхардсан тоогоор нийт **84** өвлөн уламжлагч хамрагдаж, **48** өвийн зүйлийг судалгаагаар олж тогтоосон байна.

(дэлгэрэнгүй тайланг “Зүүн бүсийн Соёлын биет бус өв” номноос үзнэ үү.)

СУДАЛГААНЫ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Багийн ахлагч: А. Саруул (Соёлын өвийн төвийн СББӨ-ийг хамгаалах хэлтсийн дарга)

Хэнтий, Дорнод аймагт судалгаа хийх багийн бүрэлдэхүүн:

Багийн ахлагч: Ж. Насанжаргал (СББӨ-ийг хамгаалах хэлтсийн мэргэжилтэн)

Багийн гишүүн: Х.Нямханд (Соёл судлаач)

Г.Ариунтунгалаг (Соёл судлаач)

Н.Дэлгэрмаа (Хэнтий аймгийн Музейн БМСанч)

Т.Оюунбат (Дорнод аймгийн БСГ-ын соёл хариуцсан мэргэжилтэн)

П.Эрдэнэбаатар (Жолооч)



Хэнтий аймаг,
СББӨ, бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх
сургалт

Өвлөн уламжлагч Д.Цэрэнханд /Дорнод аймаг, Дашбалбар сум/



Өвлөн уламжлагч М.Өнөржаргал
/Хэнтий аймаг, Дадал сум/

Зүүн бүсийн судалгааны эх хэрэглэгдэхүүнд тулгуурлан “Зүүн бүсийн соёлын биет бус өв” танин мэдэхүйн номыг 1000 ширхэг хэвлэн судалгаанд хамрагдсан өвлөн уламжлагч нар болон Аймаг, Нийслэлийн холбогдох байгууллагуудад түгээсэн.

Номын агуулга:

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЗҮҮН БҮСИЙН УГСААТНЫ ЗҮЙН ТОЙМ.

Буриад, Барга, Үзэмчин, Дарьганга, Хамниган угсаатны бүлгийн засаг захиргаа, овгийн бүрэлдэхүүн;

ХОЁРДУГААР БҮЛЭГ. СОЁЛЫН ӨВИЙН УНБМС ДАХЬ СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТ.

Ерөнхий мэдээлэл;

“ЮНЕСКО-гийн Төлөөллийн болон Яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн жагсаал”-д бүртгэгдсэн өв;

Монгол Улсын Төлөөллийн болон Яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн үндэсний жагсаалт;

Соёлын өвийн УНБМС дахь соёлын биет бус өвийн тоон үзүүлэлт;

Соёлын өвийн УНБМС дахь Зүүн бүсийн соёлын биет бус өвийн тоон үзүүлэлт;

УНБМС дахь Хэнтий аймгийн СББӨ-ийн тоон үзүүлэлт;

УНБМС дахь Дорнод аймгийн СББӨ-ийн тоон үзүүлэлт;

УНБМС дахь Сүхбаатар аймгийн СББӨ-ийн тоон үзүүлэлт.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ЗҮҮН БҮСИЙН СУДАЛГАА.

Судалгааны арга зүй.

Хэнтий аймагт хийсэн СББӨ-ийн хээрийн судалгаа;

Хэнтий аймаг дахь 2017 оны хээрийн судалгааны мэдээ;

Хэнтий аймгийн хээрийн судалгааны тэмдэглэл;

Дорнод аймагт хийсэн СББӨ-ийн хээрийн судалгаа

Дорнод аймаг дахь 2017 оны хээрийн судалгааны мэдээ;

Дорнод аймгийн хээрийн судалгааны тэмдэглэл;

Зүүн бүсийн хээрийн судалгаанд хамрагдсан СББӨ-ийн тодорхойлолтууд;

Зүүн бүсийн угсаатны бүлгийн судлагдсан байдал болон өнөөгийн байдлын харьцуулалт;

Судалгааны үр дүн;


Судалгаанд хамрагдсан сумдын байршил, СББӨ болон өвлөгчдийн тархалт, насжилтын газрын зураг

Дүгнэлт;

Зөвлөмж

Хавсралт

Товчилсон үгийн жагсаалт



Өвлөн уламжлагч нарын нэрсийн жагсаалт
Ашигласан эх сурвалжийн жагсаалт хэсгээс бүрдсэн.

Дүгнэлт

Өнөөгийн суурьшмал амьдралын нөөөлөө хэрэгцээ шаардлагаа даган угсаатны бүлгүүдийн амьдралын хэв маяг хэрхэн өөрчлөгдөж, түүнийгээ даган соёлын биет бус өвийн ховор хосгүй олон төрөл зүйлс ашиглагдахаа больж мартагдах, устан үгүй болж байгааг энэхүү судалгаанаас харж болно. Мөн хүн амын хувьд дийлэнх болох Халх, Буриад угсаатанд цөөн тоотой Хамниган, Барга, Үзэмчин угсаатан уусан саармагжих, үүний нөлөөгөөр өөрсдийн онцлог зан үйл, заншил, соёлын олон төрөл зүйл мартагдан нийтлэг шинж төрхтэй байна.

Судалгааны явцад тэдний ахуй амьдралын зан үйлийн талаар нарийвчлан асуухад ерөнхий байдлаар хариулах, “мэдэхгүй”, “мартсан” гэсэн хариултуудыг өгч байсан. Судалгаанд хамрагдсан 60-аас дээш насны иргэд нь хуримын зан үйл, хүүхэд, хоол хүнс, мал аж ахуй, ан агнуур, хорио цээрийн ёс зэрэгтэй холбоотой мэдээллийг өгч байлаа. Үүнээс үзэхэд соёлын зарим төрөл зүйл өнөөгийн суурин соёл иргэншлийн хэрэгцээ шаардлагад нийцэхгүй, даган хөгжих, оршин тогтнох нөхцөл боломжгүй тул өөрийн ач холбогдол, үүрэг шинж чанараа гэж буй нь ажиглагдлаа.

Гэсэн хэдий ч соёлын өвөө хайрлан хамгаалах, хойч үедээ өвлүүлэн үлдээх чин хүсэл эрмэлзэлтэй олон олон өвлөгчдийн ачаар өнөөг хүртэл олон зуун жилийн турш өвлөгдөн ирсэн оюуны соёлын дундаршгүй эх ундаргыг цааш өвлүүлэн хөгжүүлэхэд Орон нутгийн Удирдлага, СББӨ-ийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, эрдэмтэн судлаач нарын оролцоотойгоор авран хамгаалах үйл хэрэг цаашид улам өргөжин хөгжинө хэмээн итгэнэ.

Зөвлөмж

Орон нугийн Засаг захиргааны байгууллагад хандаж дараах Зөвлөмжийг гаргах нь. Үүнд:

1. Өөрийн нутаг дэвсгэр дээр орших СББӨ болон түүнийг өвлөн уламжлагч нарын олж тогтоох судалгааг мэргэжлийн судалгааны байгууллагатай хамтран хийх, ингэхдээ тухайн нутаг дэвсгэр дээр орших угсаатны бүлгийн СББӨ-ийн өвөрмөц онцлогийг заавал тусгах,
2. Өөрийн нутаг дэвсгэр дээр орших СББӨ-ийн Төлөөллийн болон Яаралтай хамгаалах шаардлагатай бүртгэл жагсаалтыг жил тутам боловсруулж, шинэчлэн баяжуулах,
3. СББӨ болон түүний өвлөн уламжлагчдийг баримтжуулах ажлыг өөрийн нутаг дэвсгэр дээр жил тутам хийж, баяжуулан шинэчлэх, СББӨ-ийн мэдээллийн санд архивлах.
4. 60-аас дээш насны СББӨ-ийн өвлөн уламжлагчийн бүртгэн баримтжуулалтыг нэн яаралтай хийх,

5. СББӨ-ийн бүс нутаг, олон улсын түвшинд судалгааг хөрш зэргэлдээ орших ижил төстэй СББӨ-ийн зүйлтэй улс орон, аймаг, судалгааны байгууллагатай хамтран хийх,
6. СББӨ-ийг өвлүүлэн уламжлуулах, түгээн сурталчилах, соён гэгээрүүлэх, сэргээн уламжлуулах, СББӨ-ийн өвлөн уламжлагч нарыг алдаршуулах, урамшуулах талаар хөтөлбөр хэрэгжүүлэх, жил тутамд орон нутгийн төсөвт тодорхой санхүүжилтийг суулгаж хэвших,
7. Өөрийн орон нутгийн өвөрмөц, онцлог СББӨ-д тулгуурлан аялал жуулчлалын брэнд, гарал үүслийн гэрчилгээ бүхий брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг бий болгох, хөхүүлэн дэмжих,
8. Засаг дарга нар нь өөрийн орон нутаг дахь соёлын өвийг хамгаалах талаар ард иргэд, мэргэжлийн байгууллагаас мэдээлэл авах, харилцан холбоотой, уялдаатай ажиллах зэргээр хамтын ажиллагааг бий болгож хэвшүүлэх.
9. Тус орон нутгийн оюутан залуучуул бакалаврын түвшинээс цааш үргэлжлэн магистр, докторын судалгаанд өөрийн аймаг сумдын хүрээнд өв соёлоо дээдэлсэн судалгааны ажил хийж “дадлагаа” орон нутгийн жишээн дээр хийх боломжтой.
10. Аймаг сумдын нийт иргэдэд соёлын төвөөс нь соёлын өвийн талаар олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх ажлыг (ямриа, танилцуулга, баримтат кино хийж хадгалах) шат дараалалтай хийх.

2.2.2. Монгол Улсын СББӨ-ийн хадгалалт хамгаалалтад нөлөөлж буй эрсдлийн судалгаа

Соёлын өвийг хамгаалагчдад зориулсан монголын соёлын өвийн хадгалалт хамгаалалтад нөлөөлж буй хүчин зүйлсийн газарзүйн зурагт лавлах боловсруулах, мэдээллийн санг бий болгох зорилгоор Швейцарын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр “Монголын соёлын өвийн хадгалалт хамгаалалтад нөлөөлж буй хүчин зүйлсийн газарзүйн зурагт лавлах” төслийн хүрээнд СББӨ-ийн чиглэлээр “Соёлын биет бус өвийн лавлах”, “СББӨ-ийн эрсдлийн атлас”-ыг тус тус боловсруулав.

“Соёлын биет бус өвийн лавлах”-д дараах мэдээллийг багтаав. Үүнд:

- Соёлын өвийн үндэсний төвийн УБМНС-д буй 5 ай савын 177 өвийн зүйлээс нийтлэг тархацтай, монгол соёлын өв уламжлалыг төлөөлөх 31 СББӨ-ийн төрөл зүйлийн тодорхойлолт
- Олон улс болон монгол улсад мөрдөгдөж буй эрх зүйн орчин
- СББӨ-ийн Үндэсний төлөөлөл болон Яаралтай хамгаалах шаардлагатай өвийн жагсаалт
- ЮНЕСКО-гийн СББӨ-ийн жагсаалтанд бүртгэгдсэн 13 өвийн танилцуулга
- 5 ай сав 31 өвийн төрөл зүйлийн тодорхойлолт болон өвлөн уламжлагчдын мэдээлэлд тулгуурласан 31 өвийн зүйл, 5 ай савын нэгдсэн тархалтын газрын зураг тус тус боловсрууллаа.



Соёлын биет бус өвийн эрсдлийн атлас.

Энэхүү эрсдлийн атласыг дараах үе шаттайгаар боловсруулав. Үүнд:

1. Мэдээлэл боловсруулах үе шат
 - Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн сангийн мэдээлэл”-ээс өвлөн уламжлагчдын насжилтыг мэдээллийг боловсруулах
 - Насны бүтцийг 31 өвийн төрөл зүйлд бүлэглэсэн.
 - Насны бүтцийг эрсдлийн ангилалд хуваасан
 - Бүлэглэсэн мэдээллийг газар зүйн мэдээллийн системд шилжжүүлсэн
2. Эрсдлийн газрын зураг боловсруулах үе шат
 - 31 өвийн төрөл зүйлд насны бүтцээр эрсдлийн тодорхойлж газрын зураг гаргах
 - 31 өвийн төрөл зүйлийн насны эрдлсийн зургийг холбогдох ай савд давхцуулан төрөлжсөн эрсдлийн зураг боловсруулах
 - Төрөлжсөн эрсдлийн зурагт орон зайн давхцуулалт хийх Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын насжилтын эрсдлийн нэгдсэн зураг гаргах

2010-2016 онд аймаг, сумын СББӨ-ийн бүртгэл, мэдээллийн сангаас СӨУНБМС-д цуглагдсан 177 СББӨ-ийн төрөл зүйлийн мэдээллээс монгол үндэстэн, угсаатныг төлөөлөх, нийтлэг 31 өвийн төрөл зүйлийг сонгосон ба тус өвийн зүйлийг өвлөн уламжлалж буй 3368 өвлөн уламжлагчийн мэдээлэл дээр түшиглэн “СББӨ-ийн эрсдлийн атлас”-ыг өвлөн уламжлагч нарын насны ангилал дээр тулгуурлан боловсруулав.

Эх хэл болон аман уламжлал, илэрхийллүүд	Үндэсний уламжлалт зан үйл, ёслол, баяр наадам	Ардын язгуур урлаг	Байгалийн болон сав ертөнцийн тухай мэдлэг, заншил, уламжлалт арга ухаан	Ардын уламжлалт гар урлал
Уриа дуудлага	Хурдан морь	Морин хуур	Цагаан идээ боловсруулах мэдлэг арга ухаан	Уран хатгамал, зүү ороох урлал
Ерөөл	Шагайн харваа	Исгэрээ	Хурдан морь шинжих, сойх мэдлэг, арга ухаан	Морин хуур урлал
Магтаал	Сурын харваа	Лимбэ	Уламжлалт анагаах ухаан	Уран дархны урлал
Бөхийн цол	Хуримын зан үйл	Ардын дуу	Адуутай холбоотой зан үйл, мэдлэг, арга ухаан	Монгол гутал урлал
Хурдан морины цол		Бий бийлгээ	Мал хатгах, эмчлэх уламжлалт ухаан	Сийлбэр урлал
Тууль		Уртын дуу		Эстий урлал
		Хөөмэй		Үндэсний хувцас урлал
				Арьс ширэн урлал
				Гар урлал

Сонгосон 31 өвийн төрөл зүйлийн өвлөн уламжлагчдын насны дунджийг сум бүрт тооцон гаргаж эрсдлийн 3 бүлэгт хуваан авч үзсэн. Үүнд:

Эрсдлийн утга	Насны дундаж
Их эрсдэлтэй	60-аас дээш
Дунд эрсдэлтэй	40-59
Бага эрсдэлтэй	40-өөс доош

Үндэсний Статистикийн газрын 2016 оны мэдээгээр монгол хүний дундаж наслалтыг 67 нас хэмээн үзсэний дагуу 60 дээш насны ангилалыг “их эрсдэлтэй” ангилалд тооцсон болно.

Судалгаанд хамрагдсан өвлөн уламжлагчдын эзлэх хувь нь 40-:09 насны хооронд насны ангилал бүрд өссөн үзүүлэлт илэрч байгаа бөгөөд 60 наснаас эргэн эргэн буурах хандлага нь уг насны өвлөн уламжлагч нар нь хорвоогийн жам ёсоор цөөрч буйтай холбоотой гэж үзэж болох байна.

Түүнчлэн, 10-39 насны ангилалд өвлөн уламжлагчдын эзлэх хувь бага, эсвэл огт байхгүй байгаа нь цаашид тус өвийн төрөл зүйлүүдийг уг насныханд өвлүүлэн уламжлуулахад төрийн бодлогоор хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зайлшгүй анхаарал хандуулах шаардлагатай байна.

Судалгаанд хамрагдсан бүх аймгуудын нийт хүн амын дунджаар 49,91%-ийг эзлэж байгаа 0-10 хүртлэх хүн амд цаашид СББӨ-ийн олон төрөл зүйлүүдийг балчир багаас нь алхам алхамаар нь ойгуулан таниулах, өвлүүлэн дамжуулах, хайрлан хүндлэх, хэвшүүлэх үйл ажиллагааг гэр бүл, боловсрол, олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагуудаар дамжуулан шат дараалан хэрэгжүүлдэг үндэсний тогтолцоог бий болгох шаардлагатай болохыг энэхүү судалгаа гэрчилж байна.

➤ Судалгааны үр дүн

1. “СББӨ-ийн лавлах” гарын авлага хэвлэгдэн гарсан.
2. “Соёлын өвийн эрсдлийн атлас” бүтээлүүдийг соёлын өвийн шат шатны шийдвэр гаргагч, Бүртгэл, мэдээллийн сангийн ажилтнууд болон соёлын өвийг “хамгаалагчид”-т түгээх зорилгоор тус бүр 300 ширхэг хэвлэсэн болно.

Соёлын өвийн төвийн мэргэжилтнүүдийн ГМС-ийн тухай мэдлэг ойлголт дээшилж ГМС-ийн ArcGIS програм ашиглан мэдээллийн сан үүсгэх, олон төрлийн орон зайн боловсруулалт хийх чадвартай болсон нь цаашдын соёлын өвийн судалгааны ажилд чухал ач холбогдолтой юм.

➤ Судалгааны ач холбогдол

Соёлын өв нь байгаль, хүрээлэн буй орчин, хүн, хүний нийгмийн хөгжлийн үйл явцтай хүн холбоотойн учир СББӨ-ийн тархалт, гээгдэл, хадгалалт хамгаалалтанд өвлөн уламжлагчдын насжилт хэрхэн нөлөөлж байгааг Монгол орны газар зүйн мэдээллийн системийн тусламжтайгаар энд анх удаа хөндөв.

Судалгаа нь СББӨ болоод түүний өвлөн уламжлагчдын газар зүйн байршил, насны бүтэц түүний үр нөлөөллийг тодорхойлон Монгол орны нийт нутаг дэвсгэрийг хамруулан газар зүйн мэдээллийн системд тулгуурлан хийсэн нь энэхүү судалгааны шинэлэг тал гэхэд болно.

СББӨ болон түүний өвлөн уламжлагчдын тархалт, сөргөөр нөлөөлөх эрсдлийн хүчин зүйл, түүний нөлөөллийн талаарх суурь судалгаагаар СББӨ-ийн хадгалалт хамгаалалтын менежмент, төлөвлөгөөг боловсруулах, үүсэж болох эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах зэрэг СББӨ-ийг сэргээн уламжлуулах, түгээн

дулгэрүүлэх, хадгалж хамгаалахад удирдамж, чиглэл болгоход бодит мэдээллийн сан бүхий загварчлал бий болгосон нь соёл судлалын салбарт шинэ судалгаа, судлагдахууны эхлэлийг тавьсанаараа энэхүү бүтээл СББӨ-ийг хамгаалахад суурь судалгаа болох практик ач холбогдолтой гэж үзэж байна.

Энэхүү судалгааны нийгмийн хэрэглээ, шинжлэх ухаанд оруулж буй хувь нэмэр нь дараах байдлаар илэрхийлэгдэж байна.

Шинжлэх ухааны хувьд:

1. Соёл судлалын үүднээс СББӨ-ийг байгаль, нийгмийн олон талт хүчин зүйлс, байгалийн шинжлэх ухааны судалгаан дээр үндэслэн судлах, арга зүйн хандлага, чиглэлийг бий болгосон.
2. Монгол улсын нутаг дэвсгэр дэх СББӨ-ийг таньж илэрүүлэх, өвлөн уламжлагч нарыг судалж тогтоох, өвлүүлэн уламжлуулах, хадгалж хамгаалах өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ, үнэлгээ хийх боломж бүхий атлас зураглалыг боловсруулсан.
3. СББӨ-ийн хадгалалт хамгаалалтыг газар зүйн шинжлэх ухааны дэвшилтэт технологи, арга зүйтэй хослуулан хийсэн.

Нийгмийн хэрэглээний хувьд:

1. СББӨ-ийг газар зүйн байршил бүхий байр зүйн зураглалыг хийснээр дурсгалын тархалт, нягтаршил, газар зүйн онцлогтой уялдуулан тухайн соёлыг бүтээгч ард түмний эдийн болон оюун ухаан, соёлын хүрээний судлал, соёл хоорондын харилцан хамаарал зэргийг эрдэм шинжилгээ, сургалт, судалгаа, шинэ мэдлэг, соёлын инновац, соёлын үйлдвэрлэл, аялал жуулчлал, бүтээгдэхүүн болгох зэрэг олон чиглэлээр цаашид салбарлан судлах, хөгжүүлэх боломж бий болгосон.
2. СББӨ-ийн тархалт, гээгдэл, өвлөн уламжлагчдын насжилтын зураглалыг тулгуурлан хадгалалт хамгаалалтын бодлогыг оновчтой болгох, эдийн засаг, хөрөнгө хүчийг зөв хувиарлах нөхцлийг бүрдэнэ.
3. СББӨ-ийг хадгалж хамгаалах талаар төрийн болон орон нутгийг өөрөө удирдах байгууллага (шийдвэр гаргагч, бодлого тодорхойлогч нарт) болон холбогдох бусад байгууллагууд бодлого, үйл ажиллагаа, төлөвлөгөөндөө тусгах суурь хэрэглэгдэхүүнийг бий болгосон зэрэг болно.

Байгалийн хүчин зүйлс:

- ✓ Ган,
- ✓ Зуд гэх мэт байгаль болон хүн нийгмийн хүчин зүйлсийг тодорхойлсон хэдий ч судалгааны ажлын цаг хугацаа, мэдээлэл боловсруулах, арга зүй, хүний нөөц зэрэг хүчин зүйлсээс шалтгаалж энэ удаагийн судалгааны нөлөөллийн хүчин зүйлсийн бүрэн хамарч чадаагүй. Цаашид, СББӨ-ийн хадгалалт хамгаалалт, өвлөгдөл, гээгдэлт нөлөөлж буй хүн нийгмийн хүчин зүйлсийг дээр дурьсан хүчин зүйлстэй холбон дэлгэрэнгүй судлах зайлшгүй шаардлага байна.

Түүнчлэн, судалгаанд Улаанбаатар хот дахь СББӨ болон түүний өвлөн уламжлагч нарын судалгаа хамруулаагүй болно. Улаанбаатар хотын СББӨ-ийн

тархалт, гээгдэл болон түүний өвлөн уламжлагчдын насжилтын судалгааг шилжилт хөдөлгөөн, эдийн засаг, хотжилт зэрэг бусад хүн нийгмийн хүчин зүйлстэй уялдуулан нарийвчлан гаргах шаардлагатай хэмээн үзсэн болно.

Дүгнэлт

1. Тус судалгааны ажил нь соёлын өвийг хадгалаж хамгаалахад ач холбогдолтой, цагаа олсон шаардлагатай суурь судалгаа болж чадсан,
2. Анх удаагаа СББӨ-ийн тархалт, эрсдэлийг тогтоож газар зүйн орон зайн мэдээллийг ашиглан атлас зурагт хөврүүлэн буулгасан,
3. Цаашид эрдэмтэн судлаач, оюутан залууст судалгааны эргэлтэнд оруулах гарын авлага, хөтөч бүхий хэрэглэгдэхүүн болсон,
4. Мөн орон нутгийн удирдлага, Засаг дарга нарт чиглэсэн зааварчилгаа, зөвлөмжийг дагалдуулан боловсруулсан их үр дүнтэй, сайшаалтай судалгааны бүтээл боллоо хэмээн холбогдох яам, эрдэм шинжилгээний байгууллагын төлөөллүүд 4 удаагийн нэгдсэн зөвлөлдөх уулзалтаар үнэлж байлаа.

2.3. Соёлын биет бус өвийн тайлбар толь боловсруулах:

СББӨ-ийн тайлбар толь-Соёл аль ч оронд онцгой үүрэгтэй бөгөөд түүнийг бүх хэлбэр, төрлөөр нь хадгалан хамгаалж, сурталчлан дэлгэрүүлж, сурган өвлүүлэх хүндтэй үүрэг хүлээсэн СУИС болон Соёлын өвийн төв хамтран “Соёлын Биет бус өвийн тайлбар толь” хамтран бүтээхээр болов. Энэ хүрээнд СУИС-ийн Эрдэм шинжилгээ, инновацийн газрын дарга, доктор /Ph.D/, дэд профессор Д.Даваасүрэн 2017 оны 02 сарын 02-нд тайлбар толь хэрхэн бүтээх талаар ярилцан, аргазүйн зөвлөгөө өгч, “Соёлын биет бус өвийн тайлбар толь” номын агуулгыг ярилцаж эхний удаа толгой үг-663 /холбогдох өвийн нэрс, холбогдох холбогдох ном зохиолын нэрс /номзүй-160 ном/-ийг түүвэрлэн, анхан шатны боловсруулалтыг хийв.

а. СББӨ-ийн төрөл зүйл,

б. Цагаан толгойн үсгийн дарааллаар гэсэн 2 хувилбараар нэрсийг бэлтгээд байна.

Цаашид: Үг хэллэг, тодорхойлолт, онолын нэр томъёог зөв томъёолох, зөв эрэмбэлэх, сэдвийг толгойлон оруулах тал дээр хувилбараа сонгох зэрэг сайжруулах шаардлага гарч байна.

2.4 Монгол Улсын СББӨ-ийн Үндэсний жагсаалтыг баяжуулан боловсруулах:

Монгол Улсын СББӨ-ийн Үндэсний жагсаалт шинэчлэн баяжуулах ажлын хүрээнд салбар зөвлөлийн гишүүдээр хэлэлцүүлж өвийн урьдчилсан жагсаалтыг гаргасан.

Соёлын өвийн үндэсний төвөөс 5 ай савын хүрээнд урьдчилсан байдлаар:

1-р ай сав буюу Эх хэл болон аман уламжлал, илэрхийллүүд – 240 өвийн төрөл зүйл

2-р ай сав буюу Ардын язгуур урлаг – 184 өвийн төрөл зүйл

3-р ай сав буюу Үндэсний уламжлалт зан үйл, ёслол, баяр наадам -528 өвийн төрөл зүйл

4-р ай сав буюу Байгалийн болон сав ертөнцийн тухай мэдлэг, заншил, уламжлалт арга ухаан – 206 өвийн төрөл зүйл

5-р ай сав буюу Ардын гар урлал – 594 өвийн төрөл зүйл нийт **1752** өвийн төрөл зүйлийг анхан шатны байдлаар тодорхойлон Үндэсний жагсаалтанд бүртгэх, шүүн хэлэлцэх асуудлыг Мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэхээр боловсруулаад байна. Мэргэжлийн зөвлөлийн журам, бүтэц, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах, улмаар хурлын тов зарлагдах зэрэг асуудлаас болж хойшлогдсон болно.

4.Дотоод ажил, үйлчилгээ

4.2. СББӨ-ийн анхан шатны цаасан суурьтай бүртгэлийг шивж дуусгах, цахим хэлбэрт оруулах.

- Бүртгэлийн зорилго нь: Тухайн аймаг (дүүрэг), сумын (хороо) нутаг дэвсгэр дэх СББӨ-ийг хамгаалах, хойч үед өвлүүлэх, төрөөс дэмжих харилцааг зохицуулахад тухайн шат бүхэндээ эх хэрэглэгдэхүүн болдог. СББӨ-ийн бүртгэл мэдээллийн үндсийн үндэс, анхдагч эх үүсвэр болсон анхан шатны бүртгэл мэдээллийг бүрдүүлэх ажилд онцгой анхаарал тавих нь бүртгэлийн тулгамдсан асуудал болж байгаа бөгөөд энэ онд Соёлын өвийн үндэсний төвийн УНБМСангийн бүртгэл дээр нэмж, 2014 онд цаасан суурьтай цуглагдсан Архангай аймгийн 168, Говьсүмбэр аймгийн 35, -Орхон аймгийн 76, Төв аймгийн 21, Увс аймгийн 5, Өвөрхангай аймгийн 138, Өмнөговь аймгийн 44, нийт 487 өвлөгчийг нэмж бүртгэн холбогдох асуултаар нэмж цахим хэлбэрт оруулсан. Цаашид Excel файлд шивж оруулсан мэдээллүүдийг СББӨ-ийн бүртгэлийн хэрэглээний програмд шилжүүлэх, цахим хэлбэрт оруулж сайжруулах, боловсронгуй болгох шаардлага тавигдаж байна.

4.3. Соёлын биет бус өвийн баримтжуулалт, мэдээллийн санг цэгцлэх, цахим хэлбэрт оруулах ажил.

4.3.1. СББӨ-ийн Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн сан дахь дүрс бичлэгүүдийн товъёогыг цахим хэлбэрт шивж оруулах.

- DV cam 716 ширхэг буюу 716 цагийн дүрс бичлэгнээс 100 ширхэг буюу 100 минутын dv хальсыг digital болгон цахим хэлбэрт шилжүүлэн товъёогжуулсан архивлан хадгалсан.
DV хальс хөрвүүлдэг камер нь 1999 оноос хойш хэрэглэж ирсэн бөгөөд ашиглалтын элэгдэлд орж эвдэрсэн тул Соёлын биет бус өвийн Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд хадаглагдаж буй үлдэгдэл 616 цагийн DV хальсыг тул хальс хөрвүүлэх ажил одоогоор түр зогссон ба цахим хэлбэрт шилжүүлэхэд DV хальс хөрвүүлдэг камер шаардлагатай болоод байна.

4.3.2. СББӨ-ийн Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн сан дахь дүрс бичлэгүүд дээр тулгуурлан олон нийтэд зориулсан танин мэдэхүйн агуулгыг боловсруулах.

- Олон нийтэд зориулан Адууны соёл, Икэл хуур, Мал тойглох, Монгол гэр, Мөсөн шагай гэсэн 5-н сэдвийн дагуу 3-5 минутын хялбаршуулсан танин мэдэхүйн танилцуулгын /шторк/ судалгааны бичвэрүүдийн агуулгыг

боловсруулж соёлын өвийн бүртгэл мэдээллийн санд хадгалагдаж байгаа дүрс бичлэгийг ашиглан шаардлагатай нэмэлт дүрс бичлэгийг цуглуулж эвлүүлгийн ажил хийгдэж байна.

Монгол гэр, Мөсөн шагай сэдвээр “Монголын үндэсний олон нийтийн радио телевиз”, “Байгаль соёлын өвийг хамгаалах сан” төрийн бус байгууллагатай хамтран “Монгол гэрийн уламжлалт урлал зан үйл, ёс билгэдэл”, “Таван эрдэнийн шагай” хэмээх 2 баримтат киног бүтээсэн.

4.3.3. СББӨ, өвлөн уламжлагчидтай холбогдолтой түүх намтар, гэрэл зураг зэрэг цаасан суурьтай мэдээллийг цахим хэлбэрт оруулж, холбоос үүсгэх.

- Соёлын биет бус өвийн програм хангамжийг сайжруулах, шинэчлэх, хэрэглэгчийн шаардлага тодорхойлох, өгөгдлийн сангийн зохион байгуулалт, программын кодчиллол, интернет кодчиллол зэргийг хийхэд шаардлагатай Соёлын биет бус өвийн жагсаалт, өвийн нэр, зураг, дүрс бичлэг зэрэг програмд нэмэлтээр оруулах өгөгдлүүдийн судалгааны ажил хийгдэж байна.

4.4 ЮНЕСКО-гийн СББӨ-ийн тухай Конвенцийн Монгол Улсын хэрэгжилтийн тайланг боловсруулж илгээх-

4.4.1 Хүн Төрлөхтний СББӨ-ийн жагсаалтад Монгол Улсаас бүртгэгдсэн өвийн хадгалалт хамгаалалт, Конвенцийн хэрэгжилтийн тайланг боловсруулж илгээх.

4.4.2 Яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн жагсаалтад 2013 онд бүртгэгдсэн “Монгол уран бичлэг”-ийн хадгалалт хамгаалалтын хугацаат тайланг боловсруулж илгээх.

Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын 2017 оны 05 дугаар сарын 11-ны өдрийн “Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай” А/192 тоот Тушаалаар ЮНЕСКО-ийн 2003 оны “Соёлын биет бус өвийг хамгаалах тухай” конвенцийн хэрэгжилтийн тайлан болон ЮНЕСКО-ийн Хүн төрөлхтний яаралтай хамгаалах соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгэгдсэн Монгол цуур, Монгол бий биелгээ, Монгол тууль, Монгол Уран бичлэг өвийн хугацаат тайланг бэлтгэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж, Тайланг зохих шаардлагад нийцүүлэн бэлтгэж, 2017 оны 3 дугаар улиралд багтаан танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч /Г.Энхбат/-д даалгасан болно.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн:

Ажлын хэсгийн ахлагч: Г.Энхбат
Ажлын хэсгийн гишүүд: М.Цэцэнбилэг / ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний комиссын Соёлын асуудал хариуцсан мэргэжилтэн/
С.Юндэнбат /Соёл Урлагийн их сургуулийн Соёлын сургуулийн багш/
А.Саруул /Соёлын өвийн төвийн Соёлын биет бус өвийг хамгаалах хэлтсийн дарга/
Б.Наранбат /”Хүннү” цуурын холбооны тэргүүн, судлаач/

Н.Уртнасан /Байгаль, соёлын өвийг хамгаалах сангийн тэргүүн/

Ц.Цэндсүрэн /Соёл судлаач/

Б.Кату /ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн аман зохиол судлалын секторын эрхлэгч/

Д.Батбаяр /Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч/

Ц.Жаргалсайхан /Соёлын биет бус өвийн нийгэмлэгийн тэргүүн/

Ш.Эрдэнэцэцэг /Соёл урлагийн их сургуулийн Бүжгийн урлагийн сургуулийн захирал/

Нарийн бичгийн дарга: Д.Мэндсайхан /Соёл, урлагийн газрын мэргэжилтэн/

Ажлын хэсэг нь Соёлын биет бус өвийн ЮНЕСКО-д хүргүүлэх тайланг боловсруулах төлөвлөгөө гарган 2017 оны 5 дугаар сараас 12 дугаар сарын 15-ны хооронд нийт 4 удаагийн ажлын хэсгийн уулзалт, хурлыг хийж ЮНЕСКО-д бүртгэгдсэн өвүүдийн хугацаат тайлан болон хэрэгжилтийн тайланг боловсруулан орчуулж 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдөр ЮНЕСКО-д илгээсэн болно.

Тайланг англи хэлрүү хөрвүүлэх ажлыг ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний комиссын Соёлын асуудал хариуцсан мэргэжилтэн М. Цэцэнбилэг, Ч.Цэцэгбаатар, Соёлын өвийн үндэсний төвийн мэргэжилтэн Ц.Цолмон нар хийж Соёлын биет бус өвийг хамгаалах хэлтсийн дарга А.Саруул хянасан.

Тайлангийн цахим хувилбарыг 2017 оны 12 дугаар сарын 15-ны дотор Соёлын өвийн үндэсний төвийн cch@monheritage.mn хаягнаас ЮНЕСКО-ийн 2003 оны соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенцийн нарийн бичгийн дарга нарын газрын ich-reports@unesco.org хаяг руу илгээж тайланг хүлээн авсан тухай хариу мэдэгдлийг хүлээж авсан болно. Тайлангийн эх хувийг хүргүүлэх ажлыг ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний комисс хариуцсан.

Тайлангийн Монгол, англи хувийг цахим хэлбэрээр БСШУСЯ, ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний комисс, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газар, Парис дахь Монгол улсын элчин сайдын яамнд тус тус илгээж Соёлын биет бус өвийн УНБМСанд архивлан хадгалсан.

ЮНЕСКО-д илгээсэн өвүүдийн тайлангийн нэрс:

ЮНЕСКО-гийн 2003 оны “Соёлын биет бус өвийг хамгаалах тухай” конвенцийн хэрэгжилтийн тайлан.

Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн Төлөөллийн жагсаалтад бүртгэгдсэн өв (нийт 40 хуудас)

Монгол ардын уртын дуу (2008)

Морин хуур хөгжмийн уламжлалт урлаг (2008)

Монгол баяр наадам (2010)

Монгол хөөмэйн уламжлалт урлаг (2010)

Шувуулахуй (2010)

ЮНЕСКО-гийн Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгэгдсэн;

Монгол цуур хөгжмийн урлаг (2009он, 21 хуудас)

Монгол бий биелгээ (2009 он, 20 хуудас)

Монгол тууль (2010 он, 21 хуудас)
Монгол Уран бичлэг (2013 он, 15 хуудас)

4.5. ЮНЕСКО-гийн санхүүжилтээр хэрэгжиж буй “Монгол туулийн уламжлалыг хадгалан хамгаалах, сэргээн амилуулах” төслийн хаалтын ажиллагаа ба Монгол Тууль цуврал ботиудын нээлтийн ёслол-

“Монгол туулийн уламжлалыг хадгалж хамгаалах, сэргээн амилуулах нь” төслийн хүрээнд болон БСШУСЯ-ны санхүүжилтээр Соёлын өвийн үндэсний төвөөс эрхлэн хэвлүүлсэн монгол туульсын зохиолын 12 боть номыг төслийн хүрээнд хэвлэсэн.



Монгол туулийг гүнзгийрүүлэн судлаж нийт монголчуудын түүх, шашин шүтлэг, зан үйл, ёс суртахуун, хууль ёс, гүн ухаан, сэтгэл зүй, хэл аялгуу, нийгэм ахуйн онцлог, тэдгээрийн хөгжил хувьслын мөн чанарыг тогтооход чухал ач холбогдолтой юм. Эдгээр боть номуудыг Үндэсний номын сангаар дамжуулан орон нутгийн номын сангуудаар дамжуулан олны хүртээл болгон түгээсэн.

Монгол туулийн уламжлалыг хамгаалах, дахин сэргээх нь” төслийн хүрээнд хэвлэгдсэн Монгол туулийн 12 боть цуврал номын нээлт 2017.01.31-нд БСШУСЯ-нд болж, нээлтийн арга хэмжээнд БСШУСЯ-ны Соёл, урлагийн бодлогын газрын дарга Н.Болд нарын холбогдох албаны хүмүүс оролцов.

Энэхүү цуврал ботийг бүтээхэд “Хэл зохиолын хүрээлэн”-гийн эрдэм шинжилгээний ажилтан доктор Б.Катуу, Т.Баясгалан, А.Алимаа, соёл судлаач С.Юндэнбат, өвлөн уламжлагч Э.Баатаржав, А.Балдандорж, Ховд их сургуулийн багш, тууль судлаач, доктор М.Ганболд, нар хамтран ажиллав. Монгол туулийн эхний 10 ботийг ЮНЕСКО-гийн санхүүжилтээр, 1-12 дугаар ботийг БСШУСЯ, Соёлын өвийн төв хамтран төсвийн санхүүжилтээр тус тус хэвлүүлсэн.

Тус арга хэмжээг www.montsame.mn, www.news.mn, [www.national art council](http://www.nationalartcouncil.mn) болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгсэл, ТВ-үүдээр сурталчилсан болно.



Түүнчлэн Монгол Улсын Засгийн газар, ЮНЕСКО-гийн 2013-2016 онд хамтран хэрэгжүүлсэн “Монгол туулийн уламжлалыг хамгаалах, сэргээн амилуулах нь” төслийг амжилттай хэрэгжүүлж дууссан. Төслийн хүрээнд дараах үйл ажиллагааг зохион байгуулсан байна. Үүнд:

- Ховд, Увс, Баян-Өлгий аймагт туулийн урын сангийн судалгаа, туульчдыг бүртгэн 1950 минутын баримтжуулалтыг хийж, мэдээллийн сан үүсгэв.
- Монгол туулийг удам дамжин өвлүүлэн уламжилж ирсэн 11 туульчтай гэрээ хийж, шавь сургалтыг зохион байгуулжээ. Ингэснээр өнөөдөр тууль сонирхон суралцаж буй 30 гаруй шинэ залуу туульчдаар өвлөн уламжлагч шавь сурагчаар хүрээгээ тэлсэн байна.
- Олон нийтийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх үйл ажиллагааны хүрээнд МҮОНРТ-тэй хамтран зургаан цуврал нэвтрүүлэг, “Оллоо” телевизтэй хамтран хоёр цуврал нэвтрүүлэг, мөн “Сэмүүн” студитэй хамтран нэг баримтат кино хийж олны хүртээл болгожээ.
- “Богд хааны ордон музей”-тэй хамтран 2014 онд “Хаан туульсын өргөө”-г нээж тууль хайлах болон туультай холбоотой ёслол хүндэтгэлийн зан үйлийг сурталчилж байна.

4.6. СББӨ-ийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-уудын сүлжээг бий болгож, үйл ажиллагааг нь идэвхжүүлэх-

4.6.1.ТББ-уудтай уулзалт зохион байгуулж, СББӨ-ийг түгээн сурталчилах, хадгалан хамгаалах, өвлүүлэн уламжлуулах, судлах чиглэлээр хамтын ажиллагааг идэвхжүүлэх, өөр өөрсдийн чиглэлээр явуулж буй үйл ажиллагааны танилцуулга, тайланг хэлэлцэх.

- Соёлын өвийн үндэсний төвийн санаачлагаар БСШУСЯ, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, Урлагийн газар, ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комисстой хамтран соёлын биет бус өвийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллагуудын чуулга уулзалтыг 2017 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр амжилттай зохион байгуулсан.

Энэхүү уулзалт нь соёлын биет бус өвийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудтай соёлын биет бус өвийг хамгаалах ажилд төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудын үүрэг оролцоог нэмэгдүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, тэдний хамтын ажиллагааг эрчимжүүлэх, үүрэг оролцоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагаа, мэдээлэл солилцооны нэгдсэн сүлжээ бий болгох талаар санал солилцох зорилготойгоор зохион байгуулагдав.

Уулзалтанд соёлын биет болон биет бус өвийг хамгаалах, судлах, сурталчилах, өвлүүлэн уламжлуулах зорилгоор үйл ажиллагаа явуулж байгаа 28 төрийн бус байгууллагын төлөөлөл, өвлөн уламжлагчид болон Соёлын өвийн үндэсний төв, Соёл, урлагийн газар, ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс зэрэг төрийн байгууллагыг төлөөлж нийт 45 хүн оролцов.

Тус уулзалтын хүрээнд төрийн бус байгууллагуудыг мэдээллээр хангах зорилгоор дараах илтгэлүүдийг зохион байгуулагчдын зүгээс тавьж, холбогдох хэлэлцүүлгийг хийсэн.

1. СББӨ-ийн чиглэлээр баримталж буй бодлого /БСШУСЯ-ны СУБГазрын соёлын өв хариуцсан мэргэжилтэн Г.Ичинхорлоо/
2. Соёлын өвийн төвийн чиг үүрэг, СББӨ-ийн статистик мэдээлэл /Соёлын өвийн Үндэсний төвийн СББӨХХ-ийн дарга А.Саруул/
3. СББӨ-ийг хадгалж хамгаалахад Төрийн бус байгууллагуудын үүрэг оролцоо. /"Байгаль болон Соёлын өвийг хамгаалах сан" ТББ-ийн тэргүүн Н.Уртнасан/
4. ЮНЕСКО-гийн зарчим, чиг үүрэг /ЮНЕСКО-гийн СББӨ хариуцсан мэргэжилтэн М.Цэцэнбилэг/
5. Соёлын биет бус өвд суурилсан Бүтээлч үйлдвэрлэл /Соёл, Урлагийн газрын Соёл, Соёлын өвийн хэлтсийн дарга Г.Батхуяг/

Хэлэлцүүлгийн үеэр төрийн бус байгууллагуудаас тэдний үйл ажиллагааг төр засгийн бодлогын хүрээнд дэмжих, шаардлагатай төсөв хөрөнгийг төсөвт суулгаж өгөх, соёлын биет бус өвийг хамгаалахад өвлөн уламжлагч, төрийн болон төрийн бус байгууллагуудын идэвхи чармайлтаас гадна олон нийтийн, тухайлбал оюутан залуус, энгийн иргэдийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх, төрийн бус байгууллагууд хамтран ажиллах, мэдээлэл солилцох боломж бололцоог бий болгох шаардлагатай байгааг төрийн бус байгууллагын төлөөллүүд хэлж байв.

Уулзалтаас гаргасан санал, санаачлагыг цаашид холбогдох байгууллагууд анхааралдаа авах, бодлого үйл ажиллагаандаа тусгаж ажиллахыг төрийн болон төрийн бус байгууллагууд чухалчилж байв.

Уулзалтаас гарсан санал санаачлагыг үндэслэн Соёлын өвийн үндэсний төвөөс Соёлын биет бус өвийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын хоорондын уялдаа холбоог сайжруулах, мэдээлэл солилцох, ТББ-уудын мэдээллийг оруулах буланг Соёлын өвийн үндэсний төвийн цахим хуудсанд нэмэх, Соёл урлаг хөгжүүлэх сан, БСШУСЯ-наас ТББ-уудаар гүйцэтгүүлэх ажлыг сонгон шалгаруулах зарчимаар гэрээ байгуулж ажиллах талаар саналыг хүргүүлэхээр тогтсон.

ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНД ТУСГАГДААГҮЙ, НЭМЭЛТ ХИЙГДСЭН АЖИЛУУД

ЮНЕСКО-ИЙН СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙГ ХАМГААЛАХ ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН 12 ДУГААР ХУРАЛДААНД МОНГОЛЫН ТӨЛӨӨЛӨГЧИД ОРОЛЦСОН ТУХАЙ ТАЙЛАН

ЮНЕСКО-ийн Соёлын биет бус өвийг хамгаалах Засгийн Газар Хоорондын Хорооны 12 дугаар хуралдаан Бүгд Найрамдах Солонгос улсын Жежү арал дахь Олон Улсын Конвенийн төв дээр 2017 оны 12 дугаар сарын 04-өөс 09-ний өдрүүдэд зохион байгуулагдлаа. Хуралдаанд Конвенцийн гишүүн 175 орны төлөөлөл, хөндлөнгийн ажиглагч нийлсэн 800 орчим хүн оролцов.

Уг хуралд Монгол улсыг төлөөлж БСШУСЯ-ны Соёл, Урлагийн Бодлогын Газрын дарга Н.Болд тэргүүтэй 11 хүний бүрэлдэхүүнтэй баг оролцлоо. Багийн бүрэлдэхүүнд, ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний Комиссын Ерөнхий Нарийн бичгийн дарга С.Уянга, БСШУСЯ-ны соёлын биет өв хариуцсан мэргэжилтэн Б.Даваацэрэн, ЮНЕСКО-ийн итгэмжит Байгаль, соёлын өвийг хамгаалах сангийн тэргүүн Н.Уртнасан, Соёлын өвийн үндэсний төвийн гадаад харилцааны мэргэжилтэн Ц.Цолмон, ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний Комиссын соёлын асуудал хариуцсан мэргэжилтэн М.Цэцэнбилэг, “Тэнгэр аялгуу” хамтлагийн 5 гишүүн багтсан.



Тус хурлын хэлэлцэх асуудлын 11 а хэсэгт Үнэлгээний хэсгийн дарга Монгол Улсаас тус жагсаалтанд нэр дэвшүүлсэн **“Уул овоо тахих Монгол зан үйл”** өвийн материалд хийсэн Үнэлгээний хэсгийн хяналт, дүгнэлтийг танилцуулж, тодруулга материалыг хэлэлцсэн. Тодруулганд хүргүүлсэн материалыг хангалттай гэж үзээд, жагсаалтанд бүртгэхийг дэмжиж, шалгуур U1-ээс U5 хүртэл батлаж “Уул, овоо тахих Монгол зан үйл”-ийг ЮНЕСКО-ийн Яаралтай Хамгаалах Шаардлагатай Соёлын Биет Бус Өвийн Жагсаалтад бүртгэснийг албан ёсоор зарлав.

Хурлын явцад Хорооны дэргэдэх Үнэлгээний хэсэг 2017 онд Конвенцийн хэрэгжилтийн 11 хугацаат тайлан, Яаралтай Хамгаалах Шаардлагатай СББӨ-ийн жагсаалтанд бүртгэгдсэн 12 өвийн тайлан, Яаралтай Хамгаалах Шаардлагатай Соёлын Биет Бус Өвийн жагсаалтанд нэр дэвшүүлсэн 6 өвийн материал, Хүн Төрөлхтөний Соёлын Биет Бус Өвийн жагсаалтанд нэр дэвшүүлсэн 35 өвийн материал, жагсаалтаас хасах буюу шилжүүлэх 1 хүсэлт, Олон улсын тусламж хүссэн 3 хүсэлт, Сайн хадгалалт, хамгаалалтын жагсаалтанд нэр дэвшүүлсэн 4 төсөл, ТББ-ыг магадлан итгэмжлүүлэх 50 хүсэлт, 2012 онд магадлан итгэмжлэгдсэн

59 ТББ-ын тайланд шалгалт хийж, холбогдох шийдвэрийн саналыг Хороонд хүргүүлснээ танилцуулсан. Үнэлгээний хэсгийн дүгнэлтэнд Монгол, Турк, Палестин, Сенегал, Филиппин зэрэг хэд хэдэн улсаас санал хэлэв.

Монгол улсаас дараах саналыг хэлсэн:

“Соёлын Биет Бус Өвийг Хамгаалах тухай конвенийг хэрэгжүүлэх “Үйл Ажиллагааны Удирдамж”-ын I бүлгийн нэгдүгээр хэсгийн U5 (Яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн жагсаалт) болон R5 (Төлөөллийн жагсаалт) хэсэгт уг өвийн зүйл нь конвенцийн 11, 12-р зүйлд заасны дагуу түүнийг нэр дэвшүүлэн өргөн барьж байгаа гишүүн улсын нутаг дэвсгэр дээрхи биет бус өвийн бүртгэлд орсон байх гэж заасан. Дээрхи хоёр жагсаалтанд хийсэн Үнэлгээний хэсгийн шийдвэрийн саналын зарим хэсгийг ерөнхийд нь хүлээн зөвшөөрч, зарим хэсгийг хүлээн зөвшөөрөх боломжгүй байна. Тухайлбал, Үнэлгээний хэсэг нэр дэвшүүлсэн файлд өвтэй холбогдолтой хийгдэж байгаа байнгын бүртгэл, тооллого, түүний шинэчлэлийг тодруулах эрхтэй ч тухайн улс шаардлагатай мэдээллээр хангахад хэрхэн ажиллах аргачлалыг нарийн тодорхой зааж өгөөгүй нь хүндрэл учруулж байна. Гишүүн улсуудын Конвенцид элссэн он, хуримтлуулсан туршлага харилцан адилгүй тул нэгдсэн нэг зааварчилгааг энэ хэсэгт өгөх шаардлагатай гэж үзэж байна”.

ЮНЕСКО-ийн Соёлын Биет Бус Өвийг Хамгаалах Засгийн Газар Хоорондын Хуралдаанд Монгол Улсаас анх удаа өргөн бүрэлдэхүүнтэй баг явсан нь, мөн Соёлын өвийн үндэсний төвийн төлөөлөл оролцсон нь хурлын туршид Монгол улсын оролцоо, тухайлбал хэлэлцэж байгаа асуудлуудад санал хэлэх, бусад гишүүн улсуудад дэмжлэг үзүүлэх болон зохион байгуулалтын холбогдолтой асуудлыг шийдвэрлэх, хурлын явцыг биечлэн ажиглах, Монгол улсын үүрэг оролцоог тодорхойлох, Хорооны гишүүн улсууд болон бусад Конвенцийн Гишүүн улсуудтай харилцах, хамтран санал солилцох, цаашлаад дараа дараагийн хуралд баг бүрэлдэхүүн, мэргэжлийн шинжээчдийн оролцоог тодорхойлоход арвин туршлага хуримтлуулсан ажил боллоо.

- Швейцарын хөгжлийн сангийн “Соёл, урлаг дэмжих төсөл”-ийн хүрээнд хэрэгжиж буй “Монголын соёлын өвийн хадгалалт хамгаалалтад нөлөөлж буй хүчин зүйлсийн газарзүйн зурагт лавлах (түүх соёлын үл хөдлөх дурсгал, СББӨ)” -ийн Зөвлөлдөх багийн уулзалтыг 2017 оны 2 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулав.
- ЮНЕСКО-гийн Конвенцийн хэрэгжилтийн хөндлөнгийн аудитор, антропологч Хэгэ Монгол Улсад хөндлөнгийн үнэлгээ хийх албан томиллын хүрээнд зохион байгуулах ажлыг 2017 оны 3 дугаар сарын 20-23-ны өдрүүдэд хийж гүйцэтгэв.
- 2017 оны 5 дугаар сарын 23-ны өдөр Сүхбаатарын талбай дээр “Соёл, урлагийн байгууллагуудын нээлттэй өдөр”-ийн арга хэмжээнд СӨТ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж оролцсон.
- 2017 оны 6-р сарын 8-16-ны өдрүүдэд БНХАУ-ын Сичуан мужийн Чэнду хотно зохион байгуулагдсан СББӨ-ийн олон улсын наадам, СББӨ-ийн олон улсын форум, ЮНЕСКО-гийн СББӨ-ийн Засгийн газар хоорондын “Конвенцийн хэрэгжилтийн цар хүрээ, үр дүнг тогтоох нь” бүлгийн хэлэлцүүлэгт оролцлоо.

Мэргэжил, арга зүйн сургалт:

- Баянхонгор аймгийн Боловсрол, соёлын газраас хэрэгжүүлж байгаа “Соёлын ажилтнуудыг чадавхижуулах нь” хөтөлбөрийн хүрээнд БСӨХХэлтсийн дарга Д.Нарантуяа, БСӨХХэлтсийн мэргэжилтэн Ж.Насанжаргал нар 2017 оны 5 дугаар сарын 20-23-ны өдрүүдэд Баянхонгор аймгийн сумдын соёлын өв хариуцсан ажилтнуудад “Соёлын биет бус өвийг бүртгэх”, “Биет бус өвийг өвлөн уламжлагчийг тодруулах, бүртгэх арга зүй”, “Соёлын өвийг хамгаалах тухай хууль эрх зүй”, “Биет соёлын өвийг бүртгэх, мэдээллийн сан бүрдүүлэх тухай”, “ОНСТанхимын үзүүлэлэг дэглэлт” зэрэг сэдвүүдээр мэргэжил арга зүйн сургалт өгч хичээл заав.
- 2017 оны 2 дугаар сарын 9-10-ны өдрүүдэд Нийслэлийн Соёл, урлагийн газартай хамтран Улаанбаатар хотын дүүргүүдийн соёлын мэргэжилтнүүдэд “СББӨ-ийн бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх арга зүй” 2 өдрийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтанд “СББӨ-ийн Конвенци, олон улсын механизм”, “СББӨ-ийн суурь зарчим”, “СББӨ-ийн Улсын бүртгэл мэдээллийн сангийн анхан шатны бүртгэлийн өнөөгийн байдал, анхаарах асуудал” сэдвээр хичээл орж, бүлгийн ажлыг удирдан зохион байгуулав.



- 2017 оны 11 дүгээр сарын 03, 04-ний өдрүүдэд дөрвөн жил тутам зохион байгуулагддаг “Боржигин уртын дуу, морин хуур” эрдэм шинжилгээний бага хурал, бүсийн Уртын дуу, Морин хуурын уралдаан Говьсүмбэр аймгийн “Боржигин” чуулгад амжилттай болж өнгөрлөө.

Эрдэм шинжилгээний бага хуралд Говьсүмбэр аймгийн удирдлагууд, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газар, Соёлын өвийн Үндэсний төв, ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний Комисс, Дорноговь, Дундговь, Хэнтий, Төв, Говьсүмбэр аймгуудын Боржигин сумдын төлөөлөл, ардын авьяастан нар оролцсон байна. Уралдаанд 5



аймгийн 17 сумын өвлөн уламжлагчид билиг авьяасаа сорихоос гадна өсвөрийн насны хүүхдүүд нийт 60 орчим өвлөн уламжлагч нар оролцсон. Соёлын өвийн Үндэсний төвийн Соёлын биет бус өвийг хамгаалах хэлтсийн мэргэжилтэн Ж.Насанжаргал насанд хүрэгчдийн Уртын дууны уралдаанд оролцогчдоос 70 минутын дүрс бичлэгийг хийж УНБМСанд архивлан хадгалсан.

Мөн хуралд оролцсон сумдын Соёлын төвийн эрхлэгч, Орон нутаг судлах Музейн ажилтнуудад “СББӨ, өвлөн уламжлагчдыг бүртгэх, бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх” талаар 1 цагийн мэдээлэл, сургалтыг хийсэн.

Хурлыг нээж аймгийн Засаг дарга Г.Батсуурь үг хэлж, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын Соёлын өвийн хэлтсийн дарга Г.Батхуяг, Боржигин судлалын төвийн тэргүүн, доктор Т.Намжил нар мэндчилгээ дэвшүүлэн үг хэлж, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Содном “Боржигин судлалын чиглэлээр хийгдсэн ажлын товч мэдээлэл, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал” сэдвээр илтгэл тавьснаар арга хэмжээ эхэлсэн юм.

Үндсэн илтгэлүүдийг:

- “Соёлын биет бус өв” сэдвээр СУИС-ийн багш С.Юндэнбат
- “Боржигин өв соёлын уламжлал, Боржигин уртын дуу” сэдвээр, СУИС-ийн багш, МУ-ын гавьяат багш Ц.Дэлгэр
- “Боржигин аялгуут уртын дуу” сэдвээр, Боржигин өв музейн эрдэм шинжилгээний ажилтан Т.Болдбаатар

- “Соёлын биет бус өвлөн уламжлагчийн өнөөгийн байдал” сэдвээр, Боржигин чуулгын зөвлөх багш, урлагийн гавьяат зүтгэлтэн, Буриад улсын соёлын гавьяат зүтгэлтэн Д.Нацагдорж

- “Боржигин морин хуурын өв уламжлал, цаашид сэргээн хэрэглэх арга зам” сэдвээр тус тус илтгэл тавьж хэлэлцүүлсэн.



Хуралд оролцогчдоос Боржигин судлалын чиглэлээр цаашид хийх ажлын талаар нэлээдгүй ажлыг хийх, өргөн цар хүрээтэй болгох саналууд гарч, Боржигин овогтны холбоог шинэчлэн байгуулж, Говьсүмбэр аймаг удирдан зангидаж сумдын төлөөлөл бүрэлдэхүүнд нь орж ажиллахаар болсон юм. Уг уралдаан анх зохион байгуулагдсанаас хойш хамрах хүрээ нь тэлж, ард түмний хүсэн хүлээсэн арга хэмжээний нэг болсон. Иймд цаашид Боржигин уртын дуу, морин хуурын бүсийн уралдааныг 4 жил тутам бус 2 жил тутам зохион байгуулахаар болов. Уралдааны ерөнхий шүүгчээр МУГЗ, Оросны холбооны улсын СГЗ, Боржигин чуулгын зөвлөх багш Д.Нацагдорж, МУ-ын гавьяат багш, СУИС-ын уртын дууны багш Ц.Дэлгэр, Соёлын гавьяат зүтгэлтэн, уртын дуучин Г.Дадьсүрэн нар шүүн явууллаа.



- Соёлын өвийн Үндэсний төв, Дорноговь аймгийн ЗДТГ, Музей сургалт судалгааны төвийн хамтран зохион байгуулсан "Соёлын биет бус өв, түүнийг өвлөгчийг бүртгэх, бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх арга зүй" сургалт 2017 оны 11 дүгээр сарын 24-ны өдөр 09:00-18:00 хүртэл Дорноговь аймгийн Боловсрол соёл урлагийн газрын хурлын танхимд амжилттай боллоо. Сургалтанд Дорноговь аймгийн ЗДТГ-ийн Нийгмийн бодлогын хэлтсийн Боловсрол, соёл, урлагийн бодлого хариуцсан мэргэжилтэн Ү.Ганчимэг, БСУГ-ын Соёл хариуцсан мэргэжилтэн Б.Хүдэрчулуун, Сайншанд сумын ЗДТГ-ын Нийгмийн бодлогын тасгийн Соёл урлаг хариуцсан мэргэжилтэн Б.Даваа, Музей сургалт судалгааны төвийн мэргэжилтнүүд, Дорноговь аймгийн 14 сумдын соёлын төвийн эрхлэгч, музей хариуцсан ажилтан, Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагч нар нийт 30 орчим хүн хамрагдсан.

Сургагч багшаар Соёлын өвийн Үндэсний төвийн СББӨХХ-ийн мэргэжилтэн Ж.Насанжаргал, Үл хөдлөх дурсгал хариуцсан мэргэжилтэн Г.Бүрэнтөгс нар дараах сэдвийн хүрээнд Соёлын биет бус болон Үл хөдлөх дурсгалын чиглэлээр мэдээлэл сургалтыг хийсэн болно.

Ж.Насанжаргал: “Соёлын биет бус өвийн ерөнхий ойлголт, Конвенцууд”


“Соёлын биет бус өв түүнийг өвлөгчийг бүртгэх, бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх арга зүй”

СББӨ, түүний өвлөгчийг бүртгэх дадлага ажлыг 3 багт хуваагдан тус аймгийн өвлөн уламжлагч Д.Норов, Н.Лантуу, О.Цэвэгсүрэн нарыг хамруулан хийсэн болно.

Г.Бүрэнтөгс

“Түүх соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл”

“Түүх соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтанд нөлөөлөх газар зүйн байршлын асуудал” сэдвээр тус тус сургалт явуулсан болно.



- 2017 оны 04 дүгээр сарын 18-нд Хан-Уул дүүргийн ЗДТГ-тай хамтран СББӨ-ийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх, СББӨ түүний өвлөгчийг хэрхэн бүртгэх, бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх арга зүйн чиглэлээр сургалтыг тус дүүргийн хороодын зохион байгуулагч нарын дунд явуулж 42 хүн оролцов.

Сургагч багшаар Соёлын өвийн Үндэсний төвийн СББӨХХ-ийн мэргэжилтэн Ж.Насанжаргал, Ц.Жаргалсайхан нар Соёлын биет бус өвийн чиглэлээр мэдээлэл сургалтыг хийсэн болно.

- 2017 оны 05 дугаар сарын 21-нээс 24-ны өдрүүдэд Хөвсгөл аймагт болсон тус аймгийн Удирдах ажилтны зөвлөгөөнд оролцогч 230 орчим хүнд Соёлын биет бус өвийн ерөнхий ойлголтийг өгч, Сумдын соёлын төвийн 15 ажилтнуудад Бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх арга зүй сэдвээр тус хэлтсийн мэргэжилтэн Ц.Жаргалсайхан хичээл заав.
- Дундговь аймгийн ЗДТГ-ын Боловсрол соёл урлагийн газар, аймгийн музей, театр хамтран зохион байгуулсан “Соёлийн бүтээлч үйлдвэрлэлийг орон нутагт хөгжүүлэх нь” сэдэвт зөвлөгөөн, сургалт 2017 оны 11 сарын 08-наас 11-ний өдрүүдэд амжилттай болж өндөрлөлөө. Сургалтаар соёлын ажилтнуудын чадавхийг нэмэгдүүлэх, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, туршлага солилцох, соёлын бүтээлч үйл ажиллагааг зохион байгуулах арга зүйн мэдлэг чадвар олгох зорилготой. Сургалтанд БСУГ-ын дарга, мэргэжилтнүүд, соёлын төвийн эрхлэгч, музейн ажилтнууд, дуу хөгжим, бүжгийн багш, номын сан, театруудын удирдлага, маркетингийн ажилтнууд оролцлоо.
Тус сургалтанд Монголын Үндэсний Музейн Ахлах арга зүйч Д.Мөнхтогоо “Орон нутаг судлах танхимын үйл ажиллагаа, зохион байгуулалт, хадгалалт хамгаалалт, үзүүлэлэг дэглэлт” сэдвээр, Арга зүйч Д.Эрдмаа “Орон нутаг судлах танхимын боловсролын ажил, соёлын бүтээлч үйлдвэрлэл” сэдвээр, Соёлын өвийн Үндэсний төвийн мэргэжилтэн Ж.Насанжаргал “Биет бус өвийн хадгалалт хамгаалалт, бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэлт, яаралтай хамгаалах өвийн тухай”, мэргэжилтэн Г.Анхсанаа “Түүх соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалт, өнөөгийн байдал” сэдвээр тус тус хичээл заалаа.
- Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчдын уламжлалт урлагийг хадгалж хамгаалах, хойч үедээ өвлүүлэх, судлах, сурталчлах зорилгоор “Аймгийн соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчдын анхдугаар зөвлөгөөн”-ийг Төв аймгийн ЗДТГ, Боловсрол, соёл урлагийн газар, аймгийн музей хамтран зохион байгуулсан. Зөвлөгөөнд 27 сумын Соёлын төвийн эрхлэгч, Соёлын биет бус өвийн уламжлагчдын төлөөлөл нийт 80 орчим хүн оролцсон бөгөөд Соёлын өвийн үндэсний төвийн СББӨ-ийг хамгаалах хэлтсийн мэргэжилтэн Ж.Насанжаргал Соёлын биет бус өвийн ерөнхий ойлголт, бүртгэл мэдээллийн сангийн хууль эрх зүйн орчин, Соёлын өвийн үндэсний төвийн чиг үүргийн талаар 30 минутын илтгэлийг тавив.

- 2017.12.08-09-нд Сүхбаатар аймгаас зохион байгуулсан “Соёлын биет бус өв өвлөн уламжлагчдын анхдугаар зөвлөгөөн”-д Соёлын биет бус өвийн ерөнхий ойлголт, ЮНЕСКО-гийн СББӨ-ийн Конвенцууд, СББӨ, түүний өвлөгчийг бүртгэх, бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх сэдвээр илтгэл тавьж, хэлэлцүүлсэн. Зөвлөгөөнд Сүхбаатар аймгийн Нийгмийн бодлогын хэлтэс, Боловсрол, Соёл урлагийн газар, Аймгийн музейн ажилтнууд, 12 сумдын Соёлын төвийн эрхлэгч, бүртгэл хариуцсан ажилтнууд, өвлөн уламжлагч нарын 43 хүн хамрагдсан.



Баримтжуулалт болон бусад:

- Соёлын өвийн төвийн захирлын 2017 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн А/03 тоот тушаалын дагуу Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны Доод модот буланд болсон “Хөх сувд 2017” мөсний баярын үйл ажиллагаа болон мөсөн шагайн харвааны бичлэгийг дуу, дүрс бичлэгээр баримтжуулах, бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлэхэд зорилгоор Соёлын биет бус өвийг хамгаалах хэлтсийн мэргэжилтэн Ж. Насанжаргал 2017 оны 03 дугаар сарын 02-ны өдрөөс 03 дугаар сарын 06-ны өдрийн хооронд 4 хоног ажилласан.



Хөвсгөлийн өвлийн үзэсгэлэнт байгалийг нийтэд сурталчлан таниулах, хамгаалах, орон нутгийн иргэдийн орлогыг дэмжих, эко аялал жуулчлал хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор зохион байгуулагдсан.

Тус наадам нь Монгол Улсад өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, улиралын хугацааг уртасгах,

2017 оны 03 дугаар сарын 03, 04-ны өдрүүдэд Хатгал тосгоноос 3 орчим км зайд байрлах Доод модот буланд мөсний баярын үйл ажиллагаа болсон бөгөөд 03-ны өдөр 09:30 цагт нээлтийн үйл ажиллагаа эхэлж Морин чаргатай парад, тэшүүрчдийн парад, сумдуудын төлөөлөл иргэд оролцсон.

12:30–13:30 минутын хооронд Үндэсний мөсөн шагайн тэмцээнд Хөвсгөл, Архангай аймгийн нийт 6 баг өрсөлдсөн.

Нээлтийн тоглолт, мөсөн урлал, Мөсөн шагайн харвааны нийт 30 орчим гэрэл зураг, Мөсөн шагайн харвааны хэсэгчилсэн болон байгалийн 20 орчим минутын хар зургийг дуу дүрс бичлэгээр баримтжуулж СББӨ-ийн Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд авч архивласан.



- 2017 оны 5 дугаар сард Соёл, урлагийн байгууллагуудын нээлттэй хаалганы өдөрлөгийн үеэр техник талын ажил дээр оролцон анхаарч ажиллсан ба “Өвөө бүртгүүлцгээ” уриалга бүхий нийт 02 минут 30 секундын 3 төрлийн видео график шторк хийж нийтэд хүргэсэн.
- ЮНЕСКО-гийн Ази Номхон Далайн орнуудын Соёлын биет бус өвийн олон улсын мэдээлэл, сүлжээний төв болох ICHCAP болон Байгаль соёлын өвийг хамгаалах санаас зохион байгуулагдаж буй “Төв азийн соёлын биет бус өв” сэдэвт Азийн баримтат кино наадамд БСӨХС-ын тэргүүн Н. Уртнасан, судлаач А. Дүүрэнжаргал нартай хамтран уралдаанд оролцогчдын бүтээлүүдийн үзлэгт оролцон, наадмын зохион байгуулагчдын тавигдсан шаардлага, олон улсын техникийн үзүүлэлтэнд үндэслэн хяналт тавин ажиллаж, дараах 10 өвийн баримтат кино, 84 цаг 52 минутын хар дүрсийг Соёлын өвийн УНБМСанд хүлээн авч архивласан.

Алтан нарны үр сад	/найруулагч н.Чингис/
Монгол ардын уртын дуу	/найруулагч Ч.Жумдаан/
Монгол хөөмэй өнөөдөр	/найруулагч Д.Баярсайхан/
Монгол уламжлалт уул, овоо тахилга	/найруулагч Д.Баярсайхан/
Таван эрдэнийн шагай	/найруулагч Л.Баатар/
Хөхүүрийн айраг	/найруулагч М.Төгөлдөр/
Монгол гэрийн уламжлалт урлал зан үйл, ёс билгэдэл	/найруулагч Г.Лувсангомбо/
Хурд эзэгнэх эрдэм	/найруулагч
Л.Галмандах/	
Хялгас эгшиглэх учир	/найруулагч Л.Галмандах/
Монголын нум сум урлах эрдэм	/найруулагч Ч.Жумдаан/

-х-

БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭХ АНГИ-3. СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ ХЭЛТСИЙН СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫГ ХАНГАХАД ЧИГЛЭСЭН АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ

3.1. Музейн, эрдэм шинжилгээний байгууллагад хадгалагдаж буй үзмэр, эд өлгийн зүйсийг бэхжүүлэх, сэргээн засварлах

3.1.1. Улс, аймгийн музей, байгууллагын 50 ширхэг үзмэрийг цэвэрлэж бэхжүүлэх, сэргээн засварлах.

Соёлын өвийн төвийн Соёлын өвийг хамгаалах сэргээн засварлах хэлтэс /СӨХСЗХ/ нь 2017 онд улс, аймгийн музей, байгууллагын 50 ширхэг үзмэрийг цэвэрлэж бэхжүүлэх, сэргээн засварлахаар төлөвлөж байсан ба 2016 оноос он дамнасан үзмэрүүд болон 2017 оны улс, аймгийн 18 музейн захирлуудын тоот тушаалаар Соёлын өвийн төвд үзмэрүүдийг хүлээн авав. Үүнд :

- Увс аймгийн музейн Ш.Цэдэнбал захирлын А/32 тоот тушаалаар 2017 оны 5 дугаар сарын 01-ний өдөр 4 ширхэг үзмэр;
- Уран зургийн галерейн А.Янжив захирлын А/14 тоот тушаалаар 2017 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр 11 ширхэг үзмэр;
- Ховд аймгийн музейн Х.Эрдэнэбаатар захирлын А/04 тоот тушаалаар 2017 оны 3 дугаар сарын 23-ны өдөр 9 ширхэг үзмэр;
- Дархан-Уул аймгийн музейн Д.Жамбалдорж захирлын А/03 тоот тушаалаар 2017 оны 2 дугаар сарын 23-ны өдөр 2 ширхэг үзмэр;
- Өмнөговь аймгийн музейн Ц.Отгонтуяа захирлын А/16 тоот тушаалаар 2017 оны 6 дугаар сарын 08-ны өдөр 3 ширхэг үзмэр;
- Баян-Өлгий аймгийн музейн А.Айшагүл захирлын А/21 тоот тушаалаар 2017 оны 6 дугаар сарын 12-ны өдөр 2 ширхэг үзмэр;
- Сүхбаатар аймгийн музейн захирал Д.Ариундэлгэр захирлын А/31 тоот албан бичгээр 2017 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр 3 ширхэг үзмэр;
- Богд хааны ордон музейн О.Мэндсайхан захирлын А/28 тоот тушаалаар 2017 оны 6 дугаар сарын 12-ны өдөр 11 ширхэг үзмэр;
- Орхон аймгийн музейн Ч.Энхтуяа захирлын А/8 тоот тушаалаар 2017 оны 6 дугаар сарын 15-ны өдөр 2 ширхэг үзмэр хүлээн авсан;
- Сэлэнгэ аймгийн музейн Л.Бямбаа захирлын А/08 тоот тушаалаар 2017 оны 3 дугаар сарын 24-ний өдөр 3 ширхэг үзмэр;
- Монголын театрын музейн Д.Наранжаргал захирлын А/08 тоот тушаалаар 2017 оны 3 дугаар сарын 24-ны өдөр 3 ширхэг үзмэр;
- Төв аймгийн музейн Б.Сүхбаатар захирлын А/06 тоот тушаалаар 2017 оны 3 дугаар сарын 9-ний өдөр 4 ширхэг үзмэр;
- Хэнтий аймгийн музейн Н.Нямсүрэн захирлын А/26 тоот тушаалаар 2017 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр 1 ширхэг үзмэр;
- Өвөрхангай аймгийн Д.Тогтох захирлын А/09 тоот тушаалаар 2017 оны 8 дугаар сарын 10-ны өдөр 9 ширхэг үзмэр;
- Чойжин ламын сүм музейн Сан хөмрөгийн эрхлэгч Ц.Хандмаагаас 2016 оны 3 дугаар сарын 4-ний өдөр 5 ширхэг үзмэр, /Он дамжсан/;
- Эрдэнэ зуу музейн Сан хөмрөгийн эрхлэгч Ц.Содномцэрэнгээс 2016 оны 3 дугаар сарын 2-ны өдөр 3 ширхэг үзмэр, /Он дамжсан/;

- Улаанбаатар хотын музей 1 ширхэг үзмэр /Он дамжсан/;
- Дундговь аймгийн музейн 20 ширхэг үзмэр /Очиж сэргээн засварласан/;
- Эрдэнэ Зуу музейн 17 ширхэг үзмэр /Очиж сэргээн засварласан/ нийт 114 ширхэг үзмэрийг тус тус хүлээн авчээ.

Үүнээс 104 ширхэг үзмэрийг цэвэрлэж бэхжүүлэх, сэргээн засварлах ажлыг хийж дууссан ба үлдсэн 10 ширхэг үзмэрийг 2018 оны эхний улиралд багтаан сэргээн засварлаж хүлээлгэн өгөхөөр төлөвлөж байна.

2017 онд сэргээн засварлахаар хүлээж авсан үзмэрүүдийн зонхилох хэсэг нь даавуу зөөлөн эдлэл, модон эдлэл, металл эдлэл, танка зураг зэрэг угсаатны зүйн эдлэл хэрэгсэл болон шашны эд агуурс байсан ба эдгээр үзмэрийн гэмтлийн зонхилох шалтгаан нь он удаан жилийн эдэлгээнээс үүдэлтэй хэрэглээний гэмтэл мөн музейн орчны хадгалалтын горим алдагдсанаас үүдэлтэй гэмтлүүд байна.

Энэ онд Соёлын өвийн үндэсний төвд сэргээн засварлуулахаар ирүүлсэн үзмэрүүдийг тоймловол:

- баримлын төрөл зүйл 22 ширхэг;
- даавуу зөөлөн эдлэл 24 ш;
- модон эдлэл 15 ширхэг;
- металл эдлэл 17 ширхэг;
- уран зураг 7 ширхэг;
- танка зураг 24 ширхэг;
- цаасан эдлэл 5 ширхэг байна.

Эдгээр үзмэрүүдийг жилийн эхний улиралд багтаан хүлээн авч сэргээн засварлалт, хадгалалт хамгаалалтын ажлыг хийж эхлэх цаг хугацааны шаардлага байгаа боловч сэргээн засварлуулах үзмэрүүдийг Соёлын өвийн үндэсний төвд хүргүүлэх хугацаа оройтож байгаа тул зарим үзмэрүүдийг он дамнуулан сэргээн засварлалтын ажлыг хийх нөхцөл байдал үүсэж байна.

2017 онд улс аймгийн музейнүүдээс сэргээн засварлалт хийлгэхээр ирүүлсэн үзмэрүүд, музей болон төрөл зүйлээр

№	Хүлээн авах үзмэрийн төрөл Музей	Баримал	Даавуу зөөлөн эдлэл	Модон эдлэл	Метал эдлэл	Уран зураг	Танка зураг	Цаас	нийт
1	Чойжин ламын сүм музей	1					4		5
2	Хөвсгөл аймгийн музей	1			1				2
3	Эрдэнэ Зуу музей	20					2		22
4	Богд хааны ордон музей		2	1	5			3	11
5	Төв аймгийн музей		4						4

6	Увс аймгийн музей		4					4	
7	Дархан-Уул аймгийн музей		2					2	
8	Өмнө говь аймгийн музей		3					3	
9	Сэлэнгэ аймгийн музей				2	1		3	
10	Сүхбаатар аймгийн музей			2	1			3	
11	Баян-Өлгий аймгийн музей		2					2	
12	Театрын музей			3				3	
13	Ховд аймгийн музей		4				5	9	
14	Орхон аймгийн музей				1			1	
15	Хэнтий аймгийн музей						1	1	
16	Улаанбаатар хотын музей			1				1	
17	Өвөрхангай аймгийн музей		3	2	4			9	
18	Уран зургийн галерей			5		6		11	
19	Дундговь аймгийн музей			1	3		13	17	
	нийт	22	24	15	17	7	24	5	114

Энэ онд нийт үзмэр сэргээн засварлуулах хүсэлт илгээсэн музейнүүдээс Өвөрхангай амгийн Хархорин сумын Эрдэнэ-Зуу музей болон Дундговь аймгийн музей дээр Соёлын өвийн төвийн СӨХСЗХэлтсийн сэргээн засварлах баг очиж ажилласан болно. Энэ нь сэргээн засварлахад лабораторийн нөхцөл шаардахгүй үзмэрүүдийг сэргээн засварлах, хадгалалтын ажил хийхэд газар дээр нь богино хугацаанд хийж гүйцэтгэж байгаагаараа онцлог ажил болов.

Дундговь аймгийн музейд ажилласан ажлын тайлан

Сэргээн засварлагч Б.Мягмарсүрэн, Э.Батжаргал, Н.Бат-Эрдэнэ, А.Мөнгөнцоож нар 2017 оны 2 дугаар сарын 03-07 ны хооронд ажиллав. Тус музей нь нийт 20 үзмэр сэргээн засварлуулах хүсэлтэй байсны 3-н үзмэрийг цаг хугацаа их орох тул буцаасан байна.

Сэргээн засварлалтанд 3 ширхэг тогоо, 13 ширхэг танка зураг, 1 ширхэг морин хуур хамрагдав. Сэргээн засварлалтын зургийг жишээгээр үзүүлэв.

Тогоо

Засварын өмнө



Засварын дараа





Морин хуур

Засварын өмнө



Засварын өмнө



Танка зураг

13ш танка зурагнууд нь тортог ихтэй, хир тоостой, цоорж урагдсан, хүрээ торгонууд нь урагдаж сэмэрсэн, доги модгүй, ар торго нь байхгүй зэрэг гэмтэлүүдтэй. Бодисоор тест хийж үзээд зургийг цэвэрлэв, уранхай цоорхойг нөхөж шаардлагатай газарт будгын засвар хийв.

Хүрээ торгоны урагдсан хэсгүүдийг нөхөж бэхэлж оёсон,арын торго байхгүйг шинээр арлаж, доги модгүй танкануудад шинээр доги тод хийж мөн шалхавчуудыг угааж цэвэрлэв.



Засварын өмнө



Засварын дараа

Мөн хадгалалт хамгаалалтын хувьд зарим үзмэрийг буруу дэглэж үзмэрээ гэмтээж байгаа талаар зөвлөгөө өгөв. Хадгалалт хамгаалахад зориулж өгсөн хүчил, шүлтгүй кардон цаасыг буруу зориулалтаар ашигласныг шүүмжилж хайрцаг хийх сургалт хийв.


- Хүчил, шүлтгүй кардон цаасаар “Эрийн 3 наадам”, “Таван хошуу мал” зэрэг зургуудыг хийж танин мэдэхүйн өрөөг тохижуулсан байдал



- Сав баглаа боодол буюу хайрцаг хийх сургалт хийсэн











Үзмэрээ хатгуур зүүгээр хатгаж тогтоосон, утсаар татаж тогтоосон зэрэг нь үзмэртээ гэмтэл учруулж байгаа талаар зөвлөгөө өгч өлгүүрт зөөлөвч хийх талаар сургалт хийв.



























Өвөрхангай аймгийн Хархорин сумын Эрдэнэзуу сүм музейн үзмэрүүдийг сэргээн засварласан ажлын товч тайлан


Өвөрхангай аймгийн Хар-хорин сумын Эрдэнэ Зуу сүм музейн Гол Зуу, Баруун Зуу, Зүүн Зуу сүмүүдийн үзмэр сэргээн засварлах ажилд 2017 оны 5 дугаар сарын 05-09 ны хооронд Соёлын өвийн төвийн сэргээн засварлагч Э.Батжаргал, Н.Бат-Эрдэнэ, Т.Сүхбаатар, С.Даваадарь, нарын бүрэлдэхүүнтэй баг томилогдон ажиллав.

Сэргээн засварласан үзмэрүүдийн жишээнээс:

Д.д	Үзмэрийн №	Үзмэрийн нэр	Засварын өмнө	Засварын дараа	Тайлбар
01	65-107 9	Гомбогүр 1ш	 	 	Хумс хугарч унасан, мөн бадны чимэгнүүд унаж алга болсон байсныг гипсээр нөхөн хийж тохирох өнгийн будагнуудаар будав.
02	65-108 3	Гомбогүр бурханы мутар дахь ганди 1ш	 	 	Модон чимгүүд нь хагарч, ховхорч унан алга болсон байсаныг гипсээр нөхөж хийн тохирох өнгийн бронзоор будав.

03	65-111 2	Балданлх ам 1ш	      	      	<p>Баруун мутрын хоёр хумс, баруун бойвны таван хумс, зүүн бойвны эрхий хурууны хумс, лууснаас уяж унжуулсан чөтгөрийн толгой, луусны чимэг зүүлтүүд луусны зүүн талын дээд, доод хоёр соёо, баруун талын дээд доод уруул, луусан дээр унжиж буй ногоон хадаг зэрэг олон хагарч, хугарч, унасан гэмтэлүүдтэй байсан. Эдгээр гэмтлүүдийг шавар болон гипсээр нөхөлт хийж, салсан хэсгүүдийг нааж, тохирох өнгийн будагнуудаар будав.</p>
----	-------------	-------------------	--	---	---

04	65-123 9-1	Жанрайса г 1ш	       	<p>Зүүн талын хөмсөг нь сэтэрч, хагарч, ан цавууд гарсан, рин-ааны цэцгэн чимэгнүүд нь ховхорч унан алга болсон, ээмэгний чимэг нь унан алга болсон, зүүн мутарын бугуйны өнгөн хэсгийн будаг нь хагарч, халцарсан гэмтэлүүдтэй байсан. Гэмтлүүдэд шавар болон гипсээр нөхөлт хийж, салсан хэсгүүдийг нааж, тохирох тохирох өнгийн будагнуудаар будав.</p>
05	65-147 7	Сүмийн загвар	 	<p>Сүмийн загварын дээвэр дээрх чимэглэл унасан байсныг нааж сэргээн засав.</p>

06	65-1478	Зуу бурхан /зандан/		Зуу бурханы зүүн талын мутар салж унасан байсныг нааж, нөхөж сэргээн засав.
----	---------	---------------------	--	---

Сэргээн засварын ажлын тухай товч мэдээлэл:

Бүтээлүүдийн сэргээн засварын өмнө, явц, дараах байдлуудыг фото зургаар баталгаажуулав.

Бүтээлийн хугарсан хумснууд, бад суурийн чимэгнүүд, мөрний цэцгэн чимгүүд, рин-ааны цэцгэн чимэгүүд болон бурхадын хуруунууд нь хугарч, хагарч гэмтсэн, мөн унжиж буй хадган чимгүүдийн будаг нь халцарч унасан, хагарч, унан алга болсон зэрэг гэмтлүүдийг гипс болон шавраар нөхөлт хийж, 405 /тараган цавуу/, 401 /солонгос цавуу/, лаан цавуу /халдаг/, үрлэн цавуунуудыг ашиглан тохирсон хэсгүүдэд наалт хийж, мөн дутуу алга болсон чимэгнүүдээс силконоор хэв аван гипс болон шавраар хэвлэж нөхөн гүйцээж, нааж, сийлж, дараа нь акварель, акрелик, гуаш, Dicolorbin /алтан бронз/ будагнуудыг ашиглан тохирох өнгүүдийг гарган будаж, шаардлагатай гэсэн хэсгүүдэд B72-1,5%-ийн бодисоор бэхжүүлэлт хийж сэргээн засварлах ажлыг дуусгав.

3.2. Музейн үзмэрийн материал бүтцийн судалгаа хийх

Уг ажил нь улс, аймгийн музейн үзмэрийн орц найрлагыг тогтоох, зарим буруу тогтоогдсон үзмэрийн материалын орц, найрлагыг тодруулах зорилгоор энэхүү ажлыг хийж гүйцэтгэж байна.

Соёлын өвийн төвийн лабораторит болон хөдөлгөөнт гар төхөөрөмжөөр музейд нь хийсэн материалын орц найрлагыг тодорхойлж улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд бүрдүүлсэн ажлын тоон үзүүлэлтийн хүснэгт.

№	Музей, эрдэм шинжилгээний байгууллагын нэр	Үзмэрийн тоо	Хийгдсэн ажил	Нийт
3.2.1.	Өвөрхангай аймгийн Хархорин сумын Эрдэнэ-Зуу, Хархорум музейд хадгалагдаж	Oxford X-Met 7200 зөөврийн төхөөрөмж Horiba XGT 5200 X-Ray analytical microscope суурин төхөөрөмж дээр	Материалын орц найрлага тогтоох шинжилгээ	38ш

	буй хосгүй үнэт үзмэрүүд	нийт 38ш үзмэрийн материалын орц найрлагын шинжилгээг хийж улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд бүрдүүлэв.		
3.2.2.	3.2.2. Бусад улс, орон нутгийн музейн материалын маргаантай металл объектуудад материал бүтцийн судалгаа хийх	3.2.2. Буянт-Ухаа гаалийн газраас ирүүлсэн 3ш эд зүйл; Замын үүд дэхь гаалийн газраас ирүүлсэн 2ш эд зүйл; ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн 32ш эд зүйл; нийт : 37ш Horiba XGT 5200 X-Ray analytical microscope суурин төхөөрөмж дээр дээжүүдийн судалгаа хийж улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд бүрдүүлэв	Материалын орц найрлага тогтоох шинжилгээ	37ш
	Нийт			75ш

3.3. “Баяннуур цогцолбор” дурсгалын ханын зургийг авран хамгаалах

3.3.1. Булган аймгийн Баяннуур сумын нутагт орших “Улаан хэрмийн шороон бумбагар”-ын бунхант булшны ханын зургууд болон модон бэхэлгээний микро организмыг цэвэрлэх.

1. 2017 оны 3 дугаар сар 9-нд Япон улсын Киотогийн их сургуулийн докторант О. Ангарагсүрэн тус сургууль болон Нарагийн соёлын өвийн үндэсний хүрээлэнгийн мэргэжилтнүүдтэй хамтран Булган аймгийн Баяннуур сумын нутагт орших “Улаан хэрмийн шороон бумбагар”-ын бунхант булшны нөхцөл байдалтай танилцаж судалгаа хийн дотоод орчныг судлах 10 ширхэг дата логгеруудыг байрлуулав.

2. 2017 оны 4 дүгээр сарын 02-16-ны өдрүүдэд Булган аймгийн Баяннуур сумын нутагт орших Майхан уулын Шороон бумбагарын бунхант булшинд Монаккогийн Вант Улсын дэмжлэгээр ЮНЕСКО–гийн Бээжин оффис болон ЮНЕСКО-ийн Монгол дахь Үндэсний комисс, Соёлын өвийн төв хамтран зохион байгуулсан сургалтын үеэр Итали улсын бичил цаг уурын мэргэжилтэн Алессандра Бонацца, Алессандро Сарделла нар бунхны дотоод хэсгийн бичил цаг уурын мэдээллийг тодорхой хугацаагаар буюу 1 жилийн хугацаанд авахаар бунхны үүдэвч

хэсэгт нэг, дурсгалын хамгаалалтын байгууламжийн дотор дээвэр доор нэг дата логгер байрлуулав. Дата логгерууд нь 30 секунд тутамд агаарын температур болон харьцангуй чийгшлийг хэмжих ба мэдээллийн санг 2-2,5 сар тутамд хуулж авч байна.

2017 оны 7 дугаар сард мөн оны 4-7 дугаар саруудын хугацаанд цуглагдсан мэдээллүүдийг хуулж аван дата логгеруудад setup хийж буцаан байрлуулав.

3. Булган аймгийн Баяннуур сумын нутагт орших Майхан уулын Шороон бумбагарын бунханта булшны дотоод хамгаалалтын модон хийц болон хананд үүссэн микро организмыг цэвэрлэх ажлыг хийхээр тус төвийн СӨХСЗХэлтсийн сэргээн засварлагч Н. Бат-Эрдэнэ, Э. Батжаргал, Т. Сүхбаатар, С. Даваадарь, Д. Нямдорж нарын бүрэлдэхүүнтэй баг 2017 оны 9 дүгээр сард дурсгалт газар томилогдон очиж ажиллав.



Дурсгалын байдалтай танилцахад хамгаалалтын модон байгууламж болон ханын зургийн зарим хэсгүүдэд хөгц мөөгөнцөр их хэмжээгээр үүссэн бунхны хэсгийн зарим хана болон нэвтрэх хэсгийн арк зэрэгт ханын үндсэн чулуулаг нурулт үүссэн ба зүүн талын хөмөгний модон бэхэлгээний зарим хэсгүүд ялзарч муудсаны улмаас хугарч унасан, нурулт үүссэн байдалтай байв.



Зурагт зүүн ба баруун талын хөмгийн гэрэл зураг бөгөөд сумаар заасан хэсэгт модон бэхэлгээ ялзарч нурж унасан хэсгийн харуулав

Дурсгалыг нурахаас сэргийлэн хийсэн энэхүү модон бэхэлгээ нь дурсгалыг анх нээгдэхэд хийгдсэн ба 5 жилийн аюулгүй байдлын баталгааг тухайн үед бэхэлгээг хийсэн уурхайн аврах ангийнхан өгж байсан бол өдгөө энэ хугацаа нь дуусаж байгаа юм.

Бунхны хамгаалалтын бэхэлгээний харьцангуй ачаалал багатай хэсэг гэж үзэж болох энэхүү хөмөг хэсгийн бэхэлгээний мод ялзарч муудан нурж унаж эхлэж байгаа нь дурсгалын аюулгүй байдалд аюул нүүрлэж байгааг илтгэж байна.

Иймд бунхны бэхэлгээг яаралтай шинэчлэх шаардлагатай байна.

Мөн энэ үед Япон улсын Киотогийн их сургуулийн докторант О.Ангарагсүрэн бунхны ханын зургийн гэмтлийн цар хүрээ тархалт, идэвхжилтийг судлах зорилгоор ханын зургийн үүдэвчний баруун зүүн талын хананд ханын зургаас 5см орчим хөндий зайтай 1х1м-ийн хэмжээтэй торын утсаар татаж хийн дугаарлав.



Ханын зургийн гадарга дээр давсны талстжилт харьцангуй бага харагдаж байв.

Бунханд үүссэн микро организмыг механик аргаар цэвэрлэгээ хийв

4. Дурсгалыг илэрсэн цагаас хойш жил бүр намар хүйтний эрч чангарахаас өмнө улирлын эхэнд цэвэрлэх, хучилт хийж дулаалах ажлыг Соёлын өвийн төвөөс хийдэг ба 2017 оны ээлжит ажлыг 11 дүгээр сарын 16-17-ны өдрүүдэд Соёлын өвийн төвийн СӨХСЗХэлтсийн сэргээн засварлагч А. Мөнгөнцоож, Н. Бат-Эрдэнэ, Э. Батжаргал, Д. Нямдорж нарын бүрэлдэхүүнтэй баг дурсгалт газар томилогдон очиж зохих дулаалга хучилтын ажлыг хийж гүйцэтгэв.



Мөн уг ажлын хүрээнд тус бунханд байрлуулсан бичил орчны цаг уурын хэмжилтийн багажуудын цуглагдсан мэдээллүүдийг хуулж авав. Энэ үед ЮНЕСКО-гийн мэргэжилтнүүдийн байрлуулсан төхөөрөмжүүд бичил цаг уурын орчны мэдээллийг зохих хугацаанд хураагаагүй унтарсан байв.

Бунхны бэхэлгээ модон хийцэнд өмнө хийсэн цэвэрлэгээнээс хойш хөгц мөөгөнцрийн ургалт харьцангуй бага боловч хөгц мөөгөнцрийн ургалт үүсэж эхэлсэн байдалтай байв. Үүдэвч хэсгийн хананд давс талсжих үзэгдэл эрчимжиж эхэлсэн байх магадлалтай байсан ба энэ нь хананд талсжиж тогтсон давс ба ханын дагуух газар хананаас нилээд хэмжээний шороо сайрч унасан байгаагаар харагдаж байв.



Мөн бунхны үүдэвч хэсгийн ханын зураг дүрслэлийн хойд хэсэгт байх харьцангуй хадгалалт сайтай байсан туг дарцгийн суурь бүхий 8 хүний зургийн үүд талын эхний хүмүүсийн нүүр толгой хэсэгт зургийн үндсэн ар дэвсгэр хөөж хөндийрч эхэлсэн нь маш тод харагдаж эхэлсэн байв. Эдгээр хөндийрсөн хэсгүүдийг дурсгал дээр ажилласан баг гараар зөөлөн цааш дарж хөндийрлийг буцааж буулгав.

Энэ хэсэг хананд анх дурсгал илрэх үед Паралойд Б72 уусмал түрхэж бэхжүүлсэн ба 2015, 2016, 2017 онд дурсгалт газар зохион байгуулсан ЮНЕСКО-гийн дурсгалт газрыг хамгаалах мэргэжилтний чадавх бэхжүүлэх сургалтын үед НАНО Акрил СВ 40-ийн усан дахь 2%- ийн уусмалаар бэхжүүлэлт жил дараалан хийсэн болно.

Бунхны хамгаалалтын байгууламжийн дулаалга тогвортой орчныг хангах ажлыг нэн яаралтай хийж дурсгалын хадгалалтыг сайжруулах ажил нэн тулгамдсан асуудал болж байгаа юм. Хадгалалтын орчныг сайжруулаагүйгээс үүдэвч хэсгийн ханын зургийг алдах эрсдэл өндөр болж байна.



Бунхны хучилт хийж байсан шилэн хөвөн болон гялгар уут урагдаж муудсан, хөндлөвч банз мод дутсан, цаашид дахин хэрэглэх аргагүй болсон тул энэ удаагийн хучилтын ажилд шинээр дулаалгын материал болон хучилтын гялгар цаас авч хучилт дулаалгыг шинээр сольж шинэчлэв.

5. 2017 оны 2-р улиралд Турк улсын ТИКА (Клон улсын хамтын ажиллагааны байгууллага)-тай хамтран Булган аймгийн Баяннуур сумын нутагт орших Майхан уулын Шороон бумбагарын бунхантай булш орших дурсгалт газрын хадгалалт хамгаалалтад дэмжлэг үзүүлэх зорилгоор цахилгааны найдвартай эх үүсвэр болох өндөр хүчдэлийн шугаманд холбосон ба цахилгааны шугамыг хүлээж авах ажлыг ТИКА, БСШУСЯам, Булган аймгийн ЗДТГазартай хамтран хүлээн авав.

3.3.2. Ханын зургийн хадгалалт хамгаалалтын талаар сургалт судалгаа хийгдэнэ.

Булган аймгийн Баяннуур сумын нутагт орших Майхан уулын “Шороон бумбагарын Бунхантай булшны ханын зургийг сэргээн засварлах, хадгалж хамгаалах нь” сургалт 2017

Тус сургалтыг Монаккогийн Вант Улсын дэмжлэгээр ЮНЕСКО –ийн Бээжин оффис болон ЮНЕСКО-ийн Монгол дахь үндэсний комисс, Соёлын өвийн төв хамтран 3 дахь жилдээ амжилттай зохион байгуулж дууслаа.

Энэ удаагийн сургалтыг Булган аймгийн Баяннуур сумын нутагт орших Майхан уулын Шороон бумбагарын Бунхантай булш буюу дурсгал орших газарт 2017 оны 4 дүгээр сард 14 хоногийн хугацаатай зохион байгуулсан юм.

Сургалтыг нээж Соёлын өвийн төвийн захирал Г. Энхбат, ЮНЕСКО –ийн Бээжин оффисыг төлөөлж Федерика Иелличи болон ЮНЕСКО-ийн Монгол дахь үндэсний комиссыг төлөөлөн М. Цэцэнбилэг нар үг хэлэв.



Сургалтад ЮНЕСКО-ийн экспертүүд болох ханын зургийн сэргээн засварлагч Родольфо Лухан Лансфорд болон бичил цаг уурын мэргэжилтнүүд болох Алессандра Бонацца, Алессандро Сарделла нарын сургагч багш нарын удирдлага доор явагдсан бол Соёлын өвийн төвийн СӨХСЗХэлтсийн дарга Д. Нямдорж сэргээн засварлагч А. Мөнгөнцоож, Н. Бат-Эрдэнэ, Э. Батжаргал, Г. Ууганчимэг, мэргэжилтэн Г. Анхсанаа, Б. Сайнзолбоо, А. Саруул СУИС-ийн Дүрслэх Дизайн Урлагийн сургуулийн багш Г.Амарсанаа, Монголын үндэсний музейн сэргээн засварлагч Д.Нямсүрэн, Япон улсын Киотогийн их сургуулийн докторант О. Ангарагсүрэн, орчуулагч Чулуунбаатар нар оролцов.

Уг сургалтын туршид өмнөх жилүүдэд хийгдсэн сорил ажлуудын үр дүнг дүгнэх болон бунхны модон бэхэлгээнд үүссэн микро организмын ариутгал ханын зургийн цэвэрлэгээ, болон хадгалалт, бэхжүүлэлт ханын зургийн үндсэн тулгуур болох Хувирмал үндсэн чулуулгийг нуралтаас сэргийлэнгадаргад хийсэн бэхжүүлэлт болох *Marei antique* MC тусгай зориулалтын цементийн гадаргууг хэрхэн халхлах мөн ханын зургийн тодорхой нэг хэсгийг сонгон түүн дээр сэргээн засварлалтын ажил хийж тус дурсгалд хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалт хийж дууссаны дараа дурсгалыг хэрхэн эх байдлаар нь дахин толилуулах шийдлийг олж хэлэлцэх мөн дурсгалын бичил орчны нөлөөллийг судлах, үр дүнг үндэслэн бичил орчныг хянах, мөн дурсгалын жишээн дээр үндэслэн сургалтын үр дүнгээс үүсэн гарч байгаа дүгнэлтүүдийг нэгтгэн цаашид манай улсад нээгдэж болох энэ төрлийн дурсгалуудыг хэрхэн цаг алдалгүй оновчтой байдлаар хадгалж хамгаалах мэргэжлийн зөвлөмж гаргахад чиглэсэн болно.

Сургалтын эхний өдөр бунхны байдалтай танилцав. Дурсгалын үүдэвч хэсгийн ханын зураг маш эрчимтэйгээр гэмтэж гэмтлийн явц цааш даамжирч байгаа нь энгийн нүдээр ажиглахад тодорхой харагдаж байсан ба харин бунханы хэсэг дотор хойд хана, зүүн урд булан, баруун ханын дээд хэсгээс хувирмал үндсэн чулуулаг шинээр дахин нурсан байв.



Харин 2016 онд Mapei antique MC, Ledan зэргээр бэхжүүлсэн хэсгүүд тогтвортой хэвээр байв. Бусад хэсгийн ханын зургууд харьцангуй тогтвортой байсан ба бэхжүүлэлт хийж байгаагүй хэсгүүд ус чийгний нөлөөллөөс өнгөн давхарга бага зэрэг хөөж хөндийрсөн байгаа нь ажиглагдаж байв. Энэ нь хөрсөнд шингэсэн ус чийгний хэмжээ улам бүр нэмэгдэж байх магадлалтай ба үүний эсрэг яаралтай арга



хэмжээ авахгүй бол гэмтэл цааш ахих нөхцөл бүрдэж байж болзошгүй юм. Бунхны модон бэхлэлтэнд үүссэн хөгц, мөөгөнцөр, микро организмын ургалт тархац энэ үед харьцангуй идэвхгүй байгаа ажиглагдаж байв, энэ нь агаарын хэм бага байгаатай холбоотой юм.



Тухайн өдөр оролцогчдыг 2 хэсэгт хуваан бунхны модон бэхэлгээнд үүссэн микро организмыг ариутгах ажлыг баг тус бүр хийв. Микро организмын ариутгал, мөөгөнцрийн устгалд хлорийн 15% -ийн уусмалыг шүршиж хэрэглэв.

Мөн бунхны ханын гэмтлийн гар зургийг үйлдэх зэрэг ажлуудыг хийсэн ба үүний дараа бунхны дотоод ба гадаад орчны судалгаа хийсэн ба үүнд хамгаалалтын байгууламж дотор баруун хананаас 2м орчим зайд 40 см гүн, мөн гадна талд өмнөх нүхний харалдаа мөн 40см гүн нүх ухаж хөрсний чийгийг шалгасан ба гадна ухсан нүх хуурай байсан бол хамгаалалтын байгууламжийн дотор ухсан нүхнээс гарсан хөрс нойтон чийгтэй байв.



Мөн бунхны үүд хэсгийн зураг дүрслэлгүй ханын шавар үе давхаргаас ховхорч унасан хэсгүүдээс цуглуулж бэхжүүлэх туршилт хийв

Үүнд :

1. Micro acryl CV 40 – ийн: 1%, 2%, 3%, 5% /органик гаралтай нано хэмжээс бүхий акрил /
2. Silica nano colloidal emulsion-ийн: 1%, 2%, 3%, 5%/ нано хэмжээс бүхий силика, нойтон чийглэг орчинд ажиллах боломжтой/
3. Ethyl silicate/10-25°C хэмд 60% RH –д хэрэглэнэ /



Эдгээр өөр хувь агууламжаар бэхжүүлсэн дээжүүдийг бэхжиж хатсаны дараа гар аргаар хатуулаг болон ус тэсвэрлэх тест хийсэн ба эдгээрээс бэхжилт хатуулгийн хувьд 3% -аас дээш дээжүүд хоорондоо ойролцоо сайн байсан ба ус тэсвэрлэх чадвар нь Micro acryl CV40 ашигласан дээжүүд илүү байв.


Бунхны хамгаалалтын байгууламж нь битүүмжлэл муутай халуун хүйтнийг дамжуулж сэлгэн дурсгалын дотоод тогтвортой байдлыг хангаж чадахгүй байгаа ба улмаар хүйтний улиралд бунхан доторх дулаан агаар дээш хөөрч хангалттай

дулаан биш хучилтын давхарга болон хамгаалалтын байгууламжийн тааз хэсэгт конденсаци явагдаж цантаж мөстөх зэрэг сөрөг үйл явц ажиглагдаж байна. Цанталтаас үүссэн ус буцаж газарт шингэж нэвчиж дурсгал орчмын хөрсний чийгийг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулсаар байна.

Дээврийн заагуудаар борооны ус дотогш дуслах мөн гадна талд ус зайлуулах систем хийгдээгүй тул дээврийн ус шууд газарт шингэж улмаар дотогш нэвчдэг. Ингэхдээ хөрсөнд агуулагдах давсыг өөртөө уусгана, нэгэнт нэвчсэн их хэмжээний ус нь зөвхөн дээш ууршиж гадагшлах боломжгүй ба ханын зураг байрлах босоо ханануудаар ч мөн гадагшилж байна. Хөрсөнд шингэсэн усны хэмжээ ихсэж ханах үед ханын зургийн бэхжүүлээгүй гадаргыг жижиг цэврүү хэлбэрээр хөөлгөж гэмтээж байгаа бол цаг агаар хуурайших үед эсвэл гадаа салхи ихтэй үед дээвэр дээр байрлуулсан ямар нэг тохиргоо хяналтгүй салхин агаар сорогчийн нөлөөллөөр дотоод орчин дахь агаарын хөдөлгөөн хурдассанаар харьцангуй чийгшил буурч ханын зургийн өнгөн давхаргад өчүүхэн хэмжээний хуурайших үйл явц явагдах үед шингэн хэлбэрт байсан давс ханын зургийн гадарга дээр болон доор дахин талсжиж энэ үзэгдэл нь олон дахин давтагдсанаар ханын зургийн өнгө будгийн болон шавар давхаргыг гэмтээж байна.




Бунхны үүдэвч хэсгийн ханын зургийн гэмтэл нь жилээс жилд нэмэгдэж байгаа нь энгийн нүдээр болон судалгааны материалаас тодорхой харагдаж байгаа юм.



Жишээ: Бунхны баруун ханын гэмтлийн зураг.

Баруун хана гэмтлийн зураг 2015



Баруун хана гэмтлийн зураг 2016



Баруун хана гэмтлийн зураг 2017

Давсны дахин талстжих үзэгдэл ханын зургийн үүдэвч хэсгийн зөвхөн өнгө будгийн давхарга төдийгүй шавар давхаргыг хөндийрүүлж нилээд их нөлөөлөл өгч эхэлсэн нь харагдаж байсан.



Эдгээр давсны талстжилтаас үүсэлтэй шаврын болон өнгө будгийн давхаргын хөндийрөл болон сийрэгшилтийг механик аргаар цааш буцаан дарж, давс ургасан, үүссэн хэсгүүдэд муутуу цаасыг усанд норгон нааж наад талаас нь цэвэр усанд базсан хөвөнгөөр хөнгөн дарж давсыг саармагжуулан хананаас тодорхой хэмжээгээр ангижруулах ажил хийв.

Үүний дараа бэхжүүлэлтийн туршилтын үр дүнд суурьлан Silica nano colloidal emulsion – ийн 3% ийн уусмалаар бунхны үүдэвч хэсгийн өнгө будгийн болон шаврын гэмтэлтэй давхаргыг бэхжүүлэв.

Бунхны 1, 2, 3 -р өрхний арын хананд аркны дээр байрлах Лууны толгой, Цэцэг, Сүм зэрэг дүрслэлтэй зурагнуудын зарим хэсгээр өнгө будгийн давхарга бага зэрэг хөндийрсөн байв. Дээрх хөндийрсөн гэмтлийг муутуу цаас норгож наан хөндийрлийг дарж, Micro acryl CV 40- ийн 2% - ийн уусмалаар мөн ижил арга техник хэрэглэж бэхжүүлэлт, цэвэрлэгээ хийв.



Мөн бунхны үүдэвчний баруун талын ханын сийрэгжсэн шавар болон бунхны 3- р өрхний баруун хана буюу зураггүй хананд илүү нарийвчилсан хайгуул цэвэрлэгээ хийж археологийн малталтын үед үлдсэн хөрс шорооны бохирдлыг гүйцээн цэвэрлэж хувирмал үндсэн чулуулаг болон хананд үлдсэн шавар өнгөлгөөний хэсгүүдээс сонгон Silica nano colloidal emulsion-ийн 3%- ийн уусмалыг дуслын шил болон систем ашиглан бэхжүүлэх туршилт хийв. Туршилт хийсэн хэсгүүдийг хатсаны дараа дахин шалгах шаардлагатай. Мөн өрхний зүүн ханын зурганд ижил механик цэвэрлэгээ хайгуул хийсэн ба археологийн малталтын үед хийсэн бэхжүүлэлтийн үлдэгдэл Паралойд Б72-ыг ацетонор цэвэрлэх тест хийсэн ба цэвэрлэсэн ханын зурганд өнгө будгийн сэргээн засварлалт хийж дурсгалыг эх байдлаар нь эргэн үзүүлэх дадлага ажил хийв.



Дурсгалыг эх байдлаар нь эргэн толилуулах дадлага ажлын нэг хэсэг нь хувирмал үндсэн чулуулгийг бэхжүүлсэн Marpei antique MC тусгай цементийг өнгөлөн далдлаж эх байдалд ойртуулах арга технологийг шийдэх байв. Үүний тулд хэд хэдэн янзын туршилт хийсэн ба шавар суурьтай зуурмаг хийж бунхны малтлагаас гарсан үндсэн түүхий эд болох шороо чулууг хольж үзсэн ба харагдах байдлаар ойролцоо болж байсан боловч Marpei antique MC тусгай цемент дээр барьцалдах чадвар сул байх магадлалтай гэж үзэв.



Marpei antique MC нь өөрөө шохой суурьтай тул үүнтэй илүү барьцалдах чадвар сайтай гэж үзэн шохой суурьтай зуурмагийг сонгох нь дээр гэж үзсэн ба Hydraulic lime –ийг ашиглах нь илүү бат бөх, хурдан бэхжилттэй байх боловч түүхий эд нь манай зах зээл дээр байгаагүй тул Lime putty буюу шохойн лагшинг ашиглаж туршилт хийв.



Туршилтыг мөн хэд хэдэн янзаар хийсэн ба шохойн лагшин дээр үндсэн түүхий эд болох шигшиж бэлдсэн шороо чулууг нэмж хутган хуурай пигментээр өнгө оруулан нэмэлт хольцуудыг нийлүүлэн эх дурсгал дээр бус гадаа орчинд туршилт хийж үзсэн ба үр дүнд нь шавар суурьтай зуурмагаас илүү бат бөх харагдах байдлаараа үндсэн материалтай төстэй Marpei antique MC тусгай цементтэй илүү барьцалдах чадвартай үндсэн материалын шинж чанар ойролцоо зуурмагийг гаргаж авсан ба уг зуурмагаар эх дурсгал дээр ажиллах арга зүйн шийдлийг мөн олж тохиров.

Алессандра Бонацца, Алессандро Сарделла нарын хичээлийн сэдэв цаг уурын өөрчлөлт, бохирдол соёлын өвд хэрхэн нөлөөлдөг тэдгээрийн үүсгэгч болон бүрдүүлэгч хүчин зүйлсийн тухай бөгөөд ерөнхий агуулгаараа цаг агаарын ШУ хэрхэн соёлын өвтэй холбогдох, энэ ШУ –ны үүсэл гарал, үндэслэгч мөн Европ тивд орших соёлын өвүүдэд цаг уурын өөрчлөлт өнгөрсөн, одоо, ирээдүйд хэрхэн нөлөөлж буйг судалсан томоохон төсөл судалгааны ажлын тухай танилцуулав.



Алессандра Бонацца, Алессандро Сарделла нар бунхны үүдэвч хэсэгт нэг, дурсгалын хамгаалалтын байгууламжийн дотор дээвэр доороос нэг даталоггер байрлуулав. Уг даталоггерууд нь 30 секунд тутамд агаарын температур болон харьцангуй чийгшлийг хэмжих ба мэдээллийн санг 2-2,5 сар тутамд хуулж авах шаардлагатай ба хугацаа хэтэрсэн тохиолдолд багажны санах ой дүүрч блоклогдоно.

Мөн Япон улсын Киотогийн их сургуулийн Докторантур О. Ангарагсүрэн 3-р сарын 9-ний өдөр бунханд 11ш даталоггеруудыг байрлуулсан ба сургалтын үед дурсгалын хамгаалалтын байгууламжийн гадна мөн даталоггер байрлуулж үлдээв.

Эдгээр даталоггерууд нь ойролцоогоор нэг жилийн хугацаанд тогтмол хэмжилт хийж байх ба энэ хугацаанд бунханы хамгаалалтын байгууламжид нэвтрэх тохиолдолд даталоггеруудын хэмжилтэд өөрчлөлт гарах ба энэ нь даталоггерийн мэдээллийг боловсруулахад мэдээлэлд өөрчлөлт оруулах тул орсон гарсан он, сар, өдөр, цагийг нь бүртгэн даталоггерийн мэдээлэлд хавсаргах шаардлагатай юм.

Эдгээр даталоггеруудын тусламжтайгаар бунхны бичил цаг уурын болон гадна цаг уурын мэдээлэл цуглах ба мэдээллийг нэгтгэж гэмтлийн байдалтай харьцуулснаар улирлын шинжтэй гадна цаг уураас байгууламжийн дотоод бичил цаг уурын нөлөөлөл дурсгал гэмтэж муудахад хэрхэн нөлөөлж буйг тогтооход ач холбогдолтой чухал судалгаа болж байгаа юм.

Сургалтын явц болон төгсгөлд Монгол Улсад энэ төрлийн дурсгалууд олон хадгалагдаж байгаа ба цаашид нээгдэж болох энэ төрлийн дурсгалуудын хадгалалт, хамгаалалтын ажлыг малтлага эхлэхээс өмнө сайтар төлөвлөж, цаг алдалгүй оновчтой байдлаар хадгалж хамгаалах мэргэжлийн зөвлөмжийг холбогдох байгууллага, мэргэжилтнүүдэд зориулан хэлэлцэв

3.4.1. Төв аймгийн Дэлгэрхаан сумын нутагт орших “ Их хөшөөт” –ийн дурсгалд сэргээн засварлалт хийх

Төв аймгийн Дэлгэрхаан сумын нутагт орших “Их хөшөөт” цогцолбор эртний Түрэгийн тахилга шүтээний томоохон дурсгалын нэг билээ. Энэхүү цогцолбор дурсгалыг түрэг судлалын зарим ном зохиолд Куль-чурт зориулан босгосон хөшөөний түрэг бичээс ч гэдэг. Хөшөөний өндөр нь 190 см, өргөн нь 61 см, зузаан нь 20 см. Дөрвөн талдаа бичээс бүхий байснаас хөшөөний зүүн зүг хандсан нүүрэн талд арван хоёр мөр, өмнө талд дөрвөн мөр, баруун талд арван гурван мөр, хойд талын бичээсүүд баларсан. Иймд одоо гурван талдаа нийт 29 мөр бүхий түрэг бичээстэй байна. Бид гэрэлт хөшөө болон бусад хүн, амьтны дүрслэлтэй дурсгалуудад цэвэрлэгээ, бэхжүүлэлт хийхийг зорьсон юм.

Энэхүү бэхжүүлэлтийн үр дүнд уг гэрэлт хөшөөний хадгалалт хамгаалалт, урьдчилсан байдлаар үр дүнг тандан судалж, цаашид бэхжүүлэлтийг хийснээр элдэв байгалийн болон хүн амьтны буруу үйл ажиллагаанаас үүссэх нөхцөл байдлаас сэргийлэхэд оршино.

Судалгааны багийн бүрэлдэхүүнд А.Мөнгөнцоож /Сэргээн засварлагч, судлаач/, Н.Бат-Эрдэнэ /Сэргээн засварлагч, судлаач/, Г.Бүрэнтөгс /БСӨХ-ийн мэргэжилтэн/, С.Сайнзолбоо /Жолооч/ нар 2017 оны 6 дугаар сарын 12-15-ныг хүртэл 4 хоног ажиллав.

Уг дурсгалт газрын анхны байгаа байдлыг гэрэл зургаар баримтжуулж хийв. Улмаар цэвэрлэгээний ажлыг эхлүүлэв. Ингэхдээ бид бэлдсэн материал болох нэрмэл ус, ацетон, 50 хувийн спиртын уусмалыг ашиглан хөшөөний гадаргууг сайтар шавьшин зүлгэж эхлэв. Бэлтгэсэн уусмалыг ашиглан хөвөнд шингээн шувууны сангас болж бохирдлыг дэвтээн зөөллөх байдлаар чулууны цуурсан болон их биений хэсгүүдээр цэвэрлэв.

Гэрэлт хөшөөнд баримтжуулалт хийж байх явцад чулууны цавуу энд тэнд хэвтэж байсан. Магадгүй энэ чулуун цавуугаар гэрэлт хөшөөний бичээс болон хүн чулууны хэв авсан байх магадлалтай байна. (зураг-1)



Зураг-1. Чулуун цавуу

Энд нийтдээ цагаан, саарал, шаргал боржин чулуугаар урласан гэрэлт хөшөө 1, хүн чулуун хөшөө 6, хонь 2, өнцөг булан талаараа хугарч унасан тахилын хавтан чулуу 2, эвдэрч бутарсан олон жижиг хөшөөд байна. (зураг-2)

Их хөшөөт цогцолбор дурсгалын анхны байдал





Зураг-2. Их хөшөөтийн цогцолбор

Цэвэрлэгээний явц





Дүгнэлт

Бид чулуун дурсгалыг хамгаалах, бэхжүүлэх зорилгоор Япон улсад үйлдвэрлэсэн Wacker stone strengthener // 100 болон Steinfestiger H хэмээх бэхжүүлэлтийн бодисуудыг ашиглан, нийт 13 хөшөө дурсгалыг 2-3 удаагийн давтамжтайгаар багсаар шингээн уусгах замаар бэхжүүллээ.

Мөн тахилын онгон болох 4 талын хашлага чулуунаас үлдсэн 2 хашлага чулууны нэг хавтан нь 34 хэсэг болон хугарсан ба энэ бүх хагарлуудыг дээрх аргачлалаараа бэхжүүлэлтийг үргэлжлүүлэн хийв. Бэхжүүлэлтийн явцад хагархай хашлага чулууны олон талт хугарлуудыг буцаан эвлүүлэн нийлүүлэхээр ажилласан. Үүний үр дүнд зарим нэгэн хээг тааруулж хавтан чулуун дээр дүрслэгдсэн шувуу болон бусад дүрслэлүүдийг тодруулахад маш чухал ажил болов.

Нэмэлтээр хийгдсэн ажлууд

1. Ховд аймгийн Мөнххайрхан сумын нутаг “Борт баг”-ийн нутаг “Үзүүр гялан” гэдэг газарт орших байгалийн ургаа бул чулууг дагуулан газар хөндийлөн ухсан оршуулгын байгууламжнаас олдсон эртний үед холбогдох дурсгалын сэргээн засварлалт

2016 оны 4 дүгээр сард доктор Ч.Мөнхбаяр ахлагчтай Ховд Их сургууль, Ховд аймгийн музейн хамтарсан судалгааны баг тус аймгийн Мөнххайрхан сумын “Борт баг”-ийн нутаг “Үзүүр гялан” гэдэг газарт орших байгалийн ургаа бул чулууг дагуулан газар хөндийлөн ухсан оршуулгын байгууламжнаас эртний үед холбогдох нэгэн дурсгалыг авран хамгаалах зорилгоор малтан гаргасан юм.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 04-р сарын 11-ний өдрийн А/175 дугаар тушаалаар дээрх олдворуудыг Соёлын өвийн төвд 2016 оны 5 дугаар сараас 2017 оны 4 дүгээр сарыг хүртэл бүтэн жилийн хугацаанд сэргээн засварлаж дууслаа.

Сэргээн засварлалтын ажил үндсэндээ бүртгэл баримтжуулалт, сэргээн засварлалт, судалгаа шинжилгээ, хадгалалт хамгаалалт гэсэн чиглэлээр хийгдлээ.

	Ажлын төлөвлөлт	Хийгдэх ажиллагаа
1	Баримтжуулалт	Рентгэн зураг /томографийн шинжилгээ/
		Гэрэл зураг, дүрс бичлэг
		Гар зураг
		Бүртгэл
2	Судалгаа шинжилгээ	Хүн ба мал, амьтны
		Материалын судалгаа
3	Сэргээн засварлалт	Гэмтэл тодорхойлолт
		Цэвэрлэгээ
		Бэхжүүлэлт
4	Хадгалалт хамгаалалт	Сав, баглаа боодол

Гэмтэл

Хадны оршуулгын олдворууд гол төлөв олон жилийн хур шороо, барагшун, мэрэгч амьтдын ялгадас, шавжны үүр өндөг зэрэг зүйлсээр бохирдсон боловч барагшуны баас нь хурц үнэрээрээ олдворыг хамгаалсан байх магадлалтай.

Даавуу болон эсгий эдлэлүүд маш ихээр мэрэгч амьтдад идэгдэж гэмтсэн боловч материалын шинж чанар муудаагүй. Гандаагүй, хуурайшиж хэврэгшээгүй, уян хатан чанар сайн.



Мод , метал эдлэлүүд зэврээгүй, хагарч хэмхрээгүй, өгөршиж муудаагүй.





Бохирдол болох барагшууны баас, мэрэгч амьтны баасыг хаялгүйгээр тусгайлан уут саванд хийв. Аль аль хэсгээс гарсныг тэмдэглэгээ хийж уутанд хийсэн.

Судалгаа шинжилгээ

Тус төвийн лабораторит толь, хутга, төмөр тогоо, гутлын тоног, хазаарын чимэг зэрэг 5 ширхэг металл эдлэлд бүтцийн судалгааг “Horiba XGT-5200 X-Ray” микроскоп багаж ашиглан хийж, гарсан үр дүн мэдээллийг Ховд Их сургуулиас уг олдвор олдсон хил орчмын бүс нутгаас илэрчсудалгаа шинжилгээнд хамрагдсан зарим металл эд өлгийн зүйлсийн өгөгдөлтэй харьцуулан нэрлэжээ. /Хавсралт №1/



Үзүүр гялан”-гийн хүрэл толь ба түүний гадаргуун 0.50 мм нарийвчлалтай авсан зураг



Processing Time : P3				
XGT Dia: 100 μm X-ray tube vol. : 50 kV				
Current: 1.000 mA				
X-ray Filter: Nonexistence Cell: Nonexistence				
Quant. Corr: Standard-less				
Elem. Line	Mass [%]	2sigma [%]	Atomic [%]	Intensity [cps/mA]
13 Al K	2.17	0.50	4.98	2.18
14 Si K	12.16	0.41	26.84	32.26
26 Fe K	1.95	0.04	2.17	127.04
27 Co K	0.36	0.02	0.38	27.71
28 Ni K	0.38	0.02	0.40	25.87
29 Cu K	52.18	0.49	50.90	3679.38
42 Mo K	0.00	0.01	0.00	0.02
50 Sn K	22.92	0.47	11.97	72.53
53 I K	0.07	0.19	0.03	0.10
82 Pb L	7.80	0.18	2.33	102.52

Хүрэл толины металлын бүтэц найрлагын график ба хүснэгт

“Үзүүр гялан”-гийн олдворуудыг судлан шинжлэх ажилд дотоод, гадаадын эрдэмтэн судлаачид оролцож байна. Археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор Н.Баярхүү, адуу судлаач Вильям Тейлор /William Taylor, АНУ/ нар адууны ясан дээр анхан шатны судалгааг, МУИС-ийн багш, антропологич доктор, Д.Түмэн, М.Эрдэнэ хүний ясны антропологийн судалгааг, СУИС-ийн багш, доктор Б.Мөнхцэцэг дээл, хувцасны эсгүүрийн судалгааг тус тус хийж байна. /Хавсралт №2, 3/

Францын Парис хотын Байгалийн түүхийн музейн даавуу зөөлөн эдлэл судлаач Isaline Saunier дээл өмд зэрэг даавуу зөөлөн эдлэлд, АНУ-ын Пенсильван хотын Археологи, антропологын их сургуулийн оюутан Kristen Pearson эсгий эдлэлд тус тус судалгаа хийж байна.

Материалын судалгаа

Хэдэн төрлийн даавуу, эсгий, арьс үс ашигласныг гаргалаа. Үүнд:

- эсгий 5 төрөл - цагаан эсгий, хоёр төрлийн бор эсгий, зөөлөн эсгий /ноолууртай/, хар хялгасан ноостой цайвар эсгий,
- даавуу - 40 орчим ноосон даавуу, хөвөн даавуу, торго
- арьс үс -6 төрлийн мал, амьтны арьс нэхий
- мод,
- яс - хүний болон амьтны



Эсгий



даавуу



арьс нэхий

Сэргээн засварлалт - Цэвэрлэгээ

Хадны оршуулгын олдворуудад хүн, мал амьтны яс, эсгий даавуу, арьс, яс, мод, төмрөөр хийгдсэн эд өлгийн зүйлс зонхилох ба тэдгээрийн материалын шинж чанараас хамааран бэхжүүлэлт, сэргээн засварлалтыг хийж гүйцэтгэлээ. Даавуун болон эсгийгээр хийсэн эд өлгийн зүйлд хуурай болон усан цэвэрлэгээ хийсэн ба ингэхдээ химийн бодис огт хэрэглээгүй юм. Цаашдаа олдворууд он удаан жил хадгалагдах учраас ямар нэгэн химийн бодис хэрэглэх тохиромжгүй тул энгийн цэвэрлэгээг гол болгон баримтлан ажилласан.

Даавуу, эсгий эдлэлийн бохирдлыг хуурайгаар цэвэрлэсний дараа нэрмэл усан цэвэрлэгээг хийсэн ба чийгийг шингээж авах байдлаар уг эдийн анхны хэв байдалд оруулан дэлгэн хатаалаа.

Усан цэвэрлэгээ



*Нэрмэл усаар угааж байгаа байдал
1 үзмэрийг 8-10 удаа зайлж угаасан*



Зайлж угаасан усны бохирдол.



Хуурай цэвэрлэгээ

Зарим угааж норгож болохгүй эдлэлийг чийгтэй даавуу тавьж зөөлөн товших аргаар нарийн тоос шороог цэвэрлэв.

Арьсан эдлэлийн бохирдлыг хуурайгаар цэвэрлэсний дараа хэсэгчилэн чийг өгөх замаар арьсыг тэнийлгэн хэвэнд оруулан бэхжүүлэв. Гагцхүү шарилд өмсгөсөн гутлын хоншоор хэсгийн арьсны бохирдлыг арилгах, үрчийснийг тэнийлгэх зорилгоор зөвхөн хэсгийг 0,5 %-ийн сулруулсан этанол (спиртэн уусмал)-оор арчиж цэвэрлэсэн байна.



“Үзүүр гялан”-гийн
гутлыг
цэвэрлэхийн өмнө



Ажлын явц



Цэвэрлэн бэхжүүлсний
дараа

Хүний хатмал шарил болон мал амьтны яс, мод, төмөр, ясан эдлэлийг хуурай механик аргаар цэвэрлэсэн ба зарим металл эдлэлд мэргэжлийн багаж ашигласан. Тухайлбал, Эмээлийн дөрөө, төмөр тогоог “Sand blaster” багажаар үлээлгэн цэвэрлэв.



“Үзүүр гялан”-гийн эмээлсэргээн
засварлахын өмнө



Эмээлийн эсгий дэвсгийг салган
цэвэрлэв.













Эмээлийн модны их бохирдолтой хэсэг



Эмээлийг сэргээнзасварласны дараа

Соёлын өвийн төвд олдворуудыг хүлээн авах үед анхан шатны бүртгэлд нийт 25 олдвор гэж бүртгэсэн байв. Энэ нь олдворуудын зөвхөн ил харагдаж тоолж болохуйц эд зүйлсийг анхан шатны байдлаар бүртгэсэн жагсаалт байсан бөгөөд сэргээн засварлалт, судалгаа шинжилгээний явцад энэ тоо 50 дэсийн 71ш эд өлгийн зүйл болон нэмэгдлээ. Олдворуудад хийгдсэн сэргээн засварлалт, цэвэрлэгээг хүснэгтлэн харуулбал:












№	Эд өлгийн төрөл	Засварын өмнө	Засварын дараа	Хийсэн засвар
1	Хатмал шарил /Хүн/			Хуурай цэвэрлэгээ
2	/морь/			Хуурай цэвэрлэгээ
3	Хатсан хонины арьс, толгой шийр			Хуурай цэвэрлэгээ











4	Арьсан малгай			Эвхэгдсэн байсныг чийг өгч тэнийлгээд гадаргууны бохирдлыг цэвэрлэсэн
5	малгай			Чийгтэй цэвэрлэгээ
6	малгай			Үрчийж хунирсан байсныг тэнийлгээд чийгтэй цэвэрлэгээ
7	Малгай /Эсгий дотортой даавуун гадартай/			Хэсэгчлэн угаах болон чийгтэй цэвэрлэгээ хийж хэвлэж хатаав
8	Малгай /эсгий/			Нэрмэл усаар угааж хэвлэж хатаав













9	Дээл /эсгий дотортой/			Нэрмэл усаар 8-10 удаа зайлж угаав
10	Дээл /Нэхий дотортой/			Хуурай цэвэрлэгээ болон чийгтэй даавуу тавьж зөөлөн товших аргаар нарийн тоос шороог цэвэрлэв
11	Дээл /эсгий дотортой/			Нэрмэл усаар 8-10 удаа зайлж угаав
12	Дээл /нэхий/			хуурайгаар цэвэрлэсний дараа хэсэгчилэн чийг өгөх замаар арьсыг тэнийлгэн хатаав
13	өмд			Нэрмэл усаар 8-10 удаа зайлж угаав








14	Өмд /Эсгий ба арьсан дотортой/			Нэрмэл усаар 8-10 удаа зайлж угаав
15	Өмд			Нэрмэл усаар 8-10 удаа зайлж угаав
16	Гутал /Арьсан гадартай эсгий дотортой/			Хуурай цэвэрлэгээ болон 0,5 %- ийн сулруулсан этанол (спиртэн уусмал)-оор арчиж цэвэрлэсэн
17	Гутал /эсгий/			Нэрмэл усаар 8-10 удаа зайлж угаав
18	Гутал /арьс/			Эвхэгдсэн байсныг чийг өгч тэнийлгээд гадаргууны бохирдлыг цэвэрлээд хэвэн хийж хатаав

19	Эмээлийн мод			Хуурай цэвэрлэгээ болон 40 %-ийн этанол (спиртэн уусмал)-оор арчиж цэвэрлэсэн
20	Эмээлийн дэвсэг			Хуурай болон чийгтэй даавуу тавьж зөөлөн товших аргаар нарийн тоос шороог цэвэрлэв
21	дөрөө			Хуурай цэвэрлэгээ болон 40 %-ийн этанолаар арчаад зэв цэвэрлэдэг төхөөрөмж Aribrasive-гээр цэвэрлэв. B72-1,5 % уусмалаар бэхжүүлэлт хийв
22	тохом			Хуурай болон чийгтэй даавуу тавьж зөөлөн товших аргаар нарийн тоос шороог цэвэрлэв
23	гөлөм			Нэрмэл усаар 8-10 удаа зайлж угаав

24	Нэхмэл даавуу			Нэрмэл усаар 8-10 удаа зайлж угаав
25	Давуун хүрээтэй эсгий эдлэлийн хэсгүүд			Нэрмэл усаар 8-10 удаа зайлж угаав
26	хазаар			Хуурай болон чийгтэй цэвэрлэгээ
27	Ташуур			Хуурай цэвэрлэгээ болон 40 %-ийн этанолаар арчаад Semedin e C цавуугаар нааж тогтоов
28	Даавуун гадартай эсгий богц			Нэрмэл усаар 8-10 удаа зайлж угаав
29	Даавуун гадартай эсгий богц			Хуурай болон чийгтэй цэвэрлэгээ


30	Бүс маягийн эдлэл			Хуурай болон чийгтэй цэвэрлэгээ
31	Эсгий цүнх			Нэрмэл усаар 8-10 удаа зайлж угаав
32	Эсгий хэтэвч			Хуурай болон чийгтэй цэвэрлэгээ
33	Оёдлын хэрэгсэлтэй эсгий уут			Хуурай болон чийгтэй цэвэрлэгээ
34	Арьсан уут			Хуурай цэвэрлэгээ

35	Зүүтэй уут			Хуурай цэвэрлэгээ
36	Аяганы арьсан уут			Хуурай цэвэрлэгээ болон 40 %-ийн этаноолоор цэвэрлэв
37	Модон аяга			Хуурай цэвэрлэгээ болон 40 %-ийн этаноолоор цэвэрлэв
38	Модон тэвш			Хуурай цэвэрлэгээ болон 40 %-ийн этаноолоор цэвэрлэв
39	Модон сав			Хуурай цэвэрлэгээ болон 40 %-ийн этаноолоор цэвэрлэв
40-41	Эсгий гэртэй шавар ваар			Хуурай цэвэрлэгээ болон 40 %-ийн этаноолоор цэвэрлэв. Эсгий уутийг угууж цэвэрлэв.

42	төмөр сав			<p>Хуурай цэвэрлэгээ болон 40 %-ийн этаноолоор цэвэрлэв. В72- 1,5 % уусмалаар бэхжүүлэлт хийв</p>
43	Хүрэл толь			<p>Хуурай цэвэрлэгээ болон 40 %-ийн этаноолоор цэвэрлэв. В72- 1,5 % уусмалаар бэхжүүлэлт хийв</p>
44	хутга			<p>Хуурай цэвэрлэгээ болон 40 %-ийн этаноолоор цэвэрлэв. Хутганы төмрийг В72- 1,5 % уусмалаар бэхжүүлэлт хийв</p>
45	Ясан сам			<p>Хуурай цэвэрлэгээ болон 40 %-ийн этаноолоор цэвэрлэв.</p>
46	Ац хэлбэрийн модон эдлэл			<p>Хуурай цэвэрлэгээ болон 40 %-ийн этаноолоор цэвэрлэв.</p>

47	Шарилыг ороосон хээтэй эсгий			Нэрмэл усаар 8-10 удаа зайлж угаав.
48	Шарилыг ороосон эсгий			Нэрмэл усаар 8-10 удаа зайлж угаав.
49	Олс дээс			Нэрмэл усаар зайлж угаав.
50	Арьсан хээ			Чийг өгч тэнийлгэв.
51	Торгоны өөдөс			Нэрмэл усаар зайлж угаав.

Сэргээн засварлалтын ажлын явцад энэхүү хадны оршуулгын эд зүйлсийг тухайн цаг үед хэрхэн хэрэглэж, өмсөж эдэлж байсныг олдворууд дээр тулгуурлан уран сайхны аргаар О.Оюунчимэг дүрслэн зурж баримтжуулсан.



“Үзүүр гялан”-гийн хадны оршуулгын олдворуудыг сэргээн засварлах явцад бид мөн 2015 оны 5 дугаар сард Монголын Үндэсний музейн эрдэм шинжилгээний ажилтан, доктор Ж.Баярсайхан ахлагчтай судалгааны багийнхны Ховд аймгийн Мянгад сумын “Цагаан булаг” багийн нутаг “Улаан үнээт” хэмээх газраас авран хамгаалах зорилгоор татан авчирсан хадны оршуулгын арьсан болон илгэн дээл, илгэн өмд, илгэн гутал зэрэг 4 олдворыг цэвэрлэх, бэхжүүлэх ажлыг хийлээ.

Мөн энэ цаг үед Үндэсний музейн сан хөмрөгөөс Урд улаан үнээт рхэмээх шгазраа олдсон арьсан болон илгэн эдлэлийн бохирдлыг хуурай аргаар цэвэрлэсний дараа эд өлгийн зүйлийг чийг өгөх зориулалтын материалаар хэсэгчилэн чийг өгч битүү бигнэж, арьсны хатаж хорчийсныг тэнийлгэв.



Амьтны үсийг гадагш харуулан хийсэн хүрэм нь доргоны арьс болохыг Байгалийн түүхийн музейн Чихмэлийн лабораторийн эрхлэгч Т.Дашбат тодорхойлсон байна. Арьсан хүрэмний үс он цагийн элэгдлээр өгөршилд орж суларч унасаныг органик гаралтай усан суурьтай цавуугаар нааж бэхжүүлэв.



“Улаан үнээт”-ийн арьсан хүрэмний суларч унасан үсийг нааж бэхжүүлэв.

Үзүүр гялангийн олдворуудын сэргээн засварлалтын ажлын явцын талаар 2 удаагийн эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавигдсан. 2017 оны 3-р сард ШУТИС дээр зохион байгуулагдсан “Монголын археологи- 2016” эрдэм шинжилгээний хуралд үл хөдлөх дурсгал хариуцсан мэргэжилтэн Г.Бүрэнтөгс хадны оршуулгын археологийн олдворууд болон сэргээн засварлалтын ажлын явцын талаар, 2017 оны 5-р сард “Хадан гэрийн соёл” үзэсгэлэнгийн үеэр сэргээн засварлагч Б.Мягмарсүрэнуг хадны оршуулгын эд өлгийн зүйлсийг сэргээн засварласан тухай танилцуулга илтгэлийг тус тус тавьжээ.



Монголын Үндэсний музейтэй хамтран 2017 оны 5-р сарын 3-наас 6-р сарын 6-ны өдрүүдэд “Хадан гэрийн соёл” үзэсгэлэнг тус музей дээр зохион байгуулсан. Үзэсгэлэнгийн үеэр эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж, эрдэмтэн судлаачдын хадны оршуулгын талаарх судалгаа шинжилгээний илтгэлүүд тавигдсан байна.





Үзэсгэлэнгийн үеэр Үзүүр гялангийн олдворуудын талаарх судалгаа шинжилгээ болон сэргээн засварлалтын ажлыг талаарх эрдэм судлаачдын бичсэн өгүүлэлүүдийг эмхэтгэсэн “Хадан гэрийн соёл” товхимол номыг 200 хувь хэвлүүлэн олон нийтэд тараалаа.

Дүгнэлт:

БСШУЯамнаас энэхүү олдворуудыг сэргээн засварлах, судлан шинжлэхэд ихээхэн анхаарч 8,000,0 төгрөгийн санхүүгийн асуудлыг цаг алдалгүй шийдэж өгсөн нь энэхүү “Үзүүр гялан”-гийн олдворуудын сэргээн засварлалтыг амжилттай гүйцэтгэхэд чухал дэмжлэг болсон.

№	Зарцуулалт	Төсөв
1	Ховдоос Улаанбаатарт авчирах томилолт, шатахууны зардал	2.648.0
2	Сэргээн засварлах материалын зардал	4.032.0
3	Хатмал шарилыг хадгалах хөргүүр	1.320.0
	Нийт зардал	8.000.0

“Үзүүр гялан”-гийн хадны оршуулгын онцлог нь эмэгтэй хүний өмсгөл дээл, хувцас анх удаа иж бүрэн байдлаар олдсон олдвор ба антропологи, археологи,

угсаатны зүйн чухал ач холбогдолтой энэхүү эд өлгийн зүйлсийг судлан шинжлэх ажил үргэлжилж байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон сошиал ертөнцөөр эсгий дотортой, урт арьсан түрий, арьсан ултай, хоншоор хэсэгтээ бор цоохор сүлжмэл даавуун оруулгатай, боомоороо металл товруу чимэг бүхий суран оосортой гутлыг спортын “Адидас” брэндийн гуталтай адитгасан мэдээлэл тархаж “Үзүүр гялан”-гийн олдворууд олны дунд хэдийнээ танил болсон билээ.

Он цагийн уртад өгөршиж хэврэгшсэн эртний түүхэн дурсгалт эд өлгийн зүйлсийг ирээдүй хойчисдоо өвлүүлэн үлдээхэд тэдгээрийг эрсдэх аюулгүй, агаарын чийг, дулаан, гэрэл гэрэлтүүлгийн тохиромжтой орчин нөхцөлд энэ хэвээр нь өнө удаан жил хадгалан, хамгаалахасуудал чухлаар тавигдаж байна.

Соёлын өвийн төвийн байр, өрөө тасалгааны орчин нөхцөл нь археологийн олдворуудыг хадгалахад тохиромжгүй, нийтийн халаалттай учир өрөөний температур, гэрлийг зохицуулах боломжгүй тул олдворуудхортон шавжид өртөх магадлал өндөр байна. Олдворуудыг ганц байгаа хөргүүртээ 7, 7 хоногоор ээлжлэн сэлгэж хадгалах арга хэмжээг авч байгаа боловч энэ нь хадгалалт, хамгаалалтыг бүрэн хангаж чадахгүй байна. Ялангуяа том хэмжээний эсгий, даавуун эдлэлүүд, хүний хатмал шарил, маламьтны хатмал яс, арьс үс зэрэг олдворуудыг тус тусад нь хөргүүрт байрлуулах, байнгын -5 хэм хүртэлх хуурай сэрүүн, гэрэл бага орчинд хадгалах нь тохиромжтой юм.

Иймд энэхүү “Үзүүр гялан”-гийн олдворуудыг эзэмших байгууллагын асуудал болон уг олдворуудыг цаашид муутгахгүй хадгалах хөргүүр зэрэг тоног төхөөрөмжийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

2. Орхон уул аймгийн Айргийн гозгорын археологийн малтлага, түүнээс илэрсэн олдворын цэвэрлэгээ бэхжүүлэлтийн ажил

Монголын Үндэсний Музейн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор Ц.Одбаатар ахалсан хээрийн судалгааны баг Хүннүгийн сүүлч Сяньбийн эхэн үед холбогдоно хэмээн тодорхойлж байгаа Айргийн гозгор /АГ/ 7 хэмээх дугаартай бунханы малтлагад тус төвийн СӨХСЗХэлтсийн сэргээн засварлагч Н.Бат-Эрдэнэ, С.Даваадарь нар 2017 оны 7 дугаар сарын 26-наас 8 дугаар сарын 02-ныг хүртэл 7 хоногийн хугацаатай томилогдон очиж ажиллав.

Археологийн малтлага явагдаж байх хугацаанд судлаач М.Оюунтулга Япон улсын Осака болон Кюүшүгийн институтийн судлаачидтай хамтран Япон улсын археологийн салбарт өндөр үр дүнтэй хэрэглэгдэж байгаа сахарын /TRENE / талаар болон малтлагын талбар дээр олдворын анхны төрх байдлыг алдагдуулахгүй байхын тулд сав баглаа боодлыг хэрхэн зөв хийх, хадгалалт хамгаалалтын талаар бодит жишээн дээр тулгуурлан сургалт явуулсан ба сургалтанд Өвөрхангай аймгийн Хархорум музей, Орхон аймгийн музей, Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейн төлөөллүүд оролцлоо.



Малтлагаас олдвор илрэх үед нарийн цэвэрлэгээ хийх, салгаж авах, уутлах, баглах, боох ажлыг газар дээр нь хийж гаргаж ууталсан метал эдлэлүүдээс анхан шатны цэвэрлэгээ хийж СӨТөвд хүргүүлэв.



СӨТ-д хүргэгдэж ирсэн малтлагаас илэрсэн нийт 110 орчим олдворуудаас 80 орчим модон олдворуудын цэвэрлэгээ, сахарын уусмалаар бэхжүүлэх ажил, 49ш металл, 9ш шавар ваар олдворуудын цэвэрлэгээ, бэхжүүлэлт хадгалалт хамгаалалтын ажлыг Япон улсын Нарагийн их сургуулийн хадгалалт хамгаалалтын хэлтсийн судлаач, доктор М.Оюунтулга болон Орхон аймгийн музейн ЭША М. Ганцэцэг, Улаанбаатар их сургуулийн төслийн туслах Б. Батчимэг, Хархорум музейн ахлах ЭША Б. Дэжидмаа, Сэргээн засварлагч Д. Даваадорж, ЭША Ж. Цамбагарав, туслах ажилтан Билгүүн нартай хамтран хийж гүйцэтгэж байна. Энэ ажлыг 2018 оны эхний улиралд багтаан дуусгах төлөвлөгөөтэй байна.

3. Ховд аймгийн Ховд сумын нутагт орших Хавцгайтын дэрстийн хөтөлд хийгдэж буй авто замын тэсэлгээнд өртөж гэмтсэн хадны зургийг нүүлгэн шилжүүлсэн ажил

Ховд аймгийн Ховд сумын нутагт орших Хавцгайтын дэрстийн хөтөл хэмээх газрыг дайран хийгдэж буй авто замын тэсэлгээний ажилд өртөж гэмтсэн хадны зургийг нүүлгэн шилжүүлэх, авран хамгаалах ажлыг Ховд аймгийн засаг даргын тамгын газар, НКВ International Holding компани, Соёлын өвийн төв /СӨТ/ хооронд гурвалсан гэрээ байгуулан хамтран ажиллахаар хэлэлцэж тохиролцов.

Улмаар уг авран хамгаалах ажлыг хийж гүйцэтгэхээр Соёлын өвийн төвийн Соёлын өвийг хамгаалах сэргээн засварлах хэлтсийн (СӨХСЗХ) дарга Д. Нямдорж, сэргээн засварлагч Н. Бат-Эрдэнэ нар 8-р сарын 11–ээс 20-ний хооронд 10 хоногийн хугацаатай Ховд аймагт томилогдон очиж аймгийн музей болон аймгийн засаг даргын тамгын газартай хамтарч ажлын хэсэг байгуулж ажиллав.

Соёлын өвийн төвөөс гарсан баг 8-р сарын 13 нд Ховд аймагт тус аймгийн Засаг даргын тамгын газрын төлөөллүүд, орон нутгийн музейн удирдлага болон НКВ International Holding компанийн орон нутагт буй төлөөллүүд болох Жан, Хангай нартай уулзалдав.

Ажлын хэсэг 8-р сарын 14 нд Ховд аймагт ерөнхий төлөвлөгөө, техникийн зөвлөгөө, ажлын бэлтгэлийг хангаж, улмаар дурсгалт газар очиж эхний гэрэл зургийн баримтжуулалт, хэмжилтийг хийв.




Дурсгалт газрын харагдах байдал

Уг хадны зураг нь Ховд аймгийн төвөөс хойд зүгт 28 км зайд байрлах ба Ховд сумын нутаг Хавцгайтын дэрстийн хөтөл хэмээх газар баруунаас зүүн тийш сунасан хөтөлийн үзүүр хэсэгт байх жижиг хадан толгой юм. Хадны зурагтай уг толгой хэсэг нь автозамын трассд орсны улмаас тэсэлгээний ажилд өртөж гэмтсэн ба зарим зурагтай хэсгүүд доргилтын улмаас үндсэн байрлалаа алдаж шидэгдсэн байв.

Эдгээр шидэгдэж үндсэн байрлалаа алдсан хэсгүүдийг нэмж гэмтэх, алга болох эрсдлээс урдчилан сэргийлэх зорилгоор аймгийн музейн ажилтнууд Ховд аймагт байх Өв соёлын хүрээлэнд урьдчилан хүргэсэн байв.

Газар дээрээ хөдлөлгүй үлдсэн хэсгүүдийг доорх байдлаар үндсэн 3 хэсэгт хуваан тус бүрд код, хэсэг дотор нь бүлэглэн дугаарлаж, байгалийн хагарал цуурлын дагуу хувааж, салгаж авсан ба салгаж авахдаа дурсгалд аль болох гэмтэл учруулхаас зайлсхийж гар багаж ашиглан, механик аргаар ажилласан ба жижиг хэсгүүдийг гар аргаар салгаж авсан бол томоохон үндсэн чулуулагтай холбогдсон хэсгүүдэд хөшүүрэг, гидр демократ болон зарим цахилгаан багажуудын туслалцаатайгаар зурагт хадыг хөдөлгөж салгаж авав.

1. Улаан зураасаар тэмдэглэсэн хэсэг – Т
2. Шар өнгөөр тэмдэглэсэн хэсэг – А
3. Хөх өнгөөр тэмдэглэсэн хэсэг - В



- Т – хэсэг дотроо Т-1 гэсэн код, дугаар бүхий нэг хэсэг
- А – хэсэг дотроо А-1, А-2, А-3, А-4, А-5 гэсэн код, дугаар бүхий 5 хэсэг
- В – хэсэг дотроо В-1, В-2 гэсэн 2 хэсэг тус бүрээс бүрдэнэ.
Т-хэсэг. Хэмжээ : урт-103см, өргөн -59см



А -хэсэг. Хэмжээ : урт – 257см, өргөн -150см

A-1



A-3

A-2



A-4

A-5



В-хэсэг. Хэмжээ : урт -131см, өргөн -90см

В-1



В-2



Дурсгалт газар дээр очиж ажилласан багийн бүрэлдэхүүнд :

Д. Нямдорж / СӨТ-ийн СӨХСЗХ-ийн дарга /

Н. Бат-Эрдэнэ / СӨТ-ийн СӨХСЗХ-ийн сэргээн засварлагч/

Х. Эрдэнэбаатар /Ховд аймгийн музейн захирал/

Х. Бямбасүрэн /Ховд аймгийн музейн эрдэм шинжилгээний ажилтан/

Б. Сүхбаатар /Ховд аймгийн музейн бүртгэл мэдээллийн санч/

Х. Батдорж /Ховд аймгийн музейн харуул/

Д. Цэнд-аюуш /Ховд аймгийн музейн харуул, жолооч/ нар байв.

Ажлын явцын гэрэл зургууд:



Салгасан зурагтай хаднуудыг зөөж тээвэрлэх ажилд бэлдэн жижиг хэсгүүдийг зөөлөвч зулхайгаар ороож хайрцаглав.

Гараар өргөх боломжгүй томоохон хэсгүүдийг өргөгч крантай автомашинаар өргөж тэвшин дээр байрлуулсан зөөлөвч дээр тавьж тээвэрлэн Ховд аймгийн Өв соёлын хүрээлэнгийн гадна талбайд хүргэв.



Уг хадны зураг бүхий дурсгалт газраас том хэмжээ бүхий 12 хэсэг чулуу мөн дагалдах жижиг хэсгүүдийн хамт Ховд аймаг дахь Өв соёлын хүрээлэнд хүргэгдэж очив.

Хадны зургийг салгах явцад зарим хэсгүүд дотроо олон жижиг хэсгүүдэд хуваагдаж салсан ба эдгээр хэсгүүдийг Өв соёлын хүрээлэнд хүргэсний дараа Ероху цавуугаар эвлүүлж наав.



Хадны зургийг олон нийтийн хүртээл болгох, хамгаалах, хадгалах зорилгоор Ховд аймаг дахь Өв соёлын хүрээлэнгийн гадна талбайд дурсгалд зориулан тодорхой өндөртэй тавцан бүхий тайз засаж байрлуулан хамгаалалтын саравч, хайс, талбай, гэрэлтүүлэг зэрэг тохижилтын ажил, мөн дурсгал оршиж байсан газарт танилцуулга самбар хийж байрлуулах зэрэг ажлыг гүйцэтгэхээр төлөвлөсөн ба уг ажлыг Ховд аймгийн музейн ажлын хэсэг хариуцан хийж гүйцэтгэхээр төлөвлөн ажиллаж байна.

Хадны зургуудыг байрлуулах болон орчны тохижилтын ажил хийгдэж гүйцээний дараа Соёлын өвийн төвөөс сэргээн засварлагч очиж тэсэлгээний улмаас үүссэн зарим гэмтлүүдийг засварлах шаардлагатай ба энэ ажлыг 2018 оны ажлын төлөвлөгөөнд тусгахаар төлөвлөж байна.

4. Дорнод аймаг Халх гол сумын нутагт орших “Их бурхант” дурсгалын сэргээн засварлах ажлын үр дүнг шалгах, цаашид хийгдэх үйл ажиллагааг тодорхойлох

Соёлын Өвийн Төвийн захирлын 2017 оны 05-дугаар сарын 29-ний өдрийн А/21 тоот тушаалын дагуу Дорнод аймгийн Халх гол сумын нутаг дахь “Их Бурхант” дурсгалын сэргээн засварлалт, ашиглалт, хадгалалт хамгаалалт зэрэгт үзлэг хийх зорилгоор 2017 оны 06-дугаар сарын 02-ны өдрөөс 4 хоногийн хугацаатай тус төвийн сэргээн засварлагч Н.Жамбал, С.Сайнзолбоо нар орон нутагт ажиллаа.

“Их Бурхант” цогцолборын сэргээн засварлалтын ажил хамгийн сүүлд 2015 оны 7-дугаар сарын 27-ны өдрөөс 2015 оны 8-дугаар сарын 15-ныг хүртэлх хугацаанд хийгдсэн ба уг ажлаас хойш 2017 оны 6-дугаар сар хүртэлх хугацаанд /22 сар/ сэргээн засварлалтын ажил түр зогссон нь чулуун хийцүүдэд ажиглалт судалгаа хийх боломж олголоо.



Тус цогцолборын гол бурхан Жанрайсиг болон бусад дагалдах бурхад, хоёр талын хэрмэн хананы өрлөг зэргийн өрлөгийн холбоос шавардлага, бурхадын хийц бүхий чулуунуудын хуучралт, өнгө будгийн гандалт зэрэгт ажиглалт хийж зургийг авч баримтжууллаа.

Нэг. Бурхадын шинэ болон хуучин чулуун хийцүүдийн хуучралт гадаргуугийн байгалийн хүчин зүйлсээс шалтгаалсан элэгдэл, өнгө гандалт Жанрайсиг бурханы лагшин, мутар, хөл, нигуур болон мутар дахь барьцнуудын



элэгдэл хорогдол /өнгөн хэсгийн үйрч бутрах явц/ харьцангуй бага боловч шинээр цахилгаан багаж ашиглан хэлбэр форум гаргаж хийсэн хийцүүд арай илүү элэгдсэн байдалтай байна.

Энэ шинэ чулуун хийцүүдийн өнгөний байгалийн хүчин зүйлсээс хамааралтай элэгдэл цаашид тодорхой түвшинд хүрээд зогсох төлөвтэй учир хоорондын холбогч шаврын үйрч сайрч унасан зайг аргын чулуун зуурмагаар холбож нэгтгэсний дараа суурь будалтуудыг хийх шаардлагатай гэж үзлээ.



Бурхант цогцолборын чулуун хийцүүдийн дорхи шинээр хийсэн хөрсний уллагаа-багсармал /шар шавар-бор шороон хөрс-шохой давсны холимог/-ны нягтруулсан байдал хэвийн хадгалагдсан байна./маш нягт, өндөр хатуулагтай/ Бурханы мөргөлийн тавцан дээрх Гонгор, Дүртэддагва, Аюуш бурхадын өнгө будаг мөн нийт 22 сарын хугацаанд өнгө бага зэрэг гандсан ба зарим деталл хэсгүүдийн чулууны өнгө багавтар газар /1см-10см/ 0,3-0,8см-н зузаантайгаар ховхорч унаснаас өнгө будаг мөн чулууны хамтаар дутаж харагдаж байна.

Будалтанд хэрэглэгдсэн эмульс, будаг, пигментүүд нь тогтоцын хувьд сайн, гандалт харьцангуй бага зэрэг нь цаашид сэргээн засарлалтанд ашиглаж болно гэж үзлээ.

Дээрх мөргөлийн тавцан дээрх бурхадын арын өрлөг түүний завсар зай, гол бурхан Жанрайсигийн лагшингийн чулуун хийцүүдийн хоорондын зайг /нар, салхи, борооны хүчин зүйлсээс үүдсэн/ шинэ аргын чулуун зуурмагаар дүүргэлт хийн нэгтгэсний дараа будалтыг хийх шаардлагатай.

Нарийн хийц бүхий хэсэг, хүчитгэсэн өрлөг бүхий хэсэгт чулууны цавуу ашигласан аргын чулуун зуурмаг, масстай талбай бүхий хэсэгт цагаан цемент, пигментийн оролцоотой аргын чулуун нөхөлт дүүргэлт хийх саналтай байна.

Хоёр."Их Бурхант"цогцолборын сэргээн засварлалтанд хэрэглэгдэж байсан цахилгаан багаж зарим тоног төхөөрөмжүүдийг буцаан татаж авчирлаа. Тус цогцолборын хажууд байрлах ХЦ-н 0198-дугаар ангийн тусгай салбар "Бурхант" заставын хуучин агуулахад хадгалуулж байсан эд зүйлсээс зарим багаж, тоног төхөөрөмжүүдийг татан авч, овор хэмжээ том зарим зүйлсийг /төмөр поошиг,тэрэг г.м/ буцаан хурааж баримтжуулан зургийг авч тус заставын жижүүрт хүлээлгэн өглөө. Дээрх ажилтай холбоотой зургуудыг хавсаргасан болно.

5. Говь-Алтай аймгийн Шарга сумын Халзан ширэг балгасын малталт

Нүүдлийн соёл иргэншлийн хүрээлэнгийн төслийн удирдагч А.Очирын удирдсан археологийн экспедицийн Говь-Алтай аймгийн Шарга сумын Халзан ширэг балгасын малталтанд тус төвийн СӨХСЗХ-ийн сэргээн засварлагч Н. Бат-Эрдэнэ 2017 оны 9 дүгээр сар 13 - 18ны хооронд томилогдож ажиллав.



Малталтаас түүхий шавраар хийж шохойн ланшингаар өнгөлсөн хөлний дүрслэл бүхий суурьтай баримлын хэсэг илэрч гарсан ба уг олдвор нь түүхий шавраар газар дээр нь барималдаж хийсэн тул маш эмзэг, хэврэг

олдвор байв.

Олдворыг нээн илрүүлж ил болгосны дараа механик цэвэрлэгээ хийж, Wacker OH 100 бэхжүүлэгчээр газар дээр нь бэхжүүлж тээвэрлэлтэд зориулсан сав баглаа боодлын ажлыг хийж гүйцэтгэн Соёлын өвийн төвд тээвэрлэн ирсэн ба хадгалалтын ажил хийж гүйцэтгэн хүлээлгэж өгөх юм.

Олдворын хэмжээ: суурийн урт 65 см, өргөн 30см, өндөр 50см

Уг дурсгалыг Wacker OH 100 бэхжүүлэгчээр 3 өдрийн хугацаанд өдрийн 3 удаагийн давтамжтайгаар бэхжүүлэлт хийв.

Тээвэрлэлтэд зориулан сав баглаа боодлыг хийхдээ эхлээд хүнсний скочоор ороож гадна талаар нь муутуу цаасаар бүрж гадна талаар нь эмнэлгийн зориулалттай марльтай гипстэй боолтоор ороон биежүүлсний дараа сууринаас салгахын тулд эргэн тойрон дахь газрыг 5см ухааж кардонон хашлага хайрцаг хийж

дотор талд нь полиуретан хөөс шахаж чигжрүүлж доргилтоос хамгаалах үе давхарга хийсний дараа газраас салгаж авч фанеран хайрцагт хийж зөөвөрлөв.

6. Археологийн хүрээлэнгийн сан хөмрөгт хадгалагдаж буй хосгүй үнэт хивс

Археологийн хүрээлэнгийн сан хөмрөгт хадгалагдаж буй хосгүй үнэт дурсгал болох хүннү хивс нь хадгалалтын явцад дундуураа нугалаа үүсэж тогтсон тул зохих хадгалалтын ажлыг хийж өгнө үү гэсэн хүсэлтийн дагуу Соёлын өвийн төвийн СӨХСЗХэлтсийн дарга Д. Нямдорж болон сэргээн засварлагч О.Оюунчимэг нар 2017 оны 11 дүгээр сар 30-ны өдөр газар дээр нь очиж нөхцөл байдалтай танилцав.

Уг дурсгал нь археологийн хүрээлэнгийн музейд хадгалагдаж байгаа бөгөөд хивсийг дэлгэхэд цаасаар бүрсэн зөөлөн зуйван голонд ороолттой байв. Холбогдох мэргэжилтнүүдийн хэлж буйгаар модон хайрцганд хадгалдаг байна.

Хэмжээ нь 271,5см х 153см хэмжээтэй, дэлгэж үзэхэд зүүн дээд булангаас 105см, зүүн доод булангаас 130см орчимд хөндлөн ташуу нугалаа үүссэн байв. Хивсэнд үүссэн нугалаа нь зөөлөн зуйван голонд ороож хайрцганд шууд өөр дээрээ ачаалал авхаар байрлалтай хэвтүүлж хадгалж байснаас үүссэн байж болох магадлалтай юм.





Хивсийг тэгшлэхэд тухайн ажлын орчинд том тавцан бүхий ажлын ширээ байхгүй байсан тул шалан дээр даавуу дэлгэж дээр нь тусгаарлах цаас дэвсэж дээр нь дурсгалыг дэлгэж чийг өгөхөд өнгө будгийн ямар нэг харвалт үүсэх эсэхийг чийгтэй уудаг цаасаар тестлэж үзэв.

Үүний дараа нугалаа үүссэн хэсгээс бусад хэсгийг тусгаарлах хамгаалалтын цаасаар бүрхэж нугалаа үүссэн хэсэгт нэрмэл усаар бага зэрэг чийг өгч тэнийлгэн дээрээс нь тусгаарлах цаас болон уудаг цаас дэвсэж хавтан болон хүндрүүлэгчээр даруулж 30 орчим минут тэгшилж амраасан ба үүний дараа дарсан хүндрүүлэгч болон хавтан, цаасыг авч нугалаа тэнийсэн эсэхийг шалгаж үзэв.

Үүссэн байсан нугалаа хунираа харьцангуй тэгширч багассан байсан ба нугалаатай хэсгийг дахин тэнийлгэж бага зэрэг нэрмэл усаар шүршиж дахин бага зэрэг чийг өгч мөн нугалаатай хэсэгт дахин тусгаарлах цаас болон уудаг цаас, хавтан, хүндрүүлэгч зэргээр дарж орхив. Хэсэг хугацааны дараа хивсийг очиж үзэхэд үүссэн хунираа бага зэрэг бүдгэрсэн боловч бүрэн арилаагүй байсан ба мөн түрүүчийн адил бага зэрэг чийг өгч эргүүлэн даруулж орхив.



Соёлын өвийн төвийн сэргээн засварлагч О. Оюунчимэг, Г. Ууганчимэг СӨХСЗХэлтсийн дарга Д. Нямдорж нар ареологийн хүрээлэнгийн музейд очиж хивсийг тэнийж тэгширсэн эсэхийг дахин очиж шалгасан ба хивсэнд үүссэн хунираа арилж тэгширсэн байв. Иймд урьдчилан захиж бэлдүүлсэн материалаар хивсэнд зориулсан шинэ хуйлж хадгалах голыг хийв.



Ингэхдээ 100мм -ийн PVC голыг зөөлөн хөвөн зузаалгатай даавуун материалаар ороож зузаалан, гадна талаар цуу ямбуу даавуугаар давхар ороож даавууны захыг оёж битүүлэн ороох голыг бэлдсэн ба үүндээ тэнийж тэгширсэн хивсний 2 талд хүчил шүлтгүй цаасаар жийрэглэн жигд таталттай ороон хуйлж гадна талаар цуу ямбуу даавуугаар зөөлөн ороож хадгалалтад бэлдэв.

Энэ ажлыг хийх явцад Түүх, археологийн хүрээлэнгийн сэргээн засварлагч Эрдэнэцэцэг, Нандинцэцэг нар байлцав.



Уг дурсгалыг цаашид энэ байдлаар хадгалах нь эрсдэлд оруулж болзошгүй тул тэгш планцет дээр дэлгэж зохих хамгаалалт хийж хадгалах нь зохимжтой юм. Энэ байдалд хадгалж буй хугацаанд тогтсон 2 сарын хугацаанд тогтмол дэлгэж шалгаж байх шаардлагатай байна.

7. Монголын урчуудын эвлэлийн уран сайхны фондод хадгалагдаж буй уран бүтээлүүдийн сэргээн засварлалт

Монголын урчуудын эвлэлийн уран сайхны фондод хадгалагдаж байгаа сэргээн засварлах шаардлагатай уран баримал 70ш, керамик 20ш, эсгий 4ш, сийлбэр 25ш бүтээлүүдийн сэргээн засварлах ажлын хугацааг доорх хүснэгтийн дагуу хийж гүйцэтгэхээр төлөвлөн ажиллаж байна.

Сэргээн засварлах хугацаа

№	Бүтээлийн төрөл	Тоо ширхэг	Ажиллах сэргээн засварлагч	Ажиллах хугацаа	
				2017/9	2018/2
1	Баримал	70	2	Баримал	Баримал
2	Керамик	20	1	Керамик	
3	Эсгий	4	1	Эсгий	
4	Сийлбэр	25	1	Сийлбэр	Сийлбэр
	НИЙТ	119ш	6	50ш	69ш



Одоогийн байдлаар уран баримал, уран сийлбэр, керамик эдлэлийн нийлсэн 50ш үзмэрийг хүлээж аван сэргээн засварлах ажил хийгдэж байгаа ба сэргээн засварлалтын ажил дууссан бүтээлүүдэд хайрцаг баглаа боодол хийн эргүүлэн хүлээлгэж өгөхөд бэлэн болоод байна.

8. Шинжлэх ухааны академийн Физик техникийн хүрээлэнтэй хамтын ажиллагааны санамж бичиг үйлдэж хамтын ажиллагаа тогтоов

Энэ 2017 онд 10-р сарын 13-ны өдөр Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны харъяа Соёлын өвийн төв, Шинжлэх Ухааны Академийн Физик, техникийн хүрээлэн нар хамтран соёлын өвийг сэргээн засварлахад материал судалгааны чиглэлээр хоёр талын цаашдын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд эрх тэгш болон түншлэлийн зарчимд тулгуурлан Санамж бичгийг байгуулав.

Санамж бичгийн зорилго

Түүхэн тодорхой орон зай, цаг үеийн түүх, соёл, урлаг, уран сайхан, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдол бүхий соёлын өвийн материал, шинж чанарын судалгааг хамтран зохион байгуулах.

Хамтын ажиллагааны чиглэл

- Соёлын биет өвийн сэргээн засварлалтад хэрэглэгдэх химийн бодисийн аюулгүй ажиллагаа
- Соёлын өвийг хадгалан хамгаалах орчин үеийн нанотехнологийн аргууд
- Соёлын өвийг судлах орчин үеийн техник, зарим материалын судалгааг хөгжүүлэх.
- Судалгааны ажлын үр дүнг соёлын өвийн сэргээн засварлалтад нэвтрүүлэх.
- Соёлын биет өвийн судлагдахууны төрөл зүйл, цар хүрээг тогтоох, тодорхойлолт гаргах, судалгаа хийх,
- Хамтарсан судалгааны төсөл хэрэгжүүлэх, төслийн ажилд судлаач, зөвлөхийн үүрэгтэй оролцох,
- Хамтарсан сургалт, семинар зохион байгуулах,
- Олон нийт, нийгэмд хандсан үйл ажиллагаанд хамтарч ажиллах.
- Хамтын ажиллагааны хүрээнд их дээд сургуулийн оюутнуудыг дадлагжуулах, залгамж халаагаа бэлтгэн боловсруулах чиглэлээр дараах чиглэлд хамтран ажиллана. Үүнд:
- Соёлын өвийн эрдэм шинжилгээний судалгаа, хадгалалт, хамгаалалт болон сэргээн засварлах ажилд оюутан суралцагсдыг хамруулан дадлагажуулах,
- Археологийн олдворуудыг сэргээн засварлах ажилд хамтран ажиллах.

-х-

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Үндэсний төв нь 2017 оны үр дүнгийн гэрээнд тусгагдсан соёлын биет ба биет бус өвийн бүртгэл баримтжуулалт, сэргээн засварлалтын ажлуудыг бүрэн ханган биелүүллээ. Ажлын гүйцэтгэлд ажилтнуудын ажлын ачаалал болон цаг, улирлын байдал шалтгаалсан хэдий ч дотоод нөөц бололцоо, мэргэжилтэнгүүдийн хүчин чармайлтаар үр дүнгийн гэрээт ажлуудыг амжилттай хийж гүйцэтгэсэн.

Үндэсний төвийн хүний нөөц, боловсон хүчний тухайд :

- Соёлын өвийн судалгаанд байгаль орчныг зайнаас тандан судлал ба газар зүйн мэдээлийн системийн мэргэжилтэн;
- Дэлхийн өвийн асуудал хариуцсан мэргэжилтэн;
- Сэргээн засварлагч;
- Сэргээн засварлалт, хадгалалт хамгаалалтын технологийн мэргэжилтэн;
- Архивч мэргэжилтэн (СӨУНБМСангийн цаасан болон цахим хэлбэрийн бүртгэл, мэдээллийг архивын горимын дагуу бүртгэх, товъёогжуулах, тохиромжит орчин нөхцлийг бүрдүүлэн хадгалж хамгаалах) зэрэг дутагдалтай байгаа ажилтны орон тоог эн түрүүнд нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Соёлын биет өвийн хүрээнд.

Соёлын өвийн бүртгэл баримтжуулалтад 3D хэмжээст технологи ашиглалтыг өргөжүүлэхэд мэргэжлийн тоног төхөөрөмж болон мэргэжлийн боловсон хүчний нөөц хомс байгаа, тэдгээрийг бэлтгэх, мэргэшүүлэн сургах асуудал чухал байна.

Соёлын биет бус өвийн хүрээнд:

Соёлын биет бус өвийг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, хадгалах хамгаалах чиглэлээр төрийн бус байгууллага, иргэдтэй хамтын ажиллагааг идэвхжүүлэх, өрнүүлэхэд төсөв мөнгөний асуудал дутагдалтай байсаар байна.

Сэргээн засварлах ажлын хүрээнд:

Тухайн жилд сэргээн засварлуулахаар хүсэлт гаргасан үзмэр, эд өлгийн зүйлсээ музейнүүд цаг хугацаа оройтуулан ирүүлж байгаа нь сэргээн засварлалтыг хугацаанд нь дуусгахад нөлөөлж байгаад анхаарах хэрэгтэй байна.

Цаашид Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газар, улсын болон аймгийн музей, Соёлын өвийн үндэсний төв зэрэг газрууд үр дүнгийн гэрээг батлагдахаас өмнө соёлын өвийг бүртгэн баримтжуулах, хадгалж хамгаалах, сэргээн засварлах чиглэлээр ирэх жилд хийгдэх ажлын талаар хамтран санал солилцон, зөвлөлдөн, үр дүнгийн гэрээнд захиалгат ажил, бүтээгдэхүүнийг тусгаж байх хэрэгцээ шаардлага байна.

-х-